

Г.Бямбацэрэн, Г.Болормаа  
Б.Лхамноржмоо, В.Хажидмаа

# МОНГОЛ ХЭЛ



Ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
M-692

Монгол хэл II: Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангийн сурах бичиг. /  
Бямбацэрэн Г., ба бус; Ред. Лхагвасүрэн О. -УБ. 2014. -152х./

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-21-5





## ДҮҮ НАРТАА



Уншиж, бичиж сурсан дүү нартаа баяр хүргэе! Хурдан, зөв уншаад ойлгодог, ойлгосноо илэрхийлэх, мэндчилгээ, талархал бичихэд чинь энэ ном тусална. Та нар чадна.

Зохиогчид

## ТАНИХ ТЭМДГҮҮД



Уншаарай



Яриарай



Бичээрэй




Сонсоорой




Сэтгээрэй



Багшийг сонсоод бичээрэй.



Нүдлээрэй



Үгийн тайлбар



## II АНГИЙН СУРАГЧДЫН ЭЗЭМШИХ ЧАДВАР

Бүлэг сэдэв	Дэд сэдэв	Унших чадвар	Ярих- сонсох чадвар	Бичих чадвар	Хэл зүй үгийн сан	Нүүр
1	Бүлэг ажилгүрээ	Эцэгийг ялган зөв унших. Богино, урт, хос эгшиг бүхий үгсийг харьцуулан зөв унших. Гийгүүлэгч авиаг эгшигт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгч гэж ангилан нүдэлж тогтоох зөв дуудах. Эхийг зөв, тод, чанга унших. Тулгуур дохиог ойлгож унших.	Ойлгосноо илэрхийлж ярих. Эцэгийг гийгүүлэгчийн ангиллыг тоочин хэлэх, сонсоод тогтоох.	Цагаан толгойн үсийг эгшиг, гийгүүлэгч гэж ангилахын зэрэгцээ эгшиг авиагаа урт, хос, богино эгшиг гэж ангилж бичих. Эцэгийн ангилалд тулгуурлан үгсийг эр эм үг гэж бүлэглэж бичих.	Эцэгийг, гийгүүлэгч авианы ангилал Эр үг, эм үг	6-9
2	Бүлэг ажилгүрээ	Дасгалын зааврыг өөртөө болон бусдад тод чанга, ойлгож унших. Эхийг төлөөлөн унших.	Шүлгийг цээжилснээ тод чанга илэрхийлэх. Зааврыг ойлгосноо харилцан яриагаар илэрхийлэх.	Зааврын дагуу дэвтрээ хаяглаж сурах. Өгөгдсөн зааврын дагуу эр эм үгийг ялгах, бүлэглэн бичих Зааврын дагуу тэмдэглэгээ хийж сурах, үсэг, үг нөхөж бичих. Өгөгдсөн үг ашиглаж зааврыг хамтарч зохиож бичих. Зааврын дагуу үгийн сүлжээ бөлгөж бичих. Асуултад харилуулж бичих.	Дэвтрэ хаяглахдаа аймаг сум, хүний нэрийг томоор бичих. Урт хос эгшигтэй үгийг сонсоод зөв бичих. -ыг, -ийг, залгавартай үгийг нүдэлж тогтоож бичих. Асуу, хүүрнэх өгүүлбэрт тэмдэг тэмдэглэгээ сонгож хэрэглэх.	10-12
		Тоглоомын зааврыг ойлгож унших. Эхийг зааврын дагуу хурдан зөв, ойлгож унших. Үгийн утгыг эхээс таамаглаж унших. Төлөөлөн унших.	Зураг ажилгаад харилцан ярих. Тоглоодоо харилцан яриа өрнүүлэх. Мэдээллээ бусдадаа ярих. Төлөөлөгөөний дагуу ярих. Тоглоомын үг хэллэг ашиглаж ярих.	Зураг ажилгаад харилцан ярих. Тоглоодоо харилцан яриа өрнүүлэх. Мэдээллээ бусдадаа ярих. Төлөөлөгөөний дагуу ярих. Тоглоомын үг хэллэг ашиглаж ярих.	Зааврыг хэрхэн ойлгосноо илэрхийлж ярих. Ярих төлөвлөгөө зохиох. Чухал мэдээллийг сонгож ярих.	Болсон явдлаа бичихдээ төлөвлөх, ярих, бичих, сайжруулах алхмын дагуу бичих. Асуултад харилуулж бичих. Зааврын дагуу тайлбарлан бичих. Болсон явдлаа бусдад илэрхийлснээ үнэлж бичих.
3	Болсон явдлыг ярьж, бичиж сурья	Эхийг хурдан ойлгож унших. Тодорхой хэсгүүдийг сонгож унших. Ойлгохгүй үгийг тэмдэглэж унших. Үйл явдал бүхий зураг унших. Эх дэх үгийг багцлан харж унших хурдаа нэмэх.	Зургийг ажиглаад үйл явдлын дагуу ярих. Сайн муу үйлийг ялгаж, дүгнэж ярих. Асуултын дагуу бүтэн өгүүлбэрээр ярих. Тулгуур үгийг ашиглан болсон явдлыг ярих.	Болсон явдлаа бичихдээ төлөвлөх, ярих, бичих, сайжруулах алхмын дагуу бичих. Асуултад харилуулж бичих. Зааврын дагуу тайлбарлан бичих. Болсон явдлаа бусдад илэрхийлснээ үнэлж бичих.	Эцэгийг гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгчийг ялгах, бүлэглэх.	27-32
4	Тайлбар толь бичиг ашиглаж сурья	Танил бус үгээ тэмдэглэж унших. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас, толь бичгээс утгыг уншиж мэдэх. Шүлгэн эхийг утгацлан унших. Зургийг ойлгож унших. Эхийн дүрийг харьцуулж унших. Уншлагын хурдаа тэмдэглэх.	Танил бус үгээ хэрхэн таамаглаж буйгаа бусдад ярих. Эхийг уншаад ойлгосноо ярих. Ижил сэдэв бүхий эхүүдийг дүрээр нь харьцуулан ярих.	Танил бус үгээ таамаглан бичих. Толь бичгийн тайлбар бичих. Асуулт зохиож ярьж бичих. Тодорхой сэдэвээр үгийг бүлэглэж бичих. Дүрийн шинж байдал, зан төлөвийг харьцуулан бичих.	Амьтанд оноож өгсөн нэрийг томоор бичих.	33-39
5	Танилцуулга ярьж, бичиж сурья	Танилцуулга зааврыг ойлгож унших. Эхийг ойлгож унших. Гэр бүлийн танилцуулга, товч анкет, заавар зэргийг унших, агуулга бүтцийг уншиж ойлгох.	Өөртөө итгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу ойлгомжтой тод дуугаар илэрхийлэх. Гэр бүл, өөрийгөө болон найз нөхдийгөө танилцуулах	Зааврын дагуу танилцуулга бичих. Товч анкет бөлгөж бичих. Найзынхаа танилцуулгыг загварын дагуу бичих.	Овог нэр, гэрийн хаягаа зөв бичиж сурах. Эх бичихдээ үгээ зөв сонгох, том үсгээр бичих.	40-44
6	Мэндчилгээ талархал ярьж, бичиж сурья	Мэндчилгээ бичих зааврыг ойлгож унших. Эхийг уншихдаа давтамжтай үгийг тогтоож унших.	Мэргэжлийн тухай харилцан яриа өрнүүлэх.	Талархал, мэндчилгээний агуулга, бүтцийг тайлбарлах.	Эр, эм үгэнд -ы, -ий залгаврыг зөв бичих	45-48
					Эх зохиож бичих. Засварлах, сайжруулах.	49-55

7	Төсөөлөн ярьж бичих	Эх дэх үгийг орчноос нь таамаглан нөхөж унших. Ойлогж унших. Эхийг хурдан унших.Бүтээлчээр давтан унших. Зохиолын баатар, үйл явдлыг төсөөлөн унших.	Хэрхэн төсөөлснөө илэрхийлэх. Асуултын дагуу ярилцах. Чухал мэдээллийг тайлбарлах.	Зохиолын баатар, үйл явдлыг төсөөлөн бичих. Сонгож хуулан бичих. Талархал бичих. Асуултаар үг сонгож бичих.	Асуусан, хүүрнэсэн өгүүлбэр. Өгүүлбэрийн цэг тэмдгийг сонгон бичих.	56-68
8	Ертөнцийн гурван уншиж зохионогч	Ертөнцийн гурвыг ойлгож унших. Дарааллын дагуу уншиж тогтоох. Зүйр цэцэн үг, ертөнцийн гурвыг харьцуулан унших	Ертөнцийн гурвын утгыг тайлбарлах. Ертөнцийн гурвын бүтцийг тайлбарлах. Харилцан ярих. Тайлбарлан ярихдаа толь бичиг ашиглах.	Хуулж бичих. Бүтцийг гаргаж бичих. Тулгуур үгийг ашиглан найруулж бичих. Загварын дагуу зохиож бичих. Тайлбарлан бичих.	Зөв бичих	69-74
9	Онцлого	Онцлого таах алхмын дагуу онцлогын утгыг таамаглан унших. Зурган эхийг ойлгон унших.	Онцлогын утгыг тайлбарлан ярих. Онцлого таалцах.	Онцлогыг хуулж бичих.		75-77
10	Утга ялгасан дарааллыг ойлгож унших	Хурдан тод, ойлогж унших. Шүлгийг уншихдаа дууны өндөр намыг тохируулж унших. Эхийн үйл явдлыг урьдчилан таамаглах. н.г-тэй үгийг зөв унших. Зургийг ажиглаад төсөөлөх. Эхийн бүтцийг зааглаж унших. Сонгож унших, давтан унших.	Онцлогыг таамаглан ярилцах. н.г-тэй утга ялгасан үгийн утгыг тайлбарлан ярих. Эхийн утгыг асуултын дагуу тайлбарлан ярих. Үгийг утгыг харьцуулан ярих. Асуултаар үгийг бүлэглэн ярих	Үгийг нүдэлж цээжээр бичих. Эхийн хэсгүүдэд асуулт зохиох, асуултад харуулж бичих. Үгийн утгыг харгалзуулан бичих. Зургаар эх зохиож бичих. Төсөөлөн бичих. Үйл хөдлөлийг эрэмбэлж бичих	Утга ялгасан үгийг зөв уншиж бичих	78-97
11	Үйл явдлыг зөв хэрэглэж унших	Харилцан яриаг ойлгож унших. Зургийг үйл явдлын дарааллаар ойлгож унших. Асуух өгүүлбэр, хүүрнэх өгүүлбэрийг аялгаар нь ялгаж зөв унших. Төлөөлөн унших.	Харилцан яриа өрнүүлэхдээ аялгаа тохируулан ярих. Тоглоом толгоодоо харилцан яриа ашиглах. Үгэн тоглоом ашиглах.Зугаа үгийг ярианд ашиглах.	Өгүүлбэрүүдийг аялгаар нь хувирган цэг тэмдгийг ашиглаж зөв бичих. Үгэн толгоомын үг хэллэгийг гүйцээн бичих. Үг, тэмдэг тэмдэглэгээ нөхөж бичих.	Өгүүлбэрийн цэг тэмдгийг зөв бичих	98-105
12	Цэг тэмдгийг зөв хэрэглэж унших	Уншигаа таамаглах. Үгийн тоог нэмж хурдан, ойлогж унших. Эхээс сонгож унших. Харьцуулан унших.Цээжилсэн шүлгээ илэрхийлэх унших, дүрд толгох.	Хэрхэн таамагласнаа тайлбарлах. Зураг уншаад таамагласнаа ярих. Дүрийн төрх, үйл хөдлөлийг хэрхэн таамагласнаа тайлбарлах.	Баатруудыг яриаг гүйцээн бичих. Үгийг дэлгэрүүлж бичих. Тулгуур үгийг ашиглан таамаглан бичих, нөхөж бичих.Алдааг засаж бичих.	Оноосон нэрийг том үстээр бичих.	106-118
13	Үг ялгасан мөрд шилжүүлбэр	Тэмдэглэгээ хийж унших. Ойлогж унших. Сонгож унших. Төсөөлж унших. Үйл хөдлөлийн дарааллын дагуу унших, төлөөлөн унших. Дармал болон бичмэл эхийг харьцуулан унших.	Мөрд шилжүүлэн бичсэнээ тайлбарлах. Үгийн утгыг хэрхэн таамагласнаа тайлбарлах.Эхийг сонсож ойлгох.	Сонгон, хуулан бичих. Мөрд шилжүүлэн хуулан бичих. Нүдэлж бичих. Бичмэл эхээс хуулан бичих, Үйл явдлыг дарааллын дагуу эрэмбэлэн хуулж бичих.	Үеэр тасалж мөрд шилжүүлэх	119-127
14	Эсрэг утгатай үг	Эхийг ойлгож унших. Толь бичиг ашиглан сонгож унших. Үгийн утгыг ялган унших.	Үгийн утгыг тайлбарлах. Амьтны зан төрх, шинж байдлыг тоочин ярих.	Үгийн эсрэг утгыг нөхөж бичих. Утгыг тайлбарлан бичих. Эсрэг утгатай үгийг өгүүлбэр болон эхэд хэрэглэх.	Эсрэг утгатай үг	128-131
15	Зохиож ярьж бичих	Эхийг таамаглаж унших. Эхийг ойлгож унших. Цээжилсэн илэрхийлж унших.	Эхийг сонсоод ойлгосноо илэрхийлэх, харилцан ярилцах. Зохиож ярих, сонсох. Ярих үйлээ төлөвлөх. Төлөвлөгөөний дагуу ярих.	Үлгэр, зохиолын хэсгийг таамаглан зохиож бичих.Бичсэнээ засаж дахин хуулж бичих. Талархал мэндчилгээ зохиож бичих. Шүлэг дуурайн бичих, үг өгүүлбэрийг дэлгэрүүлж, нөхөж бичих. Загварын дагуу зохиож бичих. Бичих үйлээ төлөвлөх. Төлөвлөгөөний дагуу бичих.	Зөв бичих. Эх зохиож бичих.	132-152


# ҮСГЭЭ БҮЛЭГЛЭЖ, АНГИЛЖ СУРЪЯ

1. Цагаан толгойн үсгүүдээ уншаад, цэвэр сайхан бичээрэй.



Аа / Ёё / Вв / Тт / Дд / Ее / Ёё / Жж / Зз /  
 Уу / й / Кк / Лл / Мм / Нн / Оо / Өө /  
 Тт / Рр / Сс / Тт / Чч / Чч / Рр / Хх /  
 Чч / Чч / Шш / Шш / ь / ы / ь / Э / Юю / Яя

2. Туулайд туслаарай.



3. Ярилцаад бичээрэй.

а о у	и	-ий
э ө ү		-ы



ай ... ..


4. Уншаад ярилцаарай.

а, э, и, о, у, ө, ү  
 аа, ээ, ий, оо, уу, өө, үү, ий, ы  
 ай, эй, ой, уй, үй



1. Өнгөөр ялгасан үгсийг түүж бичээд ярилцаарай.

**Насны багад эрдэмд шамдвал**  
**Залхуугүй бол нэн сайн**  
**Н, .....**



2. Эгшиг, гийгүүлэгчийг ялган бичээрэй.



Цоожоо засаад  
тушаачих

о, а, .....

ц, ж, .....



**Монгол баавар**



о .....

м .....

3. Үгсийг уншаад төгсгөлийн гийгүүлэгч ямар ялгаатайг ярилцаарай.



ард  
амт  
аалз  
угж


болоход  
амтат  
лааз  
багаж

өвс  
түлш  
цамц  
товч  
торх

хавтас  
тохош  
бүтэц  
хоточ  
торох




4. Ажиглаад тогтоогоорой.



Эгшигт гийгүүлэгч  
дандаа эгшигтэй  
бичигддэг гийгүүлэгч

Заримдаг гийгүүлэгч заримдаа эгшигтэй,  
заримдаа эгшиггүй бичигддэг гийгүүлэгч



5. Үгсийг уншаад бүлэглэн бичээрэй.

хэрэм, тах, газар, оньс, цас, овоо, дах, мойл, усч, хүүхэд, эмгэн, бичиж, зэс, тотго, ширээ, утас, засжээ, гавар, бамбар, бас, морь, цээжтэй, ном, самбар, ургана, хасаж, чинжүү, уруул, аав.

13 үг

Дан эгшигт гийгүүлэгчтэй үг	Дан заримдаг гийгүүлэгчтэй үг
овоо, магнай, .....	тах, цас, .....

6. Бичигдээгүй ямар ямар үг үлдсэн бэ? Ярилцаарай.



1. Дараах үгсийн эгшгийг урт, хос эгшгээр сольж бичээрэй.



сар - саар - сайр  
хав - ..... - .....  
хах - ..... - .....

хул - ..... - .....  
ав - ..... - .....  
ул - ..... - .....




2. Үг бүтээж уншаад бүлэглэн бичээрэй.

и	ээ	а	ах	а	уу
н			в	с	
у	аа	э	эр	у	аа

эр үг	эм үг
.....	.....
.....	.....

3. Үгсийг зөв дараалалд оруулан зүйр үг бүтээж, тодруулсан үгийг ярилцаарай.



4. Шүлгийг тод, чанга уншаарай.

5. Шүлгээс загварын дагуу үгийг бүлэглэн бичээрэй.




**Би**  
Би хэдий бяцхан боловч  
Бичиг үсэг мэднэ  
Оюун билиг хоёроороо  
Ухаан эрдмийг судална  
Үнэн зориггоо зориглон  
Үргэлжийн авьяасаа нээгдүүлж  
Сурагчийн үүргийг хүлээгээд  
Сургуулийн сахилгыг журамлана.  
*Ц.Цэдэнжав*


а .....  
аа .....  
ай .....  
ий .....  
ы .....

6. "Би" шүлгийг дэвтэртээ бичихдээ ЭГ-ийг цэнхэр, ЗГ-ийг ногоон өнгөөр ялган будаарай.


7. Урт эгшгийг нөхөж бичээд тогтоогоорой.



8. Нүдлээд бичээрэй.



1. Тулгуур дохиог ойлгож уншаад ярилцаарай.



2. Тохирох туслах эгшигийг нөхөж бичээрэй.

Юм .мыг сонирхож суудаг  
 Сониуч хүүхэд олон байдаг .м  
 Ёс учир нь .у вэ?  
 .рөөл бэлгэ нь юу вэ?  
 Яагаад ..гаад гэсэн асуултаар  
 Ярилцаж тэд учрыг таньдаг юм.

3. Дараах үгийг бүлэглэн бичээрэй.

ерөөл, хүүхэд, ёс, юмыг, ярилцаж, сониуч, юм, яагаад, юу, бэлгэ

Үлгэрлэвэл:

эр үг юмыг, ...

эм үг хүүхэд, ...

Өөрийгөө үнэлээрэй. Илүү сайн бол ✨ ✨ сайн бол ✨ сурмаар бол ♥ зураарай.


Эгшгээ ялгаж сурлаа.	
Эгшигт гийгүүлэгчээ мэдлээ.	
Заримдаг гийгүүлэгчээ мэдлээ.	

# ЗААВРЫГ ОЙЛГОЖ УНШААД, ДАГАЖ МӨРДЬЕ



## 1. Зургийг ажиглаад ярилцаарай.

- Хэн ямар хичээл хийх боломжтой вэ?
- Чи хичээлдээ явахдаа цүнхэндээ бүх дэвтэр, номоо авч явах уу?
- Өнөөдөр ямар ямар хичээл орох вэ?



Хичээлдээ юу юу  
авч явах вэ?

Миний цүнхэнд  
бүгдээрээ  
багтахгүй  
байна аа.



## 2. Туулайд хэн яаж туслах вэ? Төлөөлөн уншаад ярилцаарай.

**Бат:** Өдөр бүр орох хичээлээ ялгаарай.

**Туяа:** Яаж ялгах юм бэ?

**Бат:** Хичээлийн хуваарь гэж байдаг шүү дээ!

**Туяа:** Аа, мэдлээ. Хичээлийн хуваариа өдөр бүр  
ашиглаж байя.

**Бат:** Өнөөдөр мягмар гараг. Тиймээс цүнхэндээ энэ  
өдөр орох хичээлээ ялгаж хийнэ.





**МЯГМАР**



- Математик
- Хүн орчин
- Монгол хэл
- Дүрслэх урлаг



1. Зургийг ажиглаад үсэг нөхөж хичээлийн хэрэглэлийн нэрийг зөв бичиж сурцгаая.



2. Хичээлийн хэрэглэлийн нэрийг загварын дагуу бүлэглээрэй.



3. Цүнхээ нээгээрэй.

- Хэдэн тасалгаа байна вэ?
- Аль тасалгаанд юу хийж болох вэ?

Зөвлөгөө:

- ✓ Цүнхээ цэвэрхэн байлга.
- ✓ Хичээлийн хэрэглэлээ гамтай хэрэглэ.
- ✓ Цүнхний тасалгаа бүрийг зориулалтаар нь ашигла.



4. Хичээлийн хуваарьтай танилцаад цүнхэнд юу орохыг тэмдэглээд ✓, бичээрэй.

- ЛХАГВА**
- Монгол хэл
  - Монгол хэл
  - Математик
  - Хүн орчин



5. Шүлгийг тод, чанга уншаад, цээжлээрэй.


**Дэлхийг би үүрч явна**

Үүр|гэв|чит шинэхэн цүнхэнд минь  
 Үзэг, харандаа, ном, дэвтэр  
 Үзтэл бүгд бүрэн бий  
 Үзэж сонирхох бүх юм бий  
 Газар дэлхий хүн амь|тан|тай|гаа  
 Гадаад далай хүчит да|вал|гаа|тай|гаа  
 Улс гүрэн хот тосгонтойгоо

Уудам нутаг мал сүрэгтэйгээ  
 Сурах бичгийн минь хуудсанд байдаг юм  
 Сурагчийн цүнхэнд минь багтаж явдаг юм  
 Эрдэм ном цүнхэнд минь байна  
 Дэлхийг би үүрч явна  
 Дэн|хий|тэл даагаад алхаж явна

Н.Доржсүрэн

1. Ажиглаад ярилцаарай.



Монгол хэлний хичээлийн дэвтэр байна.



Ямар хичээлийн дэвтэр вэ?




- ПҮРЭВ**
- Монгол хэл
  - Математик
  - Хүн орчин
  - Биеийн тамир

2. Үг нөхөж бичээрэй.

**Монгол хэл**

..... аймаг, (хот) ..... сум,  
 (дүүрэг)- ийн бүрэн дунд ..... сургуулийн ..... ангийн сурагч  
 .....

3. Дэвтрээ өөрөө хаяглаарай.



4. Зөвлөгөөг хуулж бичээрэй.


Баллахгүй, цэвэр нямбай бичье.

Нэг өнгөөр бичье.

Харандаа, шугам ашиглая.

Хавтастай байлгая.

Бүрэн хаяглаж байя.




туслах эгшиг  
я, ё, е, ю, ы, й



# ТОГЛООМЫН ЗААВРЫГ УНШААД, ДАГАЖ МӨРДЬЕ

## 1. Уншаад, цээжлээрэй.



Морь буугаарай. Молор эрдэнэ минийх болог.



Хонь буугаарай. Холбоо дүүрэн хонь минийх болог.



Ямаа буугаарай. Сав дүүрэн саальтай болог.



Тэмээ буугаарай. Тэрэг дүүрэн ноостой болог.



## 2. Шагай шившсэн бэлгэдлийн үгээ цээжээр бичээрэй.

Морь ..... молор эрдэнэ минийх болог.  
 ..... холбоо дүүрэн хонь минийх болог.  
 Ямаа буугаарай ..... болог.  
 .....

### Уншихдаа:

- Цэгт хараагаа төвлөрүүлэн унших
- Толгойгоо хөдөлгөлгүй нүдээ гүйлгэн унших

## 3. Шүлгийг хурдан, ойлгож уншаарай.

### ШАГАЙН НААДГАЙ

Атга дүүрэн	шагайгаа	Хонь, ямаа хоёрыг
Ахрын эсгий	дээр цацлаа	Хооронд нь няслах гэж зүтгэлээ
Дүүгийн хаясан	шагай	<b>Хонь, ямаа хоёр мөргөлдөхийг</b>
Дэвжээ бүрхэн	буулаа	<b>Хоёр нүдээрээ харсан</b> гэж зүтгэлээ
Хонь, ямаа,	тэмээ, морь	Тэгдэггүй юм, тэнгэр задарна гэж
Ховор тохиох	онх хүртэл буулаа	Тэнд суусан эмээ хошигнолоо
Ижил ижлээр	хөндөж харвадаг	Ардын наадгайн ёсыг эрхэмлэ гэж
Эртний ёсыг	дүү зөрчлөө	Аав бидэнд сургалаа <i>Ш.Галсанбаатар</i>

## 4. Асуултын дагуу ярилцаарай.

- Дэвжээ бүрхэн буусан шагай хэдэн янзаар буусан бэ?
- Хоёр өөр шагайг нясалж болох уу? Яагаад...

## 5. Шүлгийг төлөөлөн уншаарай.

● Дүү нь болж унших үг




Үзүүр талаараа тогтсон буултыг онх гэнэ.




ахрын эсгий - хонь хяргасны дараа ахин ургасан ноосоор хийсэн эсгий  
 дэвжээ - шагай тоглоход дэвссэн зүйл  
 тэнгэр задрах - тэнгэрийн байдал ая тавгүй болох

1. Зургийг ажиглаад харилцан ярилцаарай.



Шагайгаар даам тоглоё.



Май, чамд шагай бэлэглэе.

2. Эхийг уншихдаа хэрэгтэй мэдээллээ сонгон тэмдэглээрэй.

3. Тэмдэглэсэн зүйлээ дэвтэртээ бичээрэй.

**ЭР ШАГАЙ**

Би чихрийн төмөр хайрцаг дүүрэн шагайтай. Аав маань намайг хөрөнгө их цуглуулсан олон малтай хүү дээ гэж бэлгэдэн өхөөрддөг. Миний шагайны ихэнх нь эр шагай. Цагаан сараар аз хийморио үзэхээр 2 эр шагай, 2 эм шагай сонгон “Дөрвөн бэрх” буулгадаг. Шагайны эр, эм бас хурдныг нь аавтайгаа шинждэг. Морь буулгаад нар зөв эргүүлэгтэй бол эр шагай, буруу эргүүлэгтэй бол эм шагай болно.





Эр шагай буюу азарга



Эм шагай буюу гүү

4. Өгүүлбэр бүтээгээрэй.



5. Морь буулгаад, “Дөрвөн бэрх”-ийнхээ шагайг сонгоорой.

1. Зургийг ажиглаад, шагайн буултыг асуултын дагуу ярилцаарай.



- Буултыг хэрхэн нэрлэдэг вэ?
- Шагай орхиод няслах гэтэл “Дөрвөн бэрх” буувал яах вэ?
- Морь уралдуулан тоглох үед “Дөрвөн бэрх” буувал яах вэ?
- Өөр буултыг “Дөрвөн бэрх” гэж нэрлэх үү?



2. Монголчууд ямар ямар шагайн наадгайгаар нааддаг вэ? Тоочин бичээрэй.  
алаг мэлхий өрөх, ....., .....

3. Үгийг зөв сонгон нөхөж бичээд, тоглоомын заавар хамтарч зохиоцгооё.  
Нөхөх үг: уралдуулж, сонгоно, орхиж,

### МОРЬ УРАЛДУУЛЖ ТОГЛОХ ЗААВАР

Монголчууд шагайгаар морь ..... нааддаг. Морь уралдуулахдаа дараах дүрмээр тоглоно.



- Өөр өөрийн уралдуулах морийг .....
- Тоглоомонд оролцогч бүр наадгайн талбайг байгуулахад оролцож, морио гарааны талбайд байрлуулна.
- Дүүгээсээ эхлэн дөрвөн шагайг ээлжлэн ....., буусан морины тоогоор урагшилна.
- Дөрвөн бэрх буувал 4 мориор урагшилна.
- Хамгийн түрүүнд барианд орсон тоглогч энэ наадгайн ялагч болно.

4. Дээрх зааврын дагуу морь уралдуулж тоглоорой.

5. тоглогч, оролцогч, наадагч, ялагч эр үг үү, эм үг үү? ✓

..... ч-үсгээр төгссөн эм үг      ..... ч-үсгээр төгссөн эр үг

6. Дээрх үгсэд -ийг залгаврыг залган бичээд тогтоогоорой.

**гараа:** уралдаан эхлэх газар  
**бариа:** уралдаж ирсэн морийг барих газар





## ШАГАЙ ОЛЖЭЭ

Архангай аймгийн Гол мод гэдэг газраас эртний үеийн язгууртны булшнаас олон шагай гарсан нь бүгд адууных шиг тамгатай байжээ. Судлаачид үүнийг тэр үеийн хүүхдүүдийн тоглоом болохыг тогтоосон. Харин шагай наадгайн хөө бол баатар аавынх нь хуяг дуулганы тасархай гинж учир хөө хуяг гэж нэрлэжээ.

1. Уншихдаа утгыг нь ойлгохгүй үгийг ялган тэмдэглээрэй.

2. Ойлгохгүй үгээ бусадтайгаа ярилцаарай.

3. Асуултын дагуу давтан уншаад ярилцаарай.

- Хаанаас юу олсон бэ?
- Язгууртан гэж хэн бэ?
- Олсон зүйл нь ямар онцлогтой байсан бэ?
- Судлаачид ямар нотолгоо гаргасан бэ?
- Хөө гэж юу вэ? Тоглоомонд хэрхэн ашигладаг вэ?

4. Харилцан яриаг үргэлжлүүлээрэй.

## ШАГАЙ ШҮҮРЭХ

**Од:** Хөө хуягийг хэрэглэдэг шагайн наадгайг юу гэж нэрлэдэг вэ?

**Есүй:** Шагай шүүрэх гэдэг.

**Од:** Чи нийлүүлэх шагай авчирсан уу?

**Есүй:** Надад олон шагай байна. Миний шагай будагтай учраас тоглоом дуусаад ялгахад амар.

**Од:** За тэгвэл шагай шүүрч тоглоё. Яаж тоглох вэ?

**Есүй:** Чамд зааж өгье.

**Од:** Ялагч нь болохын тулд яах вэ?

**Есүй:** Олон шагай шүүрэх ёстой.

**Тоглоомын хэрэгсэл:**

Тэмдэг буюу тамгатай шагай, хөө, дэвсгэр

**Тоглоомын заавар:**





Багшийг сонсоод бичээрэй.

Гараа бариа хоёр  
Арай ойр байна

## ШАТАР ТОГЛОХ ЗААВАР

1. Мэдээллийг уншаад, ойлгосноо бусдадаа ярьж өгөөрэй.
2. Шатар тоглох заавартай танилцаарай. Аль хэсэг нь хамгийн чухал вэ?




тэрэгний  
нүүдэл


Мэдээлэл  
Ардын тоглоомыг тоглох арга хэлбэрээр нь үгэн, хөлөгт, хөдөлгөөнт тоглоом гэж ангилдаг. Шатар бол 2 хүн тоглодог хөлөгт тоглоом юм.  
Шатар тоглоход оюун ухаан тэлнэ.




морины  
нүүдэл



бэрсний  
нүүдэл



тэмээний  
нүүдэл



Хүү 1, 2 нүд  
урагшилна.  
Давж нүүхгүй.

### Шатар тоглохдоо:

- Нүүдлийг сурсан байх
- Хоёр хүн тоглох
- Эсрэг тоглогчийн ноёнг нүүдэлгүй болгох



### хөлөг:

шатар тоглох  
хүснэгт зураг  
бүхий тавиур



## Монголчуудын бахархал



2013 оны 5 сард Грек улсад болсон сурагчдын Дэлхийн аварга шалгаруулах шатрын тэмцээний 7 хүртэлх насны хөвгүүдийн ангилалд Есөнтөмөрийн Төгстөмөр хүү сүүлийн өрөгтөө тэнцсэнээр Дэлхийн аварга болсон байна. Дэлхийн аварга шатарчин хүү Монгол улсын нэрийг дэлхийд цуурайтуулсан нь бидний бахархал билээ.



1. Мэдээллийг уншаад чамд юу бодогдсон бэ?
2. Дэлхийн аварга хүүтэй ярилцлага хийвэл юу гэж асуух вэ?
3. Танай ангийн бахархал, чиний бахархал юу вэ? Ярилцаарай.



4. Өгөгдсөн үгийг сонгоод өгүүлбэр зохиож бичээрэй.



Сонгох үг: (өрөөлдөх, ташуулдаж, чигээрээ)  
Морь ..... нүүнэ.

### Ярилцлага хийхдээ:

- Юу, юу асуухаа эхлээд жагсаан бичнэ.
- Асуултаа эрэмбэлнэ.
  - Дэлхийн аварга болсон анхны сэтгэгдлийг асуух.
  - Яаж ийм амжилтад хүрснийг тодруулах.
  - Цаашид хэрхэн чадвараа ахиулах талаар юу бодож байгааг асуух
  - Юу сонирхож байгаагаа асуух.

5. Тэмээ, тэрэгний нүүдлээр ямар үг үүсэхийг олоод будаарай.

т	э	р	э	г	а	у	т
э	э	б	э	р	с	э	э
о	х	м	а	о	м	ү	р
г	ү	в	э	э	ю	д	э
э	ү	ч	э	э	к	с	г
р	ү	м	е	и	м	з	л
э	э	я	ё	ж	х	э	ц
т	ө	ү	г	э	р	э	т



шатрын  
хөлгийг



**бахархал:**  
сайн давуу  
талыг  
хүндэтгэх



6. Чиний дуртай тоглоом юу вэ? Төлөвлөгөөний дагуу ярилцаарай.

- Яагаад чи энэ тоглоомоор тоглох дуртай вэ?
- Тоглоомынхоо тухай чи юу мэдэх вэ?
- Ямар ач холбогдолтой вэ?



7. Дуртай тоглоомынхоо талаар бичээрэй.

**Миний дуртай тоглоом**  
(компьютер тоглоом)

**Сайн тал:** Сэтгэхүй хөгжинө,  
мэдээлэл олж авна

**Яагаад гэвэл:** Компьютертой  
ажиллаж сурна.

**Сөрөг тал:** Удаан хугацаагаар  
тоглох нь эрүүл мэндэд хортой

**Яагаад гэвэл:** Нүдний хараа  
муудна.

**Миний дуртай тоглоом**  
(.....)

**Сайн тал:** .....

**Сөрөг тал:** .....

**Яагаад гэвэл:** .....

**Яагаад гэвэл:** .....



Багшийг сонсоод бичээрэй.

Модны шилмүүс  
Нүдний сормуус

## Хөдөлгөөнт тоглоомыг өөрчлөн наадацгаая



### Чоно тарвагацах

**Тарвага:** Чоно гуай, чоно гуай хэтээ өгөөч

**Чоно:** Хэтээр яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Гал түлье.

**Чоно:** Галаар яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Цавуу буцалгая.

**Чоно:** Цавуугаар яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Нум сум наая

**Чоно:** Нум сумаар яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Чонын толгойг хага харвая гээд тарваганууд чононоос зугатна.

### Тоглоомын заавар:

- Хүүхдүүд тарвага болж, нэг хүүхэд чоно болно.
- Тарвага 20-30 метр зайтай хоёр нүхтэй байна.
- Тарваганууд гүйхэд чоно тэднийг хөөж барьж дууссанаар тоглоом дуусна.

### Чоно тарвагацах

**Тарвага:** Чоно гуай, чоно гуай төл малын нэрийг хэлж өгөөч

**Чоно:** Төл малын нэрийг хэлүүлж яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Эр үг, эм үгээр нь ангилах гэсэн юм.

**Чоно:** Эр үг, эм үгээр ангилж яах гэсэн юм бэ?

**Тарвага:** “ы” “ий” зөв залгаж сурах гэсэн юм.

**Чоно:** “ы” “ий” зөв залгаж яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Чаддаг зүйлээ танд шалгуулах гэсэн юм.

**Чоно:** Чаддаг зүйлээ надад шалгуулж яах гэсэн юм бэ?

**Тарвага:** Дараагийн шинэ зүйлийг мэдье. Тарваганууд зөв гүйцэтгэж чадахгүй бол чононд баригдана.

### Тоглоомын заавар:

- Хүүхдүүд тарвага болж, нэг хүүхэд чоно болно.
- Тарваганууд даалгавраа зөв гүйцэтгэнэ.
- Буруу гүйцэтгэвэл чононд баригдана.

1. **ийг, ыг** залгаж бичээд үеэр зааглаарай. Үлгэрлэвэл: (хур|га- хур|гыг)

Эр үг үү?      Эм үг үү?

ишиг	тугал
хурга	ботго
<b>-ийг, -ыг ?</b>	
унага	

# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗААВРЫГ УНШААД ОЙЛГОЁ

1. Зааврыг тод чанга, ойлгож уншаарай.



Зааврын эхэнд юуны тухай бичсэн бэ?

**Заавар**

Үйлдвэрлэсэн сар өдрийг яаж мэдэх вэ?



Яаж хадгалах тухай аль хэсэгт байгааг тэмдэглэж уншаарай.

**Алимны ундаа: 20%**  
**Найрлага:** Зөөлрүүлсэн ус, Алимны өтгөрүүлсэн шүүс, Элсэн чихрийн сироп, Нимбэгний хүчил (E330), Үнэр амт орлуулагч.  
**Үйлдвэрлэсэн огноо:** Үйлдвэрлэсэн болон хэрэглэх хугацааг хайрцагны дээд талаас үзнэ үү.  
**Хэрэглэх заавар:** Хэрэглэхийн өмнө сайтар сэгсэрч хэрэглэнэ.  
**Хадгалах нөхцөл, хугацаа:** 0°-с 18°-с хэмд 12 сар. Задалсанаас хойш сэрүүн нөхцөлд 3-аас дээшгүй хоног хадгална.  
**Хаяг:** МонФрэш үйлдвэрийн цогцолбор, ажилчны гудамж, 3-р хороо, ХУД, Улаанбаатар хот, Монгол улс 210636. Эрүүл бие, саруул ухааны төлөө сэтгэл шингээн МонФрэш Шүүс ХХК-д үйлдвэрлэв.  
 Утас: 976-11-344129,  
 Факс: 976-11-345336,  
 E-mail: info@monfresh.mn  
 Web: www.monfresh.mn  
**МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ.**  
**MNS 687-1:2012**

2. Хүнсний бүтээгдэхүүний заавар цуглуулж түүнийгээ бусдадаа тайлбарлан ярь.

Ярих төлөвлөгөө:



1. Найрлага, орц

.....  
 .....  
 .....




2. Хэрэглэх заавар

.....  
 .....  
 .....



3. Хадгалах нөхцөл, хугацаа

.....  
 .....  
 .....





1. Өгүүллэгийг хурдан, өөртөө уншаарай.

### Хатсан алимны ундаа

Ойн амьтдын |анхны наймааг | үнэг нээжээ. |Үнэг дэлгүүрээс |хатсан алим |худалдан авч, |голын усанд дэвтээн |ху|дал|даанд гаргав. |Нарны халууныг |хэлээд яах вэ? |Бүх амьтдын |ам цангаж,| дутуу бу|цал|га|сан |устай шүүс руу дайрна. |Үнэг тэдэнд |торхтой шүүснээс |зарсаар байв. |Амьтад амныхаа цангааг| гарган ханатлаа уужээ. |Маргааш нь хатсан алимны |шүүсээ зарах гэсэн боловч |нэг ч амьтан ирсэнгүй. |Бараг бүх амьтан| ойн эмнэлэгт| үзүүлэхээр явц|гаа|сан байжээ. |

Д.Базаррагчаа

### Уншихдаа:

- Заагласан хэсгээр харж уншаарай
- Ойлгож унших



2. Асуултын дагуу ярилцаарай.

- Үнэг юу хийсэн бэ?
- Ойн амьтад яагаад эмнэлэгт үзүүлсэн бэ?
- Энэ явдал юунаас болсон бэ?

3. Өгүүллэг цаашид хэрхэн үргэлжлэх бол? Таамаглаад яриарай.

4. Амьтдад ямар асуудал тулгарсан бэ? Туслаарай.

5. Үнэгний хийсэн ундаанаас болж юу болсон бэ? Бичээрэй.  
Усаа буцалгаагүй ундаа хийсэн.  
.....

6. Баталгаатай бүтээгдэхүүн гэдгийг яаж мэдэж болох вэ? Ярилцаарай.



Аан баталгаагүй зүйл идэж ууж болохгүй юм байна.

Яагаад эмчид үзүүлэхээр болсон юм бол оо?

Үнэгний зарсан ундаанаас болсон байх аа

Баталгаатай хүнс гэдгийг яаж мэдэх вэ?





7. Энэ ундааг ууж болох уу? Яагаад?

- Зурагт юу ажиглагдаж байна вэ?
- Юунд хэрэгтэй вэ?

**Алимны ундаа: 20%**  
**Найрлага:** Зөөлрүүлсэн ус, Алимны өтгөрүүлсэн шүүс, Элсэн чихрийн сироп, Нимбэгний хүчил (E330), Үнэр амт орлуулагч.  
**Үйлдвэрлэсэн огноо:** Үйлдвэрлэсэн болон хэрэглэх хугацааг хайрцагны дээд талаас үзнэ үү.  
**Хэрэглэх заавар:** Хэрэглэхийн өмнө сайтар сэгсэрч хэрэглэнэ.  
**Хадгалах нөхцөл, хугацаа:** 0°-с 18°-с хэмд 12 сар. Задалсанаас хойш сэрүүн нөхцөлд 3-аас дээшгүй хоног хадгална.  
**Хаяг:** МонФрэш үйлдвэрийн цогцолбор, ажилчны гудамж, 3-р хороо, ХУД, Улаанбаатар хот, Монгол улс 210636. Эрүүл бие, саруул ухааны төлөө сэтгэл шингэн МонФрэш Шүүс ХХК-д үйлдвэрлэв.  
 Утас: 976-11-344129,  
 Факс: 976-11-345336,  
 E-mail: info@monfresh.mn  
 Web: www.monfresh.mn

Өө бас найрлагыг бичсэн байна.

Ундааны нэр байна.




Хугацааг нь бичсэн байна.



8. Бүтээгдэхүүний хаана ямар ямар заавар байгааг ярилцаад, ойлгож уншаарай.




Онгойлгож хэрэглэх заавар байна.



найрлага, орц

хугацаа

хэрэглэх заавар



Сүүн хүчлийн өсгөвөр гэж юу юм болоо?

Найрлага:  
 Үнээний сүү, ундны ус, сүүн хүчлийн өсгөвөр

**Зааврыг уншихдаа:**

- Ойлгож унших
- Чухал хэсгийг олох
- Дагаж, мөрдөх

**сүүн хүчлийн өсгөвөр**  
 - тараг исгэдэг хөрөнгө

9. Асуултад хариулж бичээрэй.



- Хугацаа дууссан бүтээгдэхүүн хэрэглэвэл юу болох вэ? .....
- Яагаад зааврыг унших ёстой вэ? Эрүүл мэндэд тустай.
- Заавраас юу, юу нь илүү чухал вэ? .....

10. Ундаа авах хүүхдийн сонголтод туслаарай.



Ундааг нь авмаар л байна. Би чихрийн харшилтай. Алийг нь сонгох вэ?

11. Зааврыг уншиж мөрдөөрэй. Зааврын хамгийн чухал хэсэг нь аль болохыг тэмдэглээд, яагаад чухал болох талаар ярилцаарай.


**Хүнсний бүтээгдэхүүн авах заавар**

- Үйлдвэрлэсэн хугацааг харах
- Сав баглаа боодлыг шалгаж авах
- Өнгө үзэмж, хадгалалтыг шалгах

хамгийн чухал нь

12. Заавар бичиж сураарай.

- Заавар бичих сэдвээ сонгох
- Багууд сонгосон сэдвээ жагсаан бичээд хамгийн чухал сэдвийг ангиараа сонгон хамтарч заавар бичнэ.



13. Сурагчдын бичсэн зааврыг уншаад сайжруулсан хэсэгт саналаа хэлээрэй.

**Үдийн цайндаа мөрдөх заавар**

- Гараа угаасан байх
- Хоорондоо ярихгүй байх
- Бүтээгдэхүүний зааврыг унших
- Дараа нь ширээгээ цэвэрлэх

**Үдийн цайндаа мөрдөх заавар**

- Гараа угаасан байх
- Бүтээгдэхүүний зааврыг унших
- Хооллохдоо ярихгүй байх
- Дараа нь ширээгээ цэвэрлэх

1. Лууван, гол, нар, төмсний хэлсэн үгийг төлөөлөн уншаарай.



### Түнтгэр хөөрхөн төмс

Түнтгэр хөөрхөн төмс чи юуны хүчээр ийм том ургаа вэ?

Би илчээрээ ээгээгүй бол ургахгүй л байсан юм.

Би ундаалаагүй бол түнтгэр төмс ийм том ургахгүй.



Би үй түмэн үрээс ургасан билээ. Өчүүхэн жижиг үрээс том болоход минь нар, ус, цөм тус хүргэлээ. Гэвч өчүүхэн жижиг үрийг минь хүн тариагүй бол нар ч найртайгаар ээж чадахгүй байсан.

Суваг шуудуу татаж, их голоос хүн чамайг урсгаагүй бол ус чи намайг ундалж чадахгүй байсан. Би хүний л хүчээр түнтгэр хөөрхөн том ургасан юм даа.



2. Асуултад хариулж бичээрэй.

Төмс яагаад түнтгэр том ургасан бэ?

.....


3. Мэдсэн зүйлээ бичье.

Төмсийг хүнсэнд хэрэглэх заавар: (хальслах, угаах)

4. Үгийг зөв байрлуулан өгүүлбэр зохиогоорой.

хүний л том түнтгэр ургасан. Би хүчээр

5. Юу? гэсэн асуултад тохирох үгийг нөхөж өгүүлбэр зохиогоорой.



**суваг шуудуу:**  
ус урсгахаар  
ухсан нарийн  
суваг

## Найзыгаа үнэлээрэй

### 1. Хүнсний бүтээгдэхүүний нэрийг бичээрэй.



Энэ юуны заавар вэ?



Онгойлгох заавар байна

### 2. Зааврыг уншиж, тохирох дугаарыг тэмдэглээрэй.

найрлага

2

хугацаа


3

улсын код

1

хэрэглэх заавар

4



### 3. Найрлагыг ойлгож уншаад, найздаа яриарай.

**Найрлага:** Аньсны цэвэр шүүс витамин, С витамин, **бурам** элсэн чихрийн нунтаг Аньс жимс нь витамин С, В, РР болон эрдэс бодисоор баялаг тул биеийн эсэргүүцлийг сайжруулна, ханиад томуугаас урьдчилан сэргийлэх сайн нөлөөтэй.




үрэл

### 4. Тохирох тэмдгийг сонгож бичээрэй. ( . ? )

Хүнсний бүтээгдэхүүн авахдаа хугацааг сайн харах хэрэгтэй.  
Хугацаа дууссан бүтээгдэхүүнийг хэрэглэж болох уу?  
Чи үдийн цайны мөрдөх зааврыг биелүүлдэг үү...  
Яагаад заавал зааврыг унших ёстой вэ...  
Хүмүүсийн хэрэглэдэг бүх зүйлд заавар бичигдсэн байдаг...





1. Асуултын дагуу ярилцаарай.

- Туулай яагаад энэ замыг сонгосон бэ?
- Туулайд юу тохиолдож болох вэ?
- Туулайн оронд өөрийгөө төсөөлөн бодоорой.

? ? ?  
? Ялгааг ол. ?

ЧОНО

4ОНО

2. Үлгэрийг сонсоод ярилцаарай (Багш "Туулай" үлгэрийг уншиж өгнө).

- Туулай яагаад буруу зам сонгосон бэ?
- Туулай ямар сургамж авсан бэ?

3. Уншаад өгүүлбэр зохиож бичээрэй.

Хүүхдүүд ээ! Туулайд туслаарай.



4. Лууван дээрх үсгийг нэрлээд бүлэглээрэй.



## -н замд тохиолдсон явдал

Өтгөн ойн цоорхойд хоёр өргөж явлаа. өмнө нь гараад мөрлөн өргөхөд дүнзний үзүүрээс дүүжлэгдэв. Цааш явж байтал ганган ирж дүнзний үзүүр дээр суулаа. Энэ үед хүч хүрсэнгүй алдчихжээ. Гэтэл газарт тэрийн унаж нисэн одоход гайхан зогсоно.

Д.Давааням

### 1. Багшийн асуултад зөв хариулсан өгүүлбэрийг сонгон бичээрэй.



2. Яагаад   гэж тэмдэглэснийг тайлбарлаарай.

3. Үлгэрийг дахин уншаад асуултад бүтэн өгүүлбэрээр хариулаарай.

Асуулт: Гахай яагаад дүүжлэгдсэн бэ?

Хариулт: Гахай баавгайнаас ..... учир дүүжлэгдсэн.

Асуулт: Баавгайд юу тохиолдов?

Хариулт: Хүнд мод ..... явтал эрвээхэй ..... тул модоо алджээ.

Асуулт: Баавгайн гайхах болсон шалтгаан юу вэ?

Хариулт: ..... гахай унасныг харсан.

### 4. Ярилцаарай.




Асуултад бүтэн өгүүлбэрээр хариулна.

# 1. Эхийг зөвлөмжийн дагуу уншаарай.

## Гаварт тохиолдсон явдал

Өглөөнөөс хойш бороо орсоор байв. Гавар гэртээ ганцаараа хийх зүйлээ олж ядан уйдаж суулаа. Хэн нэгэнд захиа бичих санаа төрлөө.



Оллоо, оллоо. Хөлөө гэмтээсэн гөлчгий найздаа захиа бичих юм байна шүү гэж бодсоор цаас аван суулаа.



### Зөвлөмж:

- Өөртөө уншаарай.
- Зөв ойлгон уншаарай.
- Будсан хэсгүүдийг ялган уншаарай.
- Ойлгохгүй үгээ тэмдэглээд ярилцаарай. (гавар)



Юу бичих вэ?

Өчигдөр бам|ба|рууш, бөжин, хэ|рэм|хэн гуравтай хөг|жил|тэй тоглосон. Цөөрөм рүү явж зу|гаал|сан. Амттай сайхан хоол идсэнээ бичмээр л байна.

Гавар олон үг бичиж сураагүй байв. За|хиан|даа “Эд|гэр|сэн бол хамт тоглоё” гэж бичив. Гавар захиа бичиж чадсан тул баяртай байлаа.





## 2. Асуултын дагуу бүтэн өгүүлбэрээр ярилцаарай.

- Гавар юу гэж бодсон бэ?
- Гаварт ямар санаа төрсөн бэ?
- Гавар захиа бичиж чадсан уу?
- Гавар ямар учраас баярласан бэ?

## 4. Харьцуулан ярилцаарай.

### 3. Дараах үгсийг бүлэглэн бичээрэй.




баатрын нэр	юу тохиолдов	Ямар сургамж авсан бэ?
- туулай	.....	.....
- гавар	.....	.....
- эрвээхэй	.....	.....
- баавгай	.....	.....
- гахай	.....	.....



гавар  
гөлчгий  
бөжинтэй  
цөөрөм

## Хулганад тохиолдсон явдал




1. Зургийг ажиглан ярилцаад, тайлбар бичээрэй.

- Эхлээд яасан бэ?
- Дараа нь яасан бэ?
- Төгсгөлд нь юу болсон бэ?

хулганы нэр	зан чанар	хийсэн үйл

2. Хулгануудад нэр өгөөрэй.

3. Хулгануудын талаарх өөрийн бодлоо бичээрэй.



4. Болсон явдлаа ярихдаа тулгуур үгийг ашиглаарай.

Хөдөө, малчны амьдрал, шинэ найзууд, усны хувцас, аялал, зугаалга, хөгжилтэй, эрүүл агаар, алсыг харагч

5. Бичихдээ:

- Болсон явдлаа санаарай.
- Нэгийг нь сонгоод ярих дараалал бэлдээрэй.
  - Амьтдад тохиолдсон сонирхолтой явдлыг санаарай.
  - Түүнтэй харьцуулаарай.
  - Ярих зүйлээ жагсаан бичээрэй.
- Бичсэнээ сайжруулан засаарай.

6. Бүгдийг чадсан бол ♥♥♥, дутуу бол ♥♥, ярихыг хүсвэл ♥ зураарай.

Болсон явдлаа бүгдийг найздаа ярьж чадлаа.	
Болсон хөгжилтэй явдлаасаа заримыг нь найздаа ярьж чадлаа.	
Болсон явдлаа найздаа дутуу ярилаа.	

1. Болсон явдлыг өнгө тус бүрээр нь багцлан харж, аль болох хурдан уншаарай.

### Соно хөх түрүү хоёр (домог үлгэр)


Эрт дээр цагт соно толгой дээрээ оюу шигтгээтэй байжээ. Соныг унтаж байхад хөх түрүү шигтгээг нь хулгайлан өөрийнхөө толгой дээр хатгажээ. Тэр цагаас хойш хөх түрүү ногоон толгойтой болсон ажээ. Харин соно түүнийг хөөгөөд гүйцсэнгүй. Гүйцэхийн тулд давхар далавчтай болжээ. Хурдан болсон соно, хөх түрүүг барьж аваад ногоон толгойг нь тастдаг гэнэ. Соно гарч ирэхээр хөх түрүү алга болдгийн учир энэ.



Би уншиж чадсан	Нэг минутад уншсан үгийн тоо	.....
Би дараа ингэж уншина	Нэг минутад унших үгийн тоо	.....



хөх түрүү



соно

2. Дахин уншихдаа үйл явдлын дарааллыг тогтож уншина уу.

3. Асуултын дагуу ярилцаарай

Ямар амьтан оюу шигтгээг хэрхэн авсан вэ?	Соно давхар далавчтай болсны учир юу вэ?	Амьтад ямар буруу үйл хийж байна гэж бодож байна вэ?
---	--	--

4. Чиний эд зүйлийг найз нь зөвшөөрөлгүй авах үед болсон үйл явдлаа эргэцүүлж ярилцана уу.

5. Төгсгөл эхлэлийг холбон үгийн хэлхээ үүсгээрэй.

Үлгэрлэвэл:



6. Үлгэрээс хос эгшигтэй үгийг ялган бичээд үеэр таслаарай.




Багшийг сонсоод бичээрэй.

Улс гүрэн олон ч Монголыг минь яаж гүйцэх вэ?





**Болсон явдлаа ярьж, бичье**



**Алхам-1**

Сэргээн санаад, сонгох ✓

- Надад тохиолдсон хөгтэй явдал
- Надад тохиолдсон сургамжтай явдал
- Надад тохиолдсон мартагдахгүй үйл явдал

**Алхам-2**

Ярих үйлээ төлөвлөх

- Яагаад үүнийг сонгож ярихаар болсон
- Юуны тухай ярьж эхлэх
- Яриагаа яаж үргэлжлүүлэх
- Яриагаа яаж төгсгөх

**Алхам-3**

Ярьсан зүйлийнхээ дагуу хэрхэн бичихээ төлөвлөх

- Би ярьснаа эргэцүүлэх
- Бичих дараалал тогтоох (яаж эхлэх, яаж үргэлжлүүлэх, яаж дуусгах, ямар үг хэллэг хэрэглэх)

**Алхам-4**

Хүснэгт ашиглан бичих

эхлэл	үргэлжлэл	төгсгөл

**Алхам-5**

Бичсэн эхээ сайжруулах.

Миний сайжруулсан эх


.....

.....

.....

# ТАЙЛБАР ТОЛЬ БИЧИГ АШИГЛАЖ СУРЦГААЯ

1. Зургийг ажиглаад, хүмүүс болон төл малд нэр өгч ярилцаарай.
2. Халзаадай, Жоохноо, Алагхан гэх мэтээр төл малдаа өгсөн нэрийг хэрхэн бичсэнийг ажиглаарай.
3. Яагаад Халзаадай гэж нэрлэсэн бэ?



4. Төл малаа нэрлэж бичээрэй.

Үлгэрлэвэл: Алагхан - унага, Халзаадай - хурга, .....ишиг, .....  
ботго, Жоохноо - .....

5. Шүлгийг гүйцээж уншаад, төл мал бүрийн онцлог шинжийг ярилцаарай.

Торгон шар нөмрөгтэй  
Торомгор хөөрхөн **ботго** минь  
Туг ширээ бөхөндөө  
Уураг сүүний үнэртэй

Миний хөөрхөн.....  
Монгол адууны удам  
Дэлт тахийн удам  
Дэлхийд дөрвөн туурайтан

Миний хэнз .....  
Монгол түмний энх сүрэг.  
Халзан цагаан .....  
Хотон дундаа чимэгтэй



..... олуулаа тоглосоор  
Ээж нь сүүгээ хөхүүлсээр  
Сэгсгэр хөөрхөн ..... нүүд  
Сэлмэн эвэрт болцгооно.

Бүлтгэр алаг нүдтэй  
Бумбагар зөөлөн уруултай  
Бусадтай сүүгээ хуваадаг  
Буянтай амьтан **тугал**



Багшийг сонсоод бичээрэй.

Унага, ботго, ишиг, хурга,  
тугалыг төл мал гэнэ.



1. Шүлгийг уншихдаа үгээ хоёр хоёроор нь уншаарай.  
Малын нэрийг ялган тэмдэглээрэй.



### ДҮНГИЙН ХУРАЛ

Эцэг эхийн | хурал болжээ  
Ингэ, гүү | хамт очжээ  
Онц сурсан | унаганы ээж  
Олон зочны | урд сууж  
Муу сурсан | ботгоны ээж  
Мухарт очоод | бушуухан нуугджээ

Т.Галсан



2. Ямар малын төл вэ? Эцэг мал, эх малыг нь нэрлэж бичээрэй.

Адууны төл **унага**, эх мал нь **гүү**, эцэг мал нь **азарга**.

Тэмээний төл **ботго**, эх мал нь **ингэ**, эцэг мал нь **буур**.


Үхрийн төл **тугал**, эх мал нь ....., эцэг мал нь **бух**.

Хонины төл ....., эх мал нь **ЭМ ХОНЬ**, эцэг мал нь **хуц**.


Ямааны төл **ишиг**, эх мал нь **ЭМ ЯМАА**, эцэг малыг нь ..... гэж нэрлэдэг.

3. Зөв холбож бичээд тухайн амьтан шиг дуугарч тоглоорой. (ботго буйлах)

4. Эцэг мал, эх мал, төл малыг ижил өнгөөр ялган будаарай.



азарганы,  
буурны, бухны  
хуцны, ухны





## Толь бичиг ашиглаж сураарай.

### МОРИО ХАЙРЛААРЙ

Газрын уруу хэт ширүүн давхивал морины **цээж авна**. Давхиж ирсэн морио хөдөлгөхгүй гэнэт зогсоовол морины хөлд **цус хурж, бүдрэмтгий** болно.

Толь бичгийн  
үг цагаан  
толгойн үсгийн  
дарааллаар  
бичигдэнэ.



### 1-р алхам:

Эхийг уншаад утгыг нь ойлгохгүй үгийг ялган тэмдэглээрэй.



### 2-р алхам:


Тэмдэглэсэн үгээ бичээрэй.

**цээж авна** –  
**цус хурах** –  
**бүдрэмтгий** –  
**давхих** –




### 3-р алхам:

Толь бичгээс үгээ эхний үсгээр хайж олно.



### 4-р алхам:

Толь бичгээс уншсан үгийн тайлбарыг дэвтэртээ бичээрэй.



### 5-р алхам:

Тэмдэглэсэн үгээрээ өгүүлбэр зохиогоорой.

**Ах бид хоёр цээжээ авсан морийг эмчлэв.**



1. Асуултын дагуу ярилцаарай.

- Ойлгомжгүй үгийн утгыг яаж мэдсэн бэ?
- Толь бичигт үгийг хэрхэн дараалуулж бичдэг вэ?
- Толь бичиг ямар хэрэгтэй вэ?

2. Эхийг уншаад утгыг нь ойлгохгүй үгийг толь бичиг ашиглан мэдээрэй.

Эмээлийн зөөлөвчийг тохом гэнэ. Тохмыг зөөлөн эсгийгээр хийдэг. Эмээлийн гөлөмнөөс тохом 2 см-ээр илүү байдаг. Тохомны дор зөөлөн, нимгэн эсгий, эсвэл зузаан даавуун туслах тохом (хөлсөвч) тохдог. Энэ нь тохмыг хөлснөөс хамгаална.

3. Хоёр янзын тайлбар толь бичгийг ажиглаарай.

а. Зурагт тайлбар толь

Эмээл, тохошны доор жийрэглэсэн эсгий, даавуун эдийг **тохом** гэнэ.

б. Тайлбар эх бүхий толь

**Эсгий**  
хонины ноосыг зулж хийсэн эд (бүтээгдэхүүн)

Үгийн тайлбар толь ашиглавал үгээ ухаарч эхээ гүйцэд ойлгоно. Зөв бичих толь ашиглан алдаагүй бичиж сурдаг.


4. **Эмээл, гөлөм** гэсэн хоёр үгийн утгыг толь бичгээс харж тэмдэглэл хийгээд зураарай.




**хөлсөвч-тохмын жийрэг**

1. Зургийг ажиглаад, цэгийн оронд өгүүлбэр зохиож бичээрэй.
2. Ойлгомжгүй үгээ тэмдэглээд толь бичгээс тайлбарыг хараарай.


### ХОЁР ИШИГ



1. ....  
.....



2. ....  
.....



3. ....  
.....

### ХОЁР ЯМАА

(Үлгэр)

Нарийхан жим дээр хоёр ямаа тааралдаж гэнэ. Жимийн нэг талд нь өндөр уул, нөгөө талд нь эгц эрэг байв. Хоёр ямаа яахаа бодон хэсэг зогслоо. Гэтэл нэг ямаа нь газар наалдан хэвтэв. Нөгөө ямаа нь болгоомжтойгоор түүн дээгүүр алхаад гарлаа. Ийнхүү хоёр ямаа тус тусынхаа замаар явжээ.


3. Эхэд утгыг ойлгохгүй үг байсан уу?

- Ажиглаарай.
- Ялгаарай.

4. Зураг, үлгэр хоёрын үйл явдлыг харьцуулан ярилцаарай.

5. Дараах үгийг хоёр ямааны зан төлөвт тохируулан сонгож бичээрэй.

зөрүүд, эвсэг, ухаалаг, тэнэг, хөгшин, залуу, том, жижиг



**ЖИМ** - нарийн зам

1. Эхийг хурдан уншаад уншсан хугацаагаа тэмдэглээрэй.



Морь бух хоёрын тухай	4
Нэгэн удаа морь бух хоёр хэн нь хурдан бэ? гэж маргалдаж гэнэ.	11
Бух: Би ч их хурдан давхиж чадна л даа. Даанч хөл доорх газар минь	21
цөмөрчих вий гэж айгаад байх юм гэв. Гэлээ ч гэсэн морь бух хоёр	34
уралдаж гэнэ. Бух давхиж яваад жалганд уначихжээ. Тэгээд хөл доорх	44
газар маань цөмөрчихлөө дөө гэж бодсоор хэвтсэн гэнэ. Тэр цагаас	53
хойш бух хэзээ ч давхихаа больжээ. Түүнийг ташуурдаж байж л нэг юм	63
хөдөлгөдөг болсон ажээ.	66

1 минут											2 минут												
5	10	15	20	25	30	35	40	45	50	60	65	70	75	80	85	90	95	100	105	110	115	120	→

2. Эхийг дахин уншихдаа ойлгохгүй үгээ тэмдэглээрэй.

3. Тэмдэглэсэн үгээ толь бичгээс бичээрэй.

тайлбарлах үг	миний таамаглал	толь бичгийн тайлбар
цөмөрчихлөө		
жалга		

4. Тайлбарласан үгээрээ өгүүлбэр зохион бичнэ.

5. Асуулт зохиож ярилцаарай

асуулт	хариулт
.....?	Хэн нь илүү хурднаа батлах гэж маргасан.
.....?	Жалганд унаснаа газар цөмөрчихлөө гэж бодсон.
.....?	Бух үхрийн эцэг мал.



Багшийг сонсоод бичээрэй.



Ахын хар хөх бух  
Бух бухнаас том, хар хөх бух





1. Зургийг ажиглаж, ярилцаад, өгүүлбэр зохиож бичээрэй.

**Амьтдын дунд болсон явдал**



Тугал ирж эвэр зурав.



# ТАНИЛЦУУЛГАА ЯРЬЖ, БИЧИЖ СУРЪЯ



## Гэр бүлийнхээ тухай ярилцъя

1. Хэнд гэр бүлийнхээ тухай яримаар байна, найзаа сонгоод баг болоорой.
2. Гэр бүлийнхээ тухай танилцуулаарай.
3. Загварыг ашиглаад өгүүлбэр зохиогоорой.  
Үлгэрлэвэл: (Миний ах ажилсаг)



хөл бөмбөг

.....

.....  
зантай

бор царайтай

Миний ах

ажилсаг


### Багаар ажиллахдаа:

- “Гэр бүл” сэдвээр ярилцаарай.
- Хүүхэд бүр өөрийн гэр бүлийн зургийг тайлбарлан ярилцаарай.
- Өөрийн гэр бүлийг дүрслэн зураарай.



## 4. Загварыг ажиглаад тохирох үгийг нөхөж бичээрэй.

- Намайг ..... овогтой ..... гэдэг.
- Миний аавын нэрийг ..... гэдэг.
- Миний ээжийн нэрийг ..... гэдэг.





# 1. Шүлгийг цээжлээд уран тод уншаарай.

## Гурван эрдэнэ

Алт гэвэл | аавыг↗ хэлнэ  
 Ачтай сайхан итгэлийг↗ хэлнэ  
 Эрдэнэ гэвэл | ээжийг↗ хэлнэ  
 Энгүй сайхан сэтгэлийг↗ хэлнэ  
 Нандин гэвэл | найзаа↗ хэлнэ  
 Намайг гэсэн | бодлыг↗ хэлнэ. Д.Давааням

**Уран тод уншихдаа:**  
 | - зогсоц хийн уншина  
 - дуулаа өндөрсгөнө



## Манайхан

### 2. Уншаад ярилцаарай.

- Юуны тухай бичихээ бодъё.
- Яаж эхлэхээ төлөвлөө.
- Бичихдээ гэр бүлийн гишүүдийнхээ нэрийг зөв бичье.
- Бичиж дуусаад хэн нэгэнд уншиж өгье.
- Зөвлөгөөний дагуу засаж сайжруулъя.
- Дэвтэртээ бичье.

### 3. Эхийг уншаад, хичээнгүй сайхан бичээрэй.

#### Манайхан

Манайх таван ам бүлтэй. Миний аавыг Баяраа гэдэг. Миний ээжийг Жаргалмаа гэдэг. Миний дүүг Тэмүүлэн гэдэг.  
 .....



Өгүүлбэрийн эхний үсгийг яаж бичих вэ?

Хүний нэрийн эхний үсгийг яаж бичих вэ?



+ Аав маань мужаан

#### Манайхан

Манайх таван ам бүлтэй. Миний аавыг Баяраа гэдэг. Миний ээжийг Жаргалмаа гэдэг. Миний дүүг Тэмүүлэн гэдэг. Бид чөлөөт цагаа хөгжилтэй зугаатай өнгөрөөдөг. Энэ зун бид нар Хөвсгөл далайд амрахаар явсан.

амрахаар хөгжилтэй

### 4. Эргэцүүлээрэй.

Эр үг үү?



Эм үг үү?

эх  
 эгчийн **-ийн, -ын?** аав  
 нагац

#### Манайхан

Манайх таван ам бүлтэй. Миний аавыг Баяраа гэдэг. Аав маань мужаан. Ээжийг Жаргалмаа, дүүг Тэмүүлэн гэдэг. Бид чөлөөт цагаа хөгжилтэй зугаатай өнгөрөөдөг. Энэ зун бид нар Хөвсгөл далайд амрахаар явсан.



### 1. Өөрийгөө танилцуулаарай.



Юуны тухай ярих вэ?


- Гэр бүлийн тухай
- Ураг төрлийн тухай
- Найзын тухай
- Өөрийнхөө тухай

#### Ярих төлөвлөгөө:

- Миний бага нас
- Би сургуульд орлоо
- Миний сонирхол
- Миний мөрөөдөл



### 2. Загварыг ажиглаад үг сонгож өгүүлбэр зохиож бичээрэй.



- Овог, нэр
- Төрсөн он сар өдөр
- Гэрийн хаяг
- Регистрийн дугаар

### 3. Анкет бөглөхөд юу хэрэгтэйг мэдэж аваарай.



гэрийн хаяг,  
сурагчийн  
сургуулийн  
анкет  
регистр

#### Товч анкет бөглөх загвар

1. Овог ..... нэр .....
2. Төрсөн он..... сар ..... өдөр .....
3. Регистрийн дугаар .....
4. Нас .....
5. Хүйс .....
6. Гэрийн хаяг: .....
7. Холбоо барих утас: аав .....  
ээж .....  
өөрийн .....

Өөрийгөө үнэлээрэй.

- Анкетаа зөв бичсэн
- Бага зэрэг алдаа гаргасан
- Олон алдаа гаргасан





## ○ Найзыгаа танилцуулаарай ○

1. Эргэцүүлэн бодоорой.



- Цэцэрлэгийн найз
- Сургуулийн найз
- Байрны найз
- Зуслангийн найз
- Дотны найз



2. Харилцан яриаг уншаад ярилцаарай.

- Баавгай: - Сайн байна уу? Хэрэм минь.  
 Хэрэм: - Сайн, та сайн байна уу?  
 Баавгай: - Хоёулаа хамтарч самар түүх үү?  
 Хэрэм: - Тэгье, тэгье.

3. Эхийг ойлгож уншаад ярилцаарай.

### Хоёр найз

Хэрэм баавгай хоёр эртний сайн найзууд юм. Энэ хоёр намрын налгар өдрүүдэд самар түүж хадгалав. Өглөө самар түүхээр явав. Хоёр найз их ядарчээ.

Хэрэм хуш модны мөчир дамжин боргоцойг газаршиднэ. Баавгай боргоцойг бөөгнүүлж овоолно. Дараа нь самраа цөмж хадгалав. Ажилдаа махран зүтгэсэн хоёр хэдий ядарч байсан ч амрахыг огт хүсэхгүй байв.



- Хэрэм, чи жижигхэн болохоор их ядарсан биз. Одоо амар гэж баавгай хэлэхэд хэрэм:  
 - Хоёул адилхан ажилласан. Харин та газраар явж, их самар түүж ядарсан байх. Одоо амар гэхэд баавгай ой модонд цуурайттал хүрхрэн:  
 - Би ядраагүй л дээ. Гэхдээ хоёулаа амаръя гэхэд хэрэм зөвшөөрчээ.

4. Асуултын дагуу ярилцаарай.

- Хэрэм юу гэж хэлсэн бэ?
- Хэрэм баавгай хоёр найзууд мөн үү? Яагаад?
- Хэрэмний хэлсэн үг амьтны ямар сайн чанарыг илэрхийлсэн бэ?

намар - намрын  
самар - самрын

# 1. Шүлгийг цээжлээд, уран тод уншаарай.



## Тэр миний найз

Дугар найз минь  
Дутагдал гаргажээ  
Яах вэ, яах вэ  
Миний найз  
Ямар боловч  
Миний найз  
Дугар найздаа  
Дуртай тусална

Д.Давааням



Алхам-1. Найзынхаа тухай танилцуулга бичихдээ юу бичихээ бодоорой.

- ✓ Миний найзын сурдаг сургууль, сонирхол, авьяас
- ✓ Миний найз дуртай зүйл
- ✓ Найзынхаа юугаар бахархдаг вэ?
- ✓ ...

Алхам-2. Найзынхаа сайн чанарыг бичээрэй.



сайн чанар: нөхөрсөг, ...


Алхам -3. Загварын дагуу найзынхаа танилцуулгыг бичээрэй.

## Миний найзын танилцуулга

Зураг

Миний найзын нэрийг .....гэдэг.  
Би найзынхаа ....., ....., .....  
..... сайн чанараар нь бахархдаг. Найз маань  
.....учраас .....харьцдаг. Миний  
найз .....сурдаг. Хамгийн дуртай хичээл нь  
..... Мөрөөдөл нь .....  
Би .....тусална.

## -ЫГ, -ИЙГ, -ЫН, -ИЙН ЗАЛГАВРЫГ ЗӨВ БИЧЬЕ



Ажил хийж хүн болдог  
Ар давж хүлэг болдог



1. Ямар, ямар мэргэжилтэй хүн байна вэ? Юуны тухай судлах гэж буйг таамаглая.
2. Уншиж ярилцаад мэргэжлийн нэрийг бичээрэй.

Алх хадаас нийлүүлэн  
Амьдралын хэрэгтэй зүйлийг хийнэ би

Уянгалаг сайхан хоолойгоороо  
Уярааж чадна би

Уранхай цоорхойг эвлүүлэх  
Уран гар надад бий

Амттан бүхнийг хийнэ би

### 3. Асуулт асууж сурцгаая.

- Танай аав, ээж ямар мэргэжилтэй вэ?
- .....

### 4. Уншаад асуултын дагуу ярилцаарай.

- Эр үг үү, эм үг үү?
- Ямар үсгээр төгссөн үг байна вэ?  
Ажиглаад ярилцаарай.

### Асуулт ямар байх вэ?

- Асуулт ойлгомжтой байх
- Яагаад, учир нь, хэрвээ чи байсан бол яах вэ, чи юу гэж бодож байна гэсэн үгийг ашиглаарай.

бариа**ч**

баг**ш**

ото**ч**

зураа**ч**

сувилаг**ч**

тогоо**ч**


хууль**ч**

зохиол**ч**

худалдаг**ч**

**мэргэжил:**  
эзэмшсэн  
мэдлэг





1. Ямар мэргэжилтэй хүний багаж вэ? Ярилцаарай.

2. Багажийг нэрлээд эр, эм үгээр нь ангилж бичээрэй.

Эр үг үү?

Эм үг үү?

будаг  
харандаа  
шугам

зураач

бийр

Эр үг үү?

Эм үг үү?


ЭМЧ

3. Чи ямар мэргэжилтэй хүн болох вэ?

- Сонгосон мэргэжлийнхээ тухай юу мэдэхээ ярилцаарай.



Өвчтэй хүнд  
туслах эмч  
болно.



.....

.....

4. Сонгосон мэргэжлийнхээ тухай өгүүлбэр зохиож засаж сайжруулаарай.



чагнуур,  
өвчтөн

Эмч өвчтөнг  
чагнуураар үздэг.

Эмч өвчтөнг  
чагнуураар оношилно.

5. Мэргэжлийн нэрийг эр, эм үгээр нь ялган бичээрэй.

малчин, цагдаа, эмч, худалдагч,  
зохиолч, хуульч, эдийн засагч,  
барилгачин, зураач, дуучин,  
оёдолчин, үсчин, тогооч, нисгэгч

Эр үг үү?

малчин

.....



Эм үг үү?


эмч

.....




6. Зөв харгалзуулан холбоо үг үүсгэн бичээрэй.

Тохирох залгаврыг (ын, ийн, ыг, ийг) залгаж бичээд ярилцаарай.



7. Зөв харгалзуулан холбож өгүүлбэр зохиогоорой.





8. Тохирохыг залгаарай. (-ИЙН, -ЫН)



9. Зөвийг тэмдэглээд тайлбарлаарай.



10. Тохирох залгаврыг залган холбоо үгтэй харгалзуулаарай.



1. Яагаад мэргэжил бүхэн өөр өөр үнэртэй байдаг вэ?
2. Шүлгийг уншихдаа онцолсон үгийг анхаарч уншаарай.



### Мэргэжлээс юу ханхалдаг вэ?

Мэргэжил үнэрээрээ

Мэдэгдэнэ дээ, төвөггүй

Талхчин үнэрээрээ

Танигдана даа, андашгүй

Мужааны дэргэдүүр

Өнгөрөх зуур

Мушгирсан зоргодос

Ханхлах болно

Будагчны бийрээс

Будаг ханхална

Ажилчны хүрэмнээс

Тос ханхална

Шатахууны үнэр

Жолоочоос ханхална

Шаваас наалт

Шилчнээс ханхална

Чихрийн үйлдвэрээс

Чихэр ханхална

Эмнэлгийн газраас

Эм ханхална

Хөрс шороо

Тариачнаас ханхална

Хөх далай

Загасчнаас ханхална

Арчаагүй залхуу хүнээс

Ажлын үнэр ханхалдаггүй

Аливаа үнэртнийг цацавч

Амьдралын үнэр гардаггүй



**зоргодос:**  
юмыг зорох,  
харуулдахад  
гарах зомгол

(Жанни Родари)

3. Шүлгийн талаар бусдаас асуулт асууж ярилцаарай.
4. Чи ямар мэргэжилтэй хүн болохоо найздаа яриарай.
5. Сонгосон хэсгийг тайлбарлаад дэвтэртээ бичээрэй.

Арчаагүй залхуу хүнээс ажлын үнэр ханхлахгүй

Аливаа үнэртнийг цацавч

Амьдралын үнэр гардаггүй.

6. Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.



Мужаанаас.....

Жолоочоос .....

Эмчээс .....

Загасчнаас .....

Залхуугаас .....



7. –ыг, ийг, ын, ийн” залгаврыг зөв бичээрэй.

### Шоргоолж

Шоргоолж (-ыг, ийг) эрүү сарвуу хөлөөрөө шороо ухаж үүрээ засдаг (-ыг, ийг) мэдэх үү? Шоргоолж сахлаа хөдөлгөж зүг чигээ, бас хоол тэжээлээ олдог гэнэ. Шоргоолж өт хорхой шавж (-ыг, ийг) иддэг учир ой цэвэрлэгч гэдэг. Газар (-ын, ийн) хөрсөн доор 6 метр гүнд 2 давхар байшин шиг үүр барьдаг.

1. Хэнд мэндчилгээ бичихээ эргэцүүлэн бодоорой.

- найздаа
- аавдаа
- ээждээ
- ах, эгчдээ
- багшдаа

Ээждээ мэндчилгээ  
бичихийн тулд  
баримт цуглуулах



- Хүмүүсийн бичсэн мэндчилгээг олж унших
- Бусадтайгаа зөвлөж ярилцах
- Сонин, сэтгүүл, номоос мэндчилгээ олж унших
- Телевиз, радиогоор мэндчилгээ сонсох

2. Мэндчилгээ бичихдээ ашиглах үгс:

(баярын мэнд, аз жаргал, эрүүл энхийг)

Ээждээ бичсэн мэндчилгээ



өдрийн  
баярын



1. Номинжин охины анхны бичсэн мэндчилгээг ажиглаад ярилцаарай.



### Мэндчилгээ

Хайрт аав ээждээ ирж  
байгай шинэ оны мэнд  
хүргэж эгцүл энэ аз  
жаргал хүсий.  
Охин Номинжин

2. Номинжин охины засаж сайжруулсан мэндчилгээг ажиглаарай.

3. Ойр дотны хүмүүстээ мэндчилгээ бичээрэй. Мэндчилгээ бичихдээ ашиглах үгс: (аз жаргал, мэнд хүргэе, ажлын амжилт, хүсэн ерөөе)

### Мэндчилгээ

Мэндчилгээ  
Хайрт аав, ээждээ ирж  
байгаа шинэ оны мэнд  
хүргэж, эгцүл энэ аз  
жаргал хүсье.  
Охин Номинжин



мэндчилгээ  
хүргэе




## 1. Хэнд талархал бичихээ эргэцүүлэн бодоорой.

- эмчдээ ✓
- тогоочдоо
- багшдаа
- найздаа



- Хүмүүсийн бичсэн талархлыг унших.
- Санал бодлоо хэн нэгэнтэй солилцох.



### Талархал бичихдээ:

- Хэнд бичиж байгаа
- Талархаж байгаагийн учир
- Талархлыг бичсэн хүний нэр
- Он сар өдөр


### Талархал

### Баяням овогтой Оргилд

Нэгдүгээр сургуулийн 2-р ангиудын дунд явагдсан зөв цэвэр бичгийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн тул ангийн хамт олны зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

*1-р сургуулийн 2<sup>a</sup> ангийн хамт олон*

## 2. Зургийг ажиглаад, эмчид талархал бичих болсон шалтгааныг ярилцаарай.



### Талархал

### Эмч Б.Солонгод

Миний шүдийг эмчилж, эрүүл болгож, зөвлөгөө өгсөн явдалд баярлаж талархсанаа илэрхийлье.

*50-р сургуулийн 2 дугаар ангийн сурагч Б.Чанцал*

1. Уншаад, хуулж бичээрэй.



### Талархал

Чимлэлт эгч тандар  
Хүүхэд бидний сурах орныг  
цэвэр цэцэрлэг байлгалж, ур-  
галж элдэв сайхан харимцал  
явдалд талархаж байгаагаа  
илэрхийлье.

2-а ангийн сурагчид  
2013 оны 10 сарын 10

2. Тохирох үгийг нөхөж, талархлыг гүйцээж бичээрэй.

### Талархал


Хайрт ..... тандаа

Намайг үргэлж дэмжиж ..... байдагт чинь баярлаж  
..... илэрхийлье.

Таны ач охин Б.Хулан

2013 оны 11 дүгээр сарын 1

3. Зургийг ажиглаад дараах үгсийг ашиглан талархал бичээрэй.  
(баярлаж талархсанаа, чин сэтгэлээсээ, илэрхийлье)




талархал  
илэрхийлье

## ЮУ ЧАДДАГ БОЛСНОО ЭРГЭН САНАЯ

1. Загасчин туулайд үгийг бүлэглэн бичихэд нь туслаарай.

мэргэжлийн нэр	хичээлийн хэрэглэл	төл малын нэр	гэр бүлийн гишүүд
.....	.....	.....	.....



2. Тайлбарлан бичээрэй.



Юу мэдэх вэ?

.....  
 .....  
 .....



Юу мэдэх вэ?

.....  
 .....  
 .....

3. Үдийн цайнд хэрэглэдэг бүтээгдэхүүний зааврыг уншаад ярилцаарай.

4. Загварыг ажиглан гүйцээж бичээрэй.

### Товч анкет бөглөх загвар


1. Овог ..... нэр .....
2. Төрсөн он..... сар ..... өдөр .....
3. Регистрийн дугаар .....
4. Нас .....
5. Хүйс .....
6. Гэрийн хаяг: .....



5. Өгөгдсөн үгийг ашиглан сүүний үйлдвэрийн ах , эгч нартаа талархал бичээрэй.  
(баярлаж, илэрхийлье, талархсанаа)

**Талархал**

6. Төл малыг нэрлэж, ээждээ очих ишгэнд туслаарай.



7. Хүнсний ногооны зураг зураад, нэрийг нь бичээрэй.



лууван .....

8. Өгөгдсөн үгийг ашиглан, замын хөдөлгөөнд оролцох заавар бичээрэй.



Ашиглах үгс:

шар гэрэл, анхаарах, ногоон гэрэл, улаан гэрэл, зорчих, дохио, гарц

Гарцаар гарахдаа:

.....

.....


.....

.....

.....

.....

9. Бэлгэдлийн үгийг нөхөж бичээрэй.



10. Хичээлийн хэрэглэлийн нэрийг бичээрэй.

баллуур,

11. Илүүц үгийг олоорой.

цүнх, харандаа, дэвтэр, шугам, үзэг, хайч, цавуу, намар, будаг, баллуур, ном

12. Үгсийг бүлэглэн бичээрэй.

13. Нөхөж бичээд зөв харгалзуулаарай.





## 1. Шүлгийг гүйцээж уншаарай.

### Амьтны хүрээлэн

Амараа хүү аавтайгаа  
Амьтны хүрээлэнд очлоо  
Аварга том өргөгч шиг  
..... хүзүүгээ сунгана  
Араатны хаан .....  
Архирч зогдроо хийсгэнэ  
Адтай .....

Уутат ..... энүүхэнд  
Ууртай нь аргагүй дэвхэцнэ  
Эрээн ..... энүүхэнд  
Эрэмгий янзтай цавчилна  
Зурагт, кино, номноос л  
Зөндөө харсан амьтдаа  
Амараа хүү энд ирээд  
Амьдаар нь ойроос харлаа  
Г.Түмэнбаяр







#### Гүйлгэн уншихдаа:


- Зургийг ажиглаад амьтдын нэрийг бичнэ.
- Мөр, мөрөөр нь ойлгон уншина.
- Цэгийн оронд ямар үг байхыг төсөөлөн бодоод олно.














аварга  
зогсоно





зогдор - хүзүү,  
хоолойд ургасан  
урт үс, хялгас

## 2. Төсөөлөөрэй.

### Юу байж болох вэ?

- Уутандаа үрээ тээж явдаг амьтан
- Өргөгч цамхаг шиг өндөрт сунадаг өвөрмөц нэгэн амьтан
- Архирсан дуутай араатны нэр
- Шилэн хоргонд сэлж амьдардаг амьтан
- Урт хошуутай, урт сүүлтэй амьтан юу байж болох вэ?

### Төсөөлөхдөө:

Өгүүлбэрийг уншаад зан төрх, дуу авиа, давтагдашгүй онцлог шинж нь ямар амьтанд байж болох вэ? гэдгийг бодно.

### Үлгэрлэвэл:

Сэлдэг гэхээр усны амьтад байна. Шилэн хоргонд амьдардаг гэхээр загас байна.



## 3. “Амьтны хүрээлэн” шүлгээс амьтдын зан төрхийг дүрсэлсэн хэсгийг сонгон уншаарай. Үлгэрлэвэл:


... Аварга том өргөгч шиг  
Анааш хүзүүгээ сунгалаа

...Уутат имж энүүхэнд  
Ууртай нь аргагүй дэвхцэнэ

## 4. Амараа ямар, ямар амьтан харсан бэ? Бичээрэй.

Эхлээд анаашийг харсан. ....  
.....

## 5. Хөндлөн нүднүүдэд 4 амьтны нэрийг зөв бичвэл будсан хэсэгт өөр амьтны нэр үүснэ.




Багшийг сонсоод бичээрэй.

Олон **олс**, хулс  
Өлөн **барс**, хярс



### 1. Монголын хамгийн том амьтан юу вэ?



### 2. Яагаад том амьтан гэж төсөөлснөө бичээрэй.

амьтдын тухай	тайлбар
заан	Хүнд жинтэй, бас надаас өндөр болохоор өөртэйгөө харьцуулаад том гэж сонгосон. 3,5 метр өндөр
баавгай	Асар том харагддаг, хүрхрэх дуу нь сүртэй, хөл нь маш том, босоод алхахдаа хүнээс хамаагүй өндөр болохоор хамгийн том амьтан гэж сонгосон.
	Монголын ой тайгад амьдардаг.

### 3. Асуултын дагуу ярилцаарай.

- Сэрвээ, амьтны биеийн аль хэсэгт байдаг вэ?
- Мал амьтны хүзүүнд ургасан зүйлийг юу гэдгийг ярилцаарай.
- Усыг халгиана цалгиана гэхээр яах вэ?


### 4. Хамгийн том амьтныг төсөөлж бодоод уншаарай.

.....

Монголын хамгийн том амьтан бол ..... юм. Түүний өндөр нь сэрвээгээрээ 2 метр хүрнэ. Жин нь 500-600 кг, хүзүүндээ зангидсан гарын чинээ молцогтой. Эрийг нь манж, эмийг нь сүндэс, үр төлийг нь хотол гэнэ. Эр нь далбайсан хавтгай эвэртэй. Зун нуурын уснаас салдаггүй. Хангай шиг биетэй амьтад нуурын усыг эргийг нь давтал халгиан цалгиан үсэрч ороод усны гүнд загас мэт удаан байж чадна. .... усанд сэрүүцэх гэж биш нуурын ногоон замгийг идэх гэж шумбаад замгаа амандаа зуучихсан тун ч жаргалтай хөвж явдаг гэнэ. .... туйлын гэнэн, юмыг заавал үнэрлэж байж санаа амардаг.

5. Монголын хамгийн том амьтан энэ мөн үү?

- Ямар амьтан байна вэ?
- Зураг дээрх үгсийг толиос харж ярилцаарай.
- Утгыг нь мэдсэн үгээ бичээрэй.



6. Уншсан эхдээ тохирох гарчгийг сонгоорой. (✓)

- Тэмээ
- Заан
- Хандгай

7. Хандгай эхийг давтан уншаарай.

8. Үгсийг ашиглан өгүүлбэр зохиогоорой (анааш, хөх халим, могой, эрвээхэй, тэмээн хяруул, заан)

Асуусан өгүүлбэр	Хүүрнэсэн өгүүлбэр

#### Аргачлал:


- Уншихаасаа өмнө зураг болон мэдээллүүдээс ургуулан бодоорой.
- Унших явцдаа амьтдын онцлогийг сэтгэлдээ зураглан мэдэрч уншаарай.
- Өгүүлбэр зохиохдоо өөрийн төсөөллийг санаарай.

9. Асуух үгийг нөхөж бичээрэй.


Монголын хамгийн (ямар?) амьтан (юу нь?) хоёр метр өндөр, таван зуугаас зургаан зуун килограмм (ямар?) жинтэй

10. (могой, заан, анааш, хөх халим, аалз, бар) амьтдыг өндрөөс нам руу, хүндээс хөнгөн рүү жагсаан бичээрэй. Үлгэрлэвэл:

Анааш халимнаас өндөр  
Хар халим юунаас том бэ? гэх мэт.



1. Юу мэдэх вэ? Ярилцаарай.



2. Юуны тухай ярилцсанаа дараалан бичье. Бичихийн тулд төлөвлөгөө гаргая.

- Яст мэлхийн гадаад төрх, онцлог шинж чанарын тухай
- Яст мэлхий юугаар хооллодог, хаана амьдардаг, яаж өсөж үрждэг тухай
- Яст мэлхийг хүмүүс юу гэж бэлгэшээдэг тухай.

3. Цэлмүүн төлөвлөгөөний дагуу ингэж бичжээ.



Яст мэлхийн бие нь ясан хуягтай, удаан хөдөлгөөнтэй амьтан юм. Тэр усанд амьдардаг. Олон олон өндөг гаргадаг. Хүмүүс түүнийг урт насалдаг болохоор нь бэлгэшээдэг.

4. Мэдээллийг уншаад, бичсэнээ засаж сайжруулаарай.


**Яст мэлхий**

Яст мэлхий нь хоёр нутагтан амьтан юм. Гадуураа ясан хуягтай, богино хөлтэй, удаан хөдөлгөөнтэй амьтан юм. Яст мэлхий их урт насалдаг, тайван амгалан тул хүмүүс эрүүл энхийн бэлгэдэл гэж үздэг. Яст мэлхий олон жижиг өндөг гаргаад элсэнд булж орхидог гэнэ. Өндгүүд хагарч ус руу явна. Энэ үед шувууд түүнийг шүүрчихгүй бол амьд үлддэг ажээ. Харин яст мэлхий шүдгүй байдаг гэнэ. Хачин байгаа биз? Гэсэн ч тэр хооллохдоо ер зовдоггүй гэнэ. Учир нь түүний эрүүний яс маш хурц байдаг.

5. Төлөвлөгөө зохиож бичээрэй.

Ямар ямар баавгай байдаг вэ?		Баавгай ичдэг гэдгийг мэдэх үү? Яагаад?	.....	
Юугаар хооллодог вэ?		Хаана амьдардаг вэ?	.....	
Ямар онцлогтой вэ?		.....	.....	

6. Бичсэнээ найздаа уншиж өгөөд засаж сайжруулаарай.








Чамаас хүн асуулт  
асуувал чи яах вэ?

Мэддэг зүйлээ  
хариулна.



Энэ нь хүүрнэсэн  
өгүүлбэр болно.



### Хурдан уншихын тулд:

- Эхлээд заагласан үгээр нь нэг харалтаар өгүүлбэрүүдийг уншина.
- Дараа нь нэг харалтаар бүтэн өгүүлбэрээр нь уншина.
- Эцэст нь харилцан яриаг давтан уншина.

асуулт	хариулт
- Та надад   бөжингийн тухай   юу ярих гэсэн юм бэ?	- Соёо цагаан шүдтэй,   соотон чихтэй бөжин   оо, сойз хоёрыг   огт хэрэглэж үзээгүй гэнэ.
- Хүүе! Одоо яана аа.   Хэлдэг хүнгүй юм уу?	- Ухаантай ээж нь түүнд   учирлаж дандаа хэлэхэд нь   уурлаж чарладаг зантай гэнэ.
- Туулайн бяцхан бөжин   чихэр бас идэх үү?	- Угаалгүй идсэн лууван   чихрээс ч доор гэсэн үг.
- Үг дуулдаггүй   бөжингийн   үүдэн шүд нь   өвдсөн болов уу?	- Өвдөж зовоогоод   болохгүй болохоор   эмчид очжээ.

### 1. Асуултын дагуу ярилцаарай.

- Бяцхан бөжин яах бол? Яагаад...
- Бөжин та хоёр юугаараа адил байна вэ?

### 2. Бөжингийн зан төрхийг илэрхийлсэн хэсгийг сонгож бусдадаа уншиж өгөөрэй.

### 3. Харилцан яриаг хос хосоороо дахин давтан уншаарай.

- Уншингаа ямар гэсэн асуултад хариулагдах үгсийг тэмдэглээрэй.

### 4. Дээрх ярианаас юуг чухал гэж үзсэн бэ? Яагаад?


### 5. Харилцан яриаг үргэлжлүүлэн бичээрэй.

.....

.....



### 1. Ярилцаад, хуулж бичээрэй.



### 2. Ойлгож уншаарай.

#### **Зөвлөмж:**

- Ойлгохын тулд хурдан уншаарай.
- Мэдэхгүй үгээ тэмдэглэж уншаарай.
- Ойлгоогүй хэсгээ давтан уншаарай.

#### **Санамж:**

Зарим хүүхдүүд чанга дуугаар амаа хөдөлгөн дахин давтан үг, үгээр нь буруу уншдаг.

### 3. Зөвлөмжийн дагуу үлгэрийг ойлгож уншаарай.



#### **Гурван найз** (Монгол ардын үлгэр)

Нэгэн голд ухаантай, тэнэг, зальтай гурван загас байж гэнэ. Гэтэл нэгэн удаа тэр голын хөвөөн дээр загасчид иржээ. Тэгтэл тэнэг загас “Юу л болов гэж дээ” хэмээн бодож байхад, зальт загас “За, харж л байж больё. Ер нь амь гарахаа бодъё” гээд үхсэн мэт хөвж гарав. Харин ухаант загас тэрхэн зуур шууд л усны гүн рүү шумбан одов.

Загасчид голд тороо тавилаа. Загасчин зальт загасыг барьж аваад тор давуулан шидэхэд тэр бушуухан усанд шумбан алга болов. Харин тэнэг загас ийш тийш хөвсөөр яваад баригджээ.

Үүнтэй нэгэн адил учрах зовлон бэрхшээлийг урьдчилан мэдэж, зайлан гарах арга замыг зөв сонгох ухааныг сурах нь бага насанд сурах эрдмийн нэг юм.

Ямар ч хүнд хэцүү цагт ухаантан ухаанаар шийдэж, зальтан арга сүвэгчилж, эвээр тэмцдэг. Харин мунхаг хүмүүс гурав дахь загастай адил байдаг ажээ.

### 4. Асуултын дагуу ярилцаарай.

- Тэмдэглэж уншсан үгээ тайлбарлаарай.
- Аль хэсгийг давтаж уншсан бэ? Яагаад?
- Давтан уншсан хэсэгтээ асуулт зохиогоорой.

1. Онъсогыг таагаарай.

Монгол газрын молтогчин  
Модон дээгүүр дүүлэгчин  
(тэр юу вэ?)

Сувдаг саарал  
(тэр юу вэ?)



2. Онъсогыг таахдаа асуултын дагуу ярилцаарай.

- Молтогчин гэхээр туулай юм болов уу?
- Туулай шиг жижиг амьтан юм болов уу?
- Модон дээгүүр дүүлдэг юу байж болох вэ? Төсөөлөн бодоод таагаарай.

Сувдаг гэсэн үг ямар утгатай үг вэ? толь бичиг хараарай. Саарал өнгөтэй ямар амьтан байж болох вэ?

**Баатрыг төсөөлөх арга**

- Нүдээ аниад баатрыг төсөөлөн бодно.
- Төсөөлөн бодсоноо ярилцана.
- Бусдын төсөөллийг сайн сонсоно.



3. Ямар амьтдын тухай онъсого байсан бэ?

4. Унших зохиолын баатрын талаар хэрхэн төсөөлснөө бичээрэй.

Баатраа төсөөлөхдөө:

Ямар? чихтэй

Ямар? зан төрхтэй

Ямар? нүдтэй

Ямар? зүстэй гэх мэтээр төсөөлөөрэй.



Миний унших зохиолын баатар бол.....

Энэ бол тэдний зураг

Түүний талаар миний мэдэх зүйл.....

Амьдрах орчин.....



## 1. Өгүүллэгийг уншихдаа төсөөлөн бодсоноо санаарай.



### Хэрэм чоно хоёр

Хэрэм модноос модонд үсэрч дүүлж яваад нойрмог чонон дээр ойчжээ. Чоно огло харайн барьж аваад, идэхээр завдтал хэрэм:

- Намайг тавиач гэж гуйв. Чоно:

- За би чамайг тавья. Харин чи, хэрэмнүүд та нар яахаараа ингэж дандаа хөгжилтэй байдгийг хэлчих. Би үргэлж уйтгарлаж байдаг юм. Та нарыг харахад эрхлэн наадаж, үсрэн дүүлж байх юм гэв.

Хэрэм: “Юуны түрүүн намайг мод руу тавьчих. Тэнд очоод би учрыг хэлье. Дэргэд чинь байхаар айгаад байна” гэв. Чоно түүнийг тавихад тэр хэрэм модонд үсрэн гарч тэндээсээ:

- Чи санаа муутай, уур хилэн чинь буцалж явдгаас уйтгартай байгаа юм. Бид сайхан сэтгэлтэй, хэнд ч гэм хийдэггүй болохоор хөгжил баясгалантай явдаг юм гэж өгүүлжээ.

## 2. Хэрэмний хэлсэн үгийг гүйцээж бичээрэй.

Бид ..... хэнд ч ..... явдаг юм гэж өгүүлжээ.

## 3. Өөрийнхөө төсөөллийг үлгэрийн баатартай харьцуулаарай.

## 4. Хэрмэнд хууртсан чоно яасан бэ? Үлгэрийн төгсгөлийг үргэлжлүүлэн төсөөлөн бичээрэй.



Чоно хэрмэнд хууртана гэж бодоогүй.

.....  
.....





### Баатрыг төсөөлөн бичихдээ:

- Өөрийн бодсоноо бичнэ.
- Бичсэнээ ярина.
- Засаж баяжуулна.



хэлье  
тавья  
үсэрье  
харайя  
наадья

1. Баавгай, хэрэм хоёр ямар тэмцээн зохиосон бол? Төсөөллөө хуваалцъя.



2. Өгүүллэгийг бусдад тод, чанга уншаарай.

### Ер бусын тэмцээн



Хэрэм, баавгайг “Өвлийн бэлтгэлээ өрсөн хийе” гэж ойн амьтдын өмнө уралдаанд уриалжээ. Харин баавгай

- Өөдөсхөн жаахан хэрэм чи очиж, очиж надтай уралдах гэж үү дээ гэж онгиров.

Ажилсаг хэрэм үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл модноос мод дамжин, мөчрөөс мөчирт дүүлэн өвлийн бэлтгэлээ базааж байлаа. Гэтэл майга бор өдөржин ой тайгаар хэсэн дэмий сэлгүүцнэ.

Зүгээр ч байхгүй шоргоолжны үүр хөндөн төвөг учруулна.

Нэг мэдэхэд цас орж тэмцээн дүгнэхэд ганцхан өдөр үлдсэн байлаа.

- Маргааш болтол лай ч байна, зай ч байна. Бага сага юм базааж авдаг хэрэг ээ хө! гээд уул хад дамжин аахилан харайлгаж гарлаа.







Жаахан самар олов. Дайралдсан мод бутыг суга татан хуга алгадан унагаж байв. Самар зөвхөн хуш модонд л ургадаг шүү дээ! Ой мод сүйтгэлээ гэж шүүгчид баавгайг зэмлэв. Ажилсаг хэрэм тэмцээнд аргагүй л түрүүлжээ.

Баавгай өвлийн хүнсээ зэхээгүй өлсөөд ичээндээ тухтай унтаж чадахгүй чичрэн тэнэж явав. Тусч хэрэм хөвчид амьдардаг бүх найзаа цуглуулаад баавгайд туслах санал гаргажээ. Олон хэрэмний бага багаар цуглуулсан самар зөндөө их болж баавгай өлсөж үхэх аюулаас аврагдлаа. Тэр цагаас хойш ойгоор дэмий тэнэхээ больж бяцхан найзуудтайгаа тоглон наадаж өөдөсхөн бага гэж шоолбол уурладаг болсон гэнэ.

З.Далхжав

3. Асуултын дагуу үйл хөдлөлийг сонгоод, давтан уншаарай.

- Хэрэм, баавгай хоёр ямар тэмцээн зохиосон бэ?
- Тэмцээнд хэн түрүүлсэн бэ? Яагаад?

4. Асуултын дагуу хуулж бичээрэй.

- Баавгай, тэмцээн дүгнэхэд, нэг хоног дутуу байхад юу гэж хэлж байсан бэ?

Маргааш болтол .....

5. Амьтад өвөлдөө хэрхэн бэлтгэснийг бичээрэй.

хэрэм	баавгай

6. Ажилсаг хэрмийг дүрслэн бичсэн хэсгийг хуулж бичээд, үеэр зааглаарай.

7. Загварт тохирох үг өгүүллэгээс хоёр хоёрыг бичээрэй.

чи	хэрэм	бэлт гэл лээ
<input style="width: 60px; height: 20px;" type="text"/>	<input style="width: 60px; height: 20px;" type="text"/>	<input style="width: 60px; height: 20px;" type="text"/>

8. Баавгай өөрчлөгдсөн үү? Ямар сэтгэгдэл төрж байна вэ?

**Үнэлгээ:** Асуултын дагуу сонгон уншаад өөрийгөө үнэлээрэй. 😊 😐 😞

- Хэрэм, баавгайн зохиосон тэмцээн юу вэ?
- Ямар учраас хэрэм тэмцээнд түрүүлсэн бэ?

1. Үлгэрийг бүхлээр нь уншаарай.

## Саргай цэцэг болжмор хоёр

(сургамжит үлгэр)



Алсын уулнаас хотын цэцэрлэгт нэгэн болжмор нисэж ирээд.

- Танай энд сайхан байна. Жийв жийв! Саргай цэцэг бутаараа цэцэглэжээ. Жийв жийв! Өтгөн сагсгар саргай цэцэг минь чамтай найзалъя гэж гуйж гэнэ.

- Чиний магтаал надад хэрэггүй. Чамтай нөхөрлөөд ч ашиггүй. Бүхэл шөнөдөө тэнгэрийн од намайг ширтэж байдаг. Сар над руу гэрлээ тусгаж, өглөө бүр алтан гургалдай уран хоолойгоороо миний дэргэд дуулдаг.

Тэгэхэд болжмор чи өөрийгөө юу гэж бодно вэ? Өд сөд чинь сагсайгаад ямар үзэмжгүй юм бэ? Чамаас муухай үнэр ханхалж байна. Хошуунд чинь шавхай шавар наалджээ. Фу! Фа! Цаашаа тонил! гэж саргай цэцэг болжморгийг хөөв. Болжмор дахин юу ч хэлсэнгүй нисэж одов.

Саргай цэцэгтэй хамт амьдрахыг эртнээс хүссэн өөр нэг амьтан байдаг ажээ. Тэр нь бор ногоон өнгөтэй төөлүүр хорхой юм. Төөлүүр хорхойд цэцгийн дэлбээ идэхэд амтлаг, дээр нь хэвтэхэд зөөлөн байдаг гэнэ.

Саргай цэцэгэн дээр төөлүүр хорхойг ирж сууснаас хойш түүний дэлбээ бараг үгүй болжээ. Нэг өдөр нөгөө болжмор цэцгийн дээгүүр нисэн өнгөрөхдөө үүнийг ажиглаж мэдээд

- Ах дүү нар аа нааш ирээрэй! Энэ саргай цэцэгэн дээр суусан төөлүүр хорхойг устгая! Жийв, жийв! гэж жиргэн дуудав. Болжморууд дорхноо цугларч төөлүүр хорхойг нүд ирмэх зуур устгав.
- Та нарт баярлалаа. Сайн санаатнууд зовлонгоос ангижруулж ач тус болдог юм байна гээд саргай цэцэг болжморт талархал илэрхийлээд дахин ургаж эхэлжээ.



2. Үлгэрийн хэсгийг сонгон уншаарай.

Болжмор саргай цэцэгтэй  
уулзаж буй тухай

Саргай цэцэг ургахгүй  
болсон тухай

Саргай цэцэг болжморт  
хэлсэн үгийн тухай



3. Асуултын дагуу ярилцаарай.

- Болжмор саргай цэцгээс юу гэж гуйсан бэ?
- Саргай цэцэг болжморт яаж хандсан бэ?
- Саргай цэцэг яагаад гандсан бэ?
- Болжморт талархал илэрхийлсний учир юу вэ?

4. Загварыг ашиглан болжморт зориулсан талархал бичээрэй.

*Талархал*

**Сайхан сэтгэлт болжморт**

Дахин ургахад минь ач хүргэсэн болжморт чамдаа баярлалаа.

*Талархал бичсэн Саргай цэцэг*

*Талархал*

5. Үлгэрийг уншаад ямар сургамж авсан бэ? Ярилцаарай.

6. Зөв хариултыг уншаад тэмдэглээрэй. ☑

Саргай цэцгийн дэлбээ яагаад үгүй болсон бэ?

- Саргай цэцэг ууртай байсан.
- Төөлүүр хорхой ирж сууснаас болсон.
- Болжморт төөлүүр хорхойг устгасан.


**Сэргээн санаарай**  
хүүрнэх өгүүлбэр (.)  
асуух өгүүлбэр (?)



7. Үлгэрээс сонгон бичээрэй.



Би чамтай найзалж болох уу?



.....

.....

..... ?

Миний дэлбээ яагаад ургахгүй байна аа?

Зовлонгоос ангигруулж тусалсан болжморт танд баярлалаа.



# ЕРТӨНЦИЙН ГУРАВ УНШИЖ, ЗОХИОЦГООЁ

1. Дараах шүлэглэсэн эхийг уншаарай. Хэдэн мөрөөс бүтсэн байна вэ?

Аав ээжийн сургаал нэг сайхан  
Атар газрын цэцэг нэг сайхан  
Арван тавны сар нэг сайхан

2. Мөр бүрийн утгыг ярилцаарай.

3. Арван тавны сар аль нь вэ? Тэмдэглээрэй.




4. Бидний уншиж ярилцсан зүйл оньсого уу, таавар уу, үлгэр үү, ертөнцийн гурав уу? Ярилцаарай.

5. Ертөнцийн гурвыг уншаад ярилцаарай.



Эд хөрөнгө адаг баян




6. Зөв харгалзуулаарай. Бадаг бүр дэх үгийг адилтгавал яаж харгалзах вэ?

тодруулсан үг	биеийн хэсэг	тоон дараалал
адаг	толгой	1
дунд	их бие	2
дээд	сүүл	3



7. Цээжилснээ бичихдээ орхигдсон үгээ нөхөж, зөв дараалалд оруулан бичье.



1. Аль нь болохыг сонгоорой.  Яагаад?




Идээний эх цай  
Эдийн эх хадаг  
Амьтны эх загас

?

- зүйр үг
- ертөнцийн гурав
- оньсого



2. Ертөнцийн гурван түлхүүрийг дараалал тогтоох аргаар бичнэ.




**Дараалал тогтоох арга**

- Дараалал тогтоох үгээ бэлдсэн байх
- Загварын дагуу байрлуулах
- Өгүүлбэр том үсгээр эхлэхийг санаарай.
- Зөв эсэхийг уншиж шалгах



3. Асуултын дагуу хосоороо ярилцаарай.

- Түлхүүр гэдэг чинь хаалга онгойлгодог түлхүүр мөн үү?
- Агаарыг яагаад амьдралын түлхүүр гэсэн бэ?
- Ажиллахын түлхүүр юу вэ?
- Багш юуны түлхүүр вэ? Яагаад?



4. Дарааллаар нь зөв байрлуулсан эсэхээ тулгах.




**идээ**-идээ унд,  
идэх юм  
**эд**-эдэлж  
хэрэглэдэг зүйл





*Амьдралын түлхүүр агаар  
Ажиллахын түлхүүр ухаан  
Эрдмийн түлхүүр багш*





1. Улаан, хөх хоёр харандаа өөрсдийнхөө өнгөөр гурав гурван зураг зурлаа.



Нар, гал, улаан гэрлэн дохио зурав.



Тэнгэр, гол, хадаг зурав.



2. Зурсан зургуудаар нь ертөнцийн гурвыг зохиоцгооё.

3. Улаан харандааны зохиосон ертөнцийн гурвыг гүйцээн бичээрэй.

Нөхөх үгс (гал, гэрлэн дохио, нарны)

#### ЕРТӨНЦИЙН ГУРВАН УЛААН

Ургах ..... туяа нэг улаан

Улалзан асах ..... нэг улаан

Урагшаа бүү яв гэсэн ..... нэг улаан

4. Хөх харандаа зурсан зургаараа ертөнцийн гурван хөхийг зохиожээ. Хөх харандааны зохиосон ертөнцийн гурвыг гүйцээн бичээрэй.


Нөхөх үгс (гол, тэнгэрийн, хадаг)

#### ЕРТӨНЦИЙН ГУРВАН ХӨХ

Дээд ..... өнгө нэг хөх

Дэргэдүүр урсах ..... нэг хөх

Дэлгэн барих ..... нэг хөх



Хоёулаа  
ертөнцийн гурвыг  
зохиож чадлаа  
шүү.

Тиймээ.  
Ёстой гоё.



5. Цагаан, хар, ногоон өнгөөр ертөнцийн гурав зохиогоорой.





1. Уншаад ойлгосноо бусдад тайлбарлана.
2. Залхуу хүн яагаад дандаа маргааш гэдгийг ярилцаарай.




Залхуу хүнд  
Маргааш олон



.... ?

3. Үгийг зөв байрлуулан зүйр үг бүтээгээрэй.
4. Мөр мөрөөр нь уншиж утгыг тайлбарлаарай.




5. Зүйр үгийн учрыг тайлбарлаарай. Ертөнцийн гурваас ямар ялгаатай байна вэ?
6. Цэвэр сайхан хуулж бичээд, эр үгийг цэнхэр өнгөөр, эм үгийг ягаан өнгөөр будаарай.

### Зүйр үгийн тайлбар бичихдээ:

1. Өөрийн бодлоо бичнэ.
2. Бусдын бичсэнийг сонсож санаа авах.
3. Засаж сайжруулах.

Далай хязгааргүй  
Эрдэм оройгүй

**Далай** - их хэмжээний ус учраас хязгааргүй гэсэн.  
**Эрдэм оройгүй** - дээд оргил гэж байхгүй, сурсан бүхэн эрдэм




өөрийн тайлбар:

.....  
.....

толь бичгийн тайлбар:

Хүн өөрөө хичээж чадвал амжилтад хүрдэг.



1. Зургийн нэрийг бичээрэй.




.....




.....



.....




.....





.....



.....



2. Харьцуулаад ярилцаарай.



3. Нөхөж бичээрэй.

Тэнгэр ..... дутуу ..... баганаар дутуу  
 Далай ..... дутуу ..... бүлүүрээр дутуу  
 Уул ..... дутуу ..... бүслүүрээр дутуу



Тэнгэр баганаар дутуу  
 Далай бүлүүрээр дутуу  
 Уул бүслүүрээр дутуу


4. Бичсэнээ уншаад тогтоогоорой.

5. Сурагчдын төсөөллийг дуурайн зохиогоорой.

Литан номын үсэл нэг сайхан  
 Ариун үйлсийн зүтгэл нэг сайхан  
 Анд найдрын сэтгэл нэг сайхан  
 П.Нашин-Эрдэнэ

Урсаж байгаа голын ус хар  
 Умаж байгаа өвсний өнгө хар  
 Урлаж байгаа модны үндэс хар  
 М. Энхрийлаа

1. Ертөнцийн гурвыг уншаад утгыг нь ойлгохгүй үгийг толь бичиг ашиглаарай.



Тагтад ургасан арц нэг ногоон  
Тайгад ургасан хуш нэг ногоон  
Талд ургасан **зээргэнэ** нэг ногоон

Тодруулсан үгийн утгыг толиос олж мэдье. Тольтой ажиллах алхмуудаа санаарай.

Толь ашиглах аргаа ярилцъя.

АЛХАМ 1

Ертөнцийн гурваас ..... ойлгохгүй ..... ялган тэмдэглэнэ.

Тагтад ургасан арц ...  
Тайгад ургасан хуш ....  
Талд ургасан **зээргэнэ** ....

АЛХАМ 2

Тэмдэглэсэн ..... дэвтэртээ ..... бичнэ.

*талт - уулын арц*  
*тайга - өтгөн шилүү ой*

АЛХАМ 3

..... бичгээс ..... үсгээр хайж олно.

АЛХАМ 4

Толь ..... уншсан ..... тайлбарыг дэвтэртээ бичнэ.

*Усны ёроолд замал нэг ногоон*  
*Ууланд ургадаг ганцуур нэг ногоон*  
*Утаж ариусгадаг арц нэг ногоон*

АЛХАМ 5

Тэмдэглэсэн үгээрээ ..... зохионо.

*Ой тайгад цас их унадаг.*

Бид сая тайлбар эх бүхий тольтой ажиллалаа. Үүнээс гадна зурагт тайлбар толь байдгийг санаарай.

тайга - битүү,  
шигүү ой

Тайлбар эх бүхий  
толь



Зурагт тайлбар толь

2. (цагаан, цэнхэр, ногоон, шар, улаан) үгийг ашиглаад ертөнцийн гурав зохион бичээрэй.

## 1. Оньсого таалцъя найзууд аа!

1. Аяган дотор алаг өндөг  
Тэр юу вэ?



За хө, аяга гэхээр...  
төсөөлөөд үзье. Би  
зурлаа.


Аяган дотор чинь  
өндөг байна гээд  
төсөөл дөө.



Аа, алаг өндөг шүү дээ. Талыг  
хараар будчихъя. Би таачихлаа. Та  
нар таасан уу? Таагаагүй бол миний  
зурсан зургийг ажиглаарай. Юутай  
төстэй харагдаж байна вэ?



## 2. Хүү оньсогыг яаж таасан бэ? Дарааллыг бүгдээрээ бичье.



3. Эрдэм номтой холбоотой оньсого  
таалцъя.

Цагаан талд хар үр тарина  
Хар үрээс хамаг ухаан дэлгэрнэ  
Тэр юу вэ?

## 4. Асуултын дагуу бодоорой.

- Цагаан тал гэж юу байж болох уу?
- Чи үр үзсэн үү? Ямар ямар үр мэдэх үү?
- Тэр үрийг цагаан талдаа суулгасан, суулгана гэж яахыг хэлэх үү?
- Яах гэж үр суулгадаг вэ?
- Хар үр байдаг уу?





- Будаа тарианы үрээс хамаг ухаан дэлгэрнэ гэсэн үг чинь юуг хэлж байна вэ?



- Будаа тарианаас хоол хүнс дэлгэрэх байх. Яагаад тэр вэ?
- Энэ цагаан тал цас байж болох уу?
- Цасан дээр мөр гаргахаар ямар сэтгэгдэл төрдөг вэ?
- Цасыг цагаан цаастай адилтгаж бодож болох уу? Яагаад?


5. Онъсогыг таагаад хэрхэн таасан тухайгаа ярилцаарай.

Эр ганц хүү  
 Эрдэнийн зүйлээр бөөлжинө (Тэр юу вэ?)  
 Балан хүү  
 Модон дээлтэй (Тэр юу вэ?)

6. Шүлгийг ойлгож уншаарай. Харандааг зохиолч Ж.Дашдондог яаж төсөөлөн бичсэнийг уншаарай.

ХАРАНДАА  
 Харандаа  
 Харандаа  
 Хорогдсоор  
 Хорогдсоор  
 Хамаг бие нь  
 Барагдсаар  
 Барагдсаар  
 Үсэг тоог минь  
 Бичүүлсээр  
 Бичүүлсээр  
 Үзсэн харсныг минь  
 Зуруулсаар  
 Зуруулсаар  
 Ээ хөөрхий  
 Нарийн биеэ дуусгалаа  
 Надад бүхнээ зориуллаа  
 Эрдэм сурахад тусаллаа  
 Эрэлхэг чамдаа баярлалаа

Ярилцаарай.




7. Шүлгээс санаа авч онъсого зохиоцгооё.

Үсэг тоог бичдэг  
 Нарийн биеэ дуустал  
 Надад чамд бүхнээ зориулдаг (Тэр юу вэ?)


1. Уншиж ойлгоод, асуултын дагуу ярилцаарай.

**Улаан харандаа, хөх харандаа хоёр**

Улаан харандаа улаан туулай зураад, хөх харандаандаа үзүүлэв.



Хөх харандаа хөх туулай зураад, улаан харандаанд үзүүлэв.



Хөх харандаа тэнгэр, улаан харандаа нар зурав. Хөх харандаа нарийн гол зурлаа. Улаан харандаа голын хөвөөгөөр бяцхан цэцэгнүүд нэмж зурав. Хөх харандаа туулай, улаан харандаа хоёр нүд зуржээ.



**Асуулт**

- Үлгэрт юу юу гарч байна вэ?
- Харандаанууд тус тусдаа юу зурав?
- Улаан нар байж болох уу?
- Яагаад хамтдаа зурах болов?

2. Хамтарч зурсан хэсгийг хуулж бичээрэй.

3. Зүйр үгийг үеэр тасалж бичээд, утгыг нь үлгэртэй холбон ярилцаарай.

Дэм дэмэндээ  
Дээс эрчиндээ

## ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ОЛЦГООЁ



1. Зургийг ажиглаад үйл явдлын дарааллаар дугаарлаарай.
2. Зургийн дарааллын дагуу ярилцаарай.




Нүүдлийн талаар ямар ёс мэдэх вэ?

Ачааны хамгийн сүүлд юу ачдаг вэ?



Тохирох асуулт зохиож ярилцаарай.




Зургийн дагуу ярилцахдаа:

- Нүүдлийн талаар сонирхсон зүйлээ багш, найзаасаа асуух
- Өөрийн мэддэг зүйлээ бусдад ярих
- Бусдаас хэрэгтэй мэдээллээ сонсох.

таваг  
нутаг  
найрсаг

## МОНГОЛЧУУДЫН НҮҮДЭЛ

### 1. Уншаад асуултын дагуу ярилцаарай.



Монголчууд жилийн дөрвөн улиралд нутаг сэлгэн нүүдэг. Нүүх өдөр, буух газраа урьдчилж товлон цэлмэг өдөр нүүнэ. Ачаалж байхдаа гэрийн буурин дээгүүр ачаатай, ачаагүй мал гаргадаггүй. Учир нь “ачаа хазайна” “тэмээ туйлна” гэж цээрлэдэг. Тооныг хамгийн сүүлд ачна. Нүүхдээ буурин дээрх хогийг заавал цэвэрлэдэг.

Гэрээ барихдаа ханаа нар зөв дугуйлдаг.

Монголчууд айл нүүж явахад халуун цай, тавагтай идээгээ барьж очоод “Сайн нүүж явна уу?” хэмээн найрсгаар угтдаг.

### 2. Асуулт:

- Монголчууд нүүхдээ ямар ёс үйлддэг вэ?
- Нүүдэл хийж байгаа хүмүүсийг хэрхэн угтдаг вэ?
- Гэрийн буурин дээгүүр мал гаргадаггүй учир юу вэ?

### 3. Асуултын дагуу давтан уншаад, хариулж бичээрэй.

- Монголчууд нүүдэлтэй таараад юу гэж хэлдэг вэ?
- Тоонотой холбоотой ямар ёс байдаг вэ?
- Ханаа яаж дугуйлдаг вэ?
- Нүүхдээ ямар ёс үйлддэг вэ? Учир нь юу вэ?

### 4. “г, га”-аар төгссөн үгийг ялгаж бичээрэй.

таваг

.....  
.....

Монгол, нутаг, аяга, таваг, найрсаг, булаг,  
газар, цэлмэг, нүүдэг, ураг, уурга, хог, үг

аяга

.....  
.....

**туйлна**-морь, тэмээ  
булгих, ачаа хөсгөө  
хөглүүлэх

**буурь**-гэр барьсан газар





1. Ногоон өнгөөр тэмдэглэсэн үгийг ажиглан дуугаа өндөрсгөж уншаарай.
2. Бадаг тус бүрийг уншаад ойлгосноо бичээрэй.


### Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй.

Талын шувуудын өндгөнд  
Сүүдрээ бүү хүргээрэй  
Ташуурын сүүдэр шүргэх төдийд  
Үрээ тэд голдог гэнэ.

Хээрийн салхины хөл дор  
Хэдэн өндөг хоцордог гэнэ  
Тэнгэрт нисэх тавилангүй  
Тэндээ яг төгсдөг гэнэ.

Сүр хүчит хүн танаас хүсэх нь  
Сүүдрээ хямгадаж яваарай  
Тайван нар тэнгэрт налайж  
Тал нутагт шувууд жиргэг

Д.Нямаа



Өндгөнд сүүдрээ тусгахад  
эх нь голдог тухай байна

Эхдээ гологдсон .....  
болдоггүй тухай өгүүлжээ.

.....

### 3. Давтан уншаад асуултын дагуу ярилцаарай.

- Шувуу яагаад өндгөө голдог вэ?
- Шувуу бидний ээжүүд шиг үрээ хайрладаг уу? Яагаад?
- Ээждээ гологдсон өндөг яах вэ?
- Гуравдугаар бадагт юуны тухай өгүүлсэн байна вэ?
- “Сүүдрээ хямгадаж яваарай” гэсний учрыг тайлбарлан яриарай.

#### Шүлэг цээжлэхийн өмнө:

- Утгыг ойлгох.
- Дахин давтан унших.
- Хоёр хоёр мөрөөр нь давтан унших.

### 4. Шүлгээ цээжлээд аль нэг бадгийг цээжээр бичиж тулгаж шалгаарай.

### 5. Хялбар тогтоох аргаар тоглоорой.

Талын шувуудын өндгөнд

Сүүдрээ бүү хүргээрэй

Ташуурын сүүдэр шүргэх төдийд

Үрээ тэд голдог гэнэ

#### Хялбар тогтоох тоглоом:

- Шүлгийн үгсийг цаасан дээр бичиж, бэлдсэн байна.
- Үгийг мөр мөрөөр нь зөв байрлуулж өрж тоглоно.
- Байрлуулснаа шүлэгтэйгээ тулгана
- Хэн түрүүлж байрлуулсан нь хожно.





сүүдэр-газар туссан бараан дүрс  
голдог-үл тоомсорлох, орхих,  
талын шувуу-талд амьдардаг  
шувуу (тогоруу, тоодог...)



6. Тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээгээрэй.

сүүдрээ                      голддог                      хямгадаж  
 Шувуудын өндгөнд ..... бүү хүргээрэй.  
 Өндгөө тэд ..... юм.  
 Сүүдрээ ..... яваарай.



1. Зургийг ажиглан юу болсон, цаашид юу болох талаар төсөөлөн ярилцаарай.
2. Өгүүллэгийн хэсэг бүрийг унших цаашид үйл явдал хэрхэн өрнөхийг таамаглан яриарай.



**ЖИМС ТҮҮСЭН НЬ**

Маралмаа Анараа хоёр ах эгчийнхээ хамт жимс түүхээр явжээ. Уулын модонд очиж жимс түүж эхлэв. Нэг харсан чинь Анараа жимсийг мөчиртэй нь хугалаад идэж байв.

**Төсөөлөн ярихдаа:**

- Өөрт юу төсөөлөгдөж буйг ярих
- Бусдын төсөөллийг сонсох

“Жимсний иш мөчрийг хугалж, гэмтээж болохгүй шүү хойтон жил нь ургадаггүй юм” гэсэн ээжийн хэлсэн үг санаанд орж найздаа хэлэв. Анар маш ихээр айж одоо яанаа гээд уйлав. Ээжийн захисныг найздаа эхлээд хэлсэн бол ийм юм болохгүй л байсан даа гэж Маралаа гэмшив.

Монголчууд зулзаган мод, жимсний модыг хамаагүй хугалж гэмтээдэггүй, хамгаалахыг сургаж иржээ. Модоо гэмтээгээд байвал гол ус ширгэнэ гэдэг байжээ. Анараа бид хоёр ардын сайхан ёсноос их олон зүйл мэдэж авлаа.

3. Асуултын дагуу ярилцаарай.
  - Анараа яагаад уйлсан бэ?
  - Ээж нь юу гэж хэлсэн бэ?
  - Маралаа, Анараа хоёр юу мэдэж авсан бэ?
  - Эхээс ямар сургамж авсан бэ?




4. Өгүүллэгийн үйл хөдлөлийн дэс дарааг бичээрэй.

Эхний хэсэгт юуны тухай өгүүлсэн бэ?

Дараагийн хэсэгт юуны тухай өгүүлсэн бэ?

Төгсгөлийн хэсэгт юуны тухай өгүүлсэн бэ?

5. Холбоо үг бүтээгээрэй.



## УТГА ЯЛГАСАН ҮГИЙГ ЗӨВ УНШИЖ, БИЧЬЕ




### 1. Онъсогыг таахдаа асуултын дагуу ярилцаарай.

Бүдүүн хүн

Бүсээ бүсэлж чадахгүй

Тэр юу вэ? (.....)



#### Онъсогоо таамаглая:

- Нэг нь онъсогоо уншина
- Утгыг ярилцана
- Таамаглаж буй гурав гурван үг олно
- Хамгийн оновчтой гэсэн таамгаа тайлбарлана

#### Асуулт:

- Бүдүүн гэхээр юу байж болох вэ?
- Бүс бүсэлдэг юу байж болох вэ?

#### Таамаглал:

- Бүс бүсэлдэг дээл юм уу?
- Бүс гэхээр гэрийн бүс юм болов уу?



### 2. Онъсогоны хариуг зургаас ажиглан олоорой.

Ишигний эвэр

Ийшээ тийшээ

Тэр юу вэ? (.....)

### 3. Онъсогыг таагаад, зургийг гүйцээж зураарай.

Матмал нэгэн цагариг

Махир зургаан хавирга

Тэр юу вэ? (т ..... но)

Би үүгээр явъя чи түүгээр яв


Билүүтийн аманд уулзъя

Тэр юу вэ? (г..... б.....)

Эгч дүү хоёр

Эн чацуухан

Тэр юу вэ? (х ..... га)



Өдөр гурвалжин

Орой дөрвөлжин

Тэр юу вэ? (ө.....)




**матмал** - махийлгаж  
матаж хийсэн зүйл

1. “Г”, “га, го”-той үгийг уншихад өөрөөр хэлэгдэж байгааг анзаарч дахин, дахин хэлж үзээрэй.

а. Үгийг хэлж, сонсоод ялгаж бичээрэй.

тараг	араг	булаг
тарга	арга	булга

б. Зураг ба үгийг харьцуулан утгыг ярилцаарай.



в. Үгийг харьцуулан уншаад утгын ялгааг тайлбарлаарай? Ийм хэлбэрийн үг тус бүр гурвыг бичээрэй.

уураг	алаг - алаг бөмбөг (өнгө)
уурга	алга - гарын алга

г. Ямар ялгаа байгааг бичээрэй.

“Г” хэлэхэд- .....


“га, го” бичиж тэмдэглэхэд- .....

утгын ялгаа- .....

2. Гэрийн зургийг ажиглаарай. “га, го”-той үг олж бичээрэй.

(чагтага, босго, хаалга, тотго, туурга)

3. Тохирох асуултыг сонгоорой.



4. Тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Малын ..... тэвээрэг сайн оржээ. (тараг, тарга)  
 ..... савар үүрээд гарсан ээж минь ядарч байгаа байхдаа. (арга, араг)  
 ..... ус нь бургилсан сайхан нутаг байна. (булга, булаг)  
 Хонины ..... амттай. (тараг, тарга)  
 Аливааг хийхэд ..... ухаан хэрэгтэй. (арга, араг)  
 Сор сайтай ..... байна. (булга, булаг)

5. Үгийн утгыг тайлбарлан өгүүлбэр зохиогоорой.

борог	торог	хуулаг
борго	торго	хуулга

**борог өвс**-шарлаж унасан  
**борог мах**- өөхгүй мах  
**борго**-нохой хоргоон хуцах





1. “н” “на, но, нэ, нө”-тэй үгийг уншихад өөрөөр хэлэгдэж байгааг анзаарч уншаарай.

а. Үгийг сонсоод ялгаж бичээрэй.

тан	булан	он	өн	эн
тана	булна	оно	өнө	энэ

б. Зураг ба үгийг харьцуулан утгыг ярилцаарай.

ца**на** чарга  
ца**н** хэнгэрэг




ца**на**  
ца**н**







в. Ийм хэлбэрийн үг олж уншаарай.

г. Ямар ялгаа байгааг бичээрэй.

хэлэхэд- .....  
 бичиж тэмдэглэхэд- .....  
 утгын ялгаа .....



2. Зургийг ажиглаад “на, но, нь”-тэй үгийг бичээрэй.



хана

3. Бичсэн үгээ цээжээр бичээрэй.

4. Тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээж бичнэ.

Шинэ ..... солигдож өвлийн өвгөн ирлээ. (он, оно)



..... хүүрэг татуулсаар цасан охид бүжиглэв. (цан, цана)

Тэмүүжинг Чингис ..... хэмээн өргөмжлөв. (хаан, хаана)

Ангийн ..... сонирхолтой болжээ. (булан, булна)

..... шиг цав цагаан өнгөтэй юм. (тана, тан)

5. Үгийн утгыг тайлбарлан өгүүлбэр зохиогоорой.



**ан** - 1. юмны хагарч үүссэн цав  
 2. ан амьтан  
**ана** - арга чарга  
**ана мана** - хүч тэнцүү

1. Шүлгийг уншаад, гарчиг өгөөрэй.

Өвлийн хүйтэнд хөлддөггүй ус  
 Өвчинг эдгээх ачтай ус  
 Ариухнаар урсах цэнгэг ус  
 Амьдрал тэтгэх рашаан ус



Аглаг хөвчийн ховор эрдэнэ  
 Ар тайгын сорлог үстэн  
 Хүйтэн өвөлд хүний гоёл  
 Хүрэн үст гоёмсог амьтан



2. Үгийг харьцуулж хэлээд, ярилцаарай.

булаг - гэхэд амны  
 ангайлт бага байна.  
 Булаг - булга өөр  
 хэлэгдэж байна.

булга - гэхэд амны  
 ангайлт томорч хоолой  
 шахагдаж хэлэгдэж  
 байна. Булаг - булга  
 утга нь бас өөр байна.

3. Үгийг харьцуулан уншаад, утгыг тайлбарлаарай.

баг-бага баг - баг хороо, нүүрний баг  
 бага - бага нас, их бага

уураг-уурга

4. Зургийг ажиглаад бичээрэй.



5. Ажиглаад ярилцаарай.

**Г** — хоолойн **га**- г (а, о, у, ы) арга, торго, гутал, багыг  
 хэлний **Г**- ардаа эгшиггүй (араг, гэзэг, гөлөг)

Үнэлгээ: Зөв уншаад цээжээр бичээрэй.

цана	хана	шинэ	эрдэнэ	хулгана
ботго	хурга	зураг	утга	санана
явна	унага	тараг	оготно	оньсого
дотно	чанга	ганга	шударга	ганган
азарга	ань	хононо	хонь	аварга



уншиж чадсан	бичиж чадсан
😊 😐 😞	😊 😐 😞





1. Зургийг ажиглаад төсөөлөн бодоорой.  
✓ Төсөөлж ярих

Дөрвөлжин хэлбэртэй цагаан өнгөтэй юм чинь юу байж болох вэ?



2. Эхийг уншаад төсөөлөн бодсонтойгоо харьцуулж ярилцаарай.

### БЯЦХАН ХУЛГАНА

Хулганы бяцхан зулзага гайхалтай нэгэн зүйлийг олжээ. Тэр олсон зүйл нь цагаан өнгөтэй, дөрвөлжин хэлбэртэй, сайхан үнэртэй байлаа.

Тэгээд цагаан өнгөтэй дөрвөлжин зүйлээ аваад гэр лүүгээ харилаа. Бяцхан хулганы аав ээж ихэд баярлажээ.

- Миний хүү гоё юм олсон байна. Энэ чинь саван гэдэг зүйл шүү дээ гэв.

Өрөөнийхөө голд савангаа тавилаа. Хулганы гэр цэцгийн үнэрээр дүүрлээ.

3. Зургийг ажиглаад, юу болохыг төсөөлөн бодоорой.



4. Эхийг уншаад, төсөөлөн бодсонтойгоо харьцуулж ярилцаарай.

Тэдний сэтгэл үнэхээр таатай байлаа. Хулганы аав, ээж савангийн булангаас жаахныг аваад гар нүүрээ угаалаа.

Зулзага ч мөн хоцорсонгүй. Саван хөөсөрч тэдний нүүр, гар ч цэв цэвэрхэн болов.

Бүгдээрээ сарнай цэцгийн үнэртэй боллоо.

Гурван хулгана үнэхээр аз жаргалтай байв.

Цонхоор гэрэлтэх саран тэднийг инээмсэглэн харж байлаа.



### 5. Асуултад хариулж ярилцаарай.

✓ Гөлчгий юу олсон бэ?

✓ Сар яагаад инээсэн бэ?

✓ Савангаар юу хийв?

### 6. Үлгэрийг уншаад хэсэг тус бүрт гарчиг өгье.



"Бяцхан хулганы олз"  
"Хулгана юу олов?",  
"Олз" эдгээр гарчгаас  
хамгийн оновчтой нь  
аль вэ?

Эхний хэсэгт  
"Бяцхан хулганы  
олз" гэсэн гарчиг  
өгье.



### 7. Үлгэрээ ойлгосноо ярилцаарай.



Үлгэрийн  
баатруудыг  
нэрлээрэй.

Эхлээд юу  
болсон бэ?

Дараа нь юу  
болсон бэ?


Эцэст нь яасан  
бэ?

### 8. Зургийн дэс дарааллыг зөв олоорой.



### 1. Зургийг ажиглаарай.

- ✓ Амьтны үр төл юугаар хооллодог вэ?
- ✓ Иддэг хоолыг нь харгалзуулаарай.



Хэдгэнэ ээ! Амьтдын үр төл ямар хоолонд дуртайг яг одоо хариулна уу.

Ялаа гуай би бодож байгаад яг зөв хариулъя. Хүүхдүүд ээ, надад туслаарай.

### 2. Цэгийн онрд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Хулганы гөлчгий ..... иддэг.  
Муурын зулзага ..... иддэг.  
Галууны дэгдээхэй ..... иддэг.  
Хэрэмний зулзага ..... иддэг.

амьтдын  
зулзагын  
сарвагар


### 3. Чиний төсөөлсөн зүйл шүлэгт байна уу? Уншаад ярилцаарай.

#### Хэдгэний хариултад хэн туслах вэ?

Хөвч тайгаар зугаалж  
Хөдөө аялсан  
Олон амьтдын зулзага  
Олз омогтойхон цугларчээ  
Эрх хулганы **гөлчгий**  
Хэсэг махтай иржээ.  
Эрээн муурын **зулзага**  
Хэдэн арвай олжээ.  
Орилоо нугасны **дэгдээхэй**  
Самарт боргоцой авчирчээ.  
Ой тайгын хэрэм  
Сарвагар өт түүжээ.

Аль дуртай хоолоо  
Цөмөөрөө хоорондоо сольё! гэж  
Аглаг тайгын хэрэм  
Санал гарган хэлж гэнэ.  
Амьтдын зулзагын аль нь  
Ямар юм авсныг  
Алдаагүй зөв хариулахыг  
Ялаа хэдгэнэд шаарджээ.  
Юу, юугаар хооллодгийг нь  
Хэн сайн мэддэг нь  
Хэдгэнийн өгөх хариултад  
Хэлж одоо тусална уу?

(Г.Жамьянсүрэн)



4. Асуултад хариулж ярилцаарай.

- Амьтдын зулзага хаана аялж зугаалсан бэ?
- Юуны? гөлчгий юутай ирсэн бэ?
- Ямар? юуны? зулзага юу олсон бэ?
- Ямар? юуны? дэгдээхэй юу? авчирсан бэ?
- Ой тайгын юу? ямар? юу? түүсэн бэ?
- Хэрэм ямар? санал гаргасан бэ?
- Ялаа юунд хариулахыг шаардсан бэ?
- Чи хэдгэний асуултад хариулт өгч чадсан уу?

5. Амьтдын үр төлд нэр өгөөрэй.

- ✓ Цэвэр нямбай бичээрэй.

Хэрэмний үр төл  
(хорилдой)  
Соотон

Би ингэж  
нэрлэнэ

нугасны дэгдээхэй  
.....

гөлчгий  
Дэлдээхэй

муурын зулзага  
.....

6. Бусад амьтны үр төлд нэр өгөөд бичээрэй.

Үлгэрлэвэл: чонын бэлтрэг - Сааралхан .....

- ✓ Үр төлд өгсөн нэрийн эхний үсгийг яаж бичсэн бэ?
- ✓ Өөр ямар тохиолдолд эхний үсгийг томоор бичдэг вэ?

7. Амьтны хүрээлэнгийн зургийг ажиглаж ярилцаад эх зохиогоорой.







### 8. Уншаад ярилцаарай.

- ✓ Ямар алдаа гаргасан байна вэ?
- ✓ Алдаагаа яаж зассан бэ?

Амьтны хүрээлэнд	Амьтны хүрээлэнд
Би дүүтэйгээ амьт <b>ни</b> й хүрээлэнд очлоо. Тэнд олон амьтад байв. Би барын бамбарт <b>б</b> амбаахай гэж нэр өгөв. Оцон шувууны дэгдээхэйг дүү Бөмбөөлэй гэж дуудлаа.	Би дүүтэйгээ амьтны хүрээлэнд очлоо. Тэнд олон амьтад байв. Би барын бамбарт Бамбаахай гэж нэр өгөв. Оцон шувууны дэгдээхэйг дүү Бөмбөөлэй гэж дуудлаа.

### 9. Шүлгийг уншаад, дуурайж зохиогоорой



### 10. Онъсогыг таахдаа дарааллаа санаад зөв харгалзуулаарай. Тохируулан холбоорой.

Яа яа жимбүүхэй  
Яс махгүй жимбүүхэй

муур

Эрээн л байна бар байлгүй  
Эвэртэй л байна буга байлгүй

хэдгэнэ

Гуруй гуруй биетэй  
Гучин гурван нуруутай

ялаа



### Багшийг сонсоод бичээрэй.

Тарагны халбага  
Тарваганы хавирга



## ЦЭЦЭГ БАЯРЛАВ

1. Зургийг ажиглаад, асуултад хариулж бичээрэй.



а. Туулайн бөжин юу тарьсан бэ?  
.....



б. Цэцэг хэрхэн ургасан байна вэ?  
.....



в. Хулганы гөлчгий ирээд цэцгийг таслах гэв. Туулай түүнд юу гэж хэлсэн бэ?  
.....



г. Улаан цэцэг баярлан ганхав. Түүнийг харсан амьтдын зулзага баясан бүжиглэв. Цэцгийг ямар ямар амьтдын зулзага сонирхсон бэ?  
.....

2. Ямар амьтдын зулзага вэ? Харгалзуулаарай.

туулай	бөөдий	үнэг
	гавар	
хулгана	гөлчгий	зараа
	бэлтрэг	
	бөжин	
чоно	хоролдой	хэрэм

3. Зургаа үлгэр болгож бичээрэй.

### Цэцэг баярлав

Эхлээд .....  
Дараа нь .....  
Эцэст нь .....

4. Зүйр үгийг хуулж бичээд, ярилцаарай.

#### Зүйр цэцэн үг

Нэг өдөр танилцаж  
Мянган өдөр нөхөрлөнө.

Нөхрийн хэрэг бүтвэл  
Өөрийн хэрэг бүтнэ.

бөжингийн  
хулганы  
цэцгийг  
хоролдойн





1. Шүлгийг цээжлээд уран тод уншаарай.

**Барын бамбар**

Андурч ойртов оо  
Би муур биш шүү  
Алдар нэр маань  
Барын бамбар шүү  
С.Маршак

- Шүлгийг ойлгож уншаарай.
- Шүлгийг хоёр хоёроороо уншаарай.
- Анги нийтээр уншаад цээжлээрэй.

2. Бамбар, муур хоёрын адил ба ялгаатай талыг ярилцаад, бичээрэй.



Бамбар, муур хоёр  
үнэхээр адилхан  
юм аа.!



Ялгаатай шүү  
дээ. Муур гэрийн  
тэжээмэл амьтан ....  
Харин бар .....



3. Онъсогыг таагаарай.

Шарга шарга биетэй  
Шар шувуун нүдтэй      Тэр юу вэ? (.....)



4. Юу, юуны үр төл вэ? Бичээд өгүүлбэр зохиогоорой.

Үлгэрлэвэл: нохойн гөлөг, хонины хурга



5. Хэлний г, хоолойн г-тэй үгийг ялган бичээрэй.

1. Зургийг ажиглаад, үйл хөдлөлийг төсөөлөн бодож, ярилцаарай.



2. Шүлгийг ойлгож уншаарай.

**Шүлгийг цээжлэхдээ:**

- Утгыг ойлгож уншаарай
- Шүлгийг мөр мөрөөр нь давтан цээжлээрэй
- Анги нийтээрээ уншаарай
- Хоёр хоёроороо буюу багаараа уншаарай
- Шүлэг цээжлэх ямар аргууд байдгийг бусдаас асуугаарай.

**Зараа тугал хоёр (шүлэг)**

Ичимхий зараа хэвтэж гэнэ  
 Идэмхий тугал ирж гэнэ  
 Бөөрийг нь тэр долоож гэнэ  
 Өөрийн нь хэл өвдөж гэнэ  
 Дайралдсан бүхэн хоол биш шүү гэж  
 Даажигнасан зараа инээж гэнэ.

*А.Барто*

3. Асуултын дагуу ярилцаарай.

- Зарааг яагаад ичимхий гэсэн бэ?
- Тугалны хэл яагаад өвдсэн бэ?
- Зараа юу гэж хэлсэн бэ?

4. Зарааны хэлсэн үгийг сонгон бичээрэй.


5. Шүлгийн үйл явдлын дарааллыг бичээрэй.

Эхлээд яасан .....  
 Дараа нь яасан .....  
 Эцэст нь яасан .....

6. Загварын дагуу бичээрэй.

ямар?  
 .....  
 .....  
 тугал  
 Алаг тугал мөөрлөө.  
 .....


яасан?  
 .....  
 .....  
 зараа  
 Зараа шоолж инээсэн.  
 .....





### 1. Зургийг ажиглаад юуны тухай уншихаа төсөөлцгөөе!

- Зургийг нэрлэж бичнэ.
- Юунд хэрэглэдгийг тайлбарлана.
- Юуны тухай уншихаа төсөөлнө.



### 2. “Шилбүүр, уурга” үгээр өгүүлбэр зохиогоорой.

болохгүй      Уурган

дээгүүр      алхаж


Юу?      яав?

Хэн?      юу?      яасан?

Хэн?      ямар?      юу?      яав?

### 3. Хүснэгтийг бөглөөд бичээрэй (хосоороо ярилцана).

Уншихын өмнөх төсөөлөл	Уншсаны дараах төсөөлөл
<p><i>Үлгэрлэвэл:</i> Ажилсаг хүү амралтаараа хөдөө иржээ. Хүү өдөрт адуу эргүүлнэ, хониндоо явна, хониндоо явахдаа шилбүүрээ барина. Тэр адуундаа явахдаа ч шилбүүр барьдаг. Учир нь тэр уургаа даахаар том эр болоогүй.</p> <p>Ц.Амараа</p>	





## ШИЛБҮҮР

Би адуунд явахдаа шилбүүр барин явлаа. Замд айлын хүүхдүүд тааралдаад:

- Болдоо, хурганд явж байна уу? гэв.
- Үгүй, адуунд явж байна.
- Худлаа, чи хурганд явж байна шүү дээ.
- Яагаад?

*Д.Давааням*

Хүүхдийн зохиолч Д.Давааням нь "Мөлхөө ангийнханд" гэсэн шүлгийн ном бичсэн. Халхын өндөр Гонгор гэдэг хүний ач хүү Давааням Хөвсгөл аймагт төржээ.



4. Дараах асуултын дагуу сонгон уншаарай. Сонгон унших хэсэг байна уу, байхгүй бол төсөөлөн ярилцаарай.

- Хүү юунд явсан бэ?
- Найз нь Болдыг яагаад худлаа, чи хурганд явж байна гэж хэлсэн бэ?

5. Болд хүү адуундаа явсан уу, яагаад? Дараах хоёр загвараас сонгоод  бичээрэй.

Болд адуундаа явсан.	Учир нь.....
Болд адуундаа яваагүй.	Учир нь.....

6. Болд унах унагаа барихаар явсан уу, адуугаа гилж (тууж) ирэхээр явсан уу? Ярилцаарай. Ярилцахдаа адуугаа зүслээд, оноосон нэр өгч ярилцаарай.

7. Төсөөлж бодсоноос чинь уншсан өгүүллэг юугаараа ялгаатай байгааг ярилцаад, өмнөх хүснэгтээ бөглөөрэй.

8. Өгүүллэгийн үйл явдлын дарааллыг ярилцаад төгсгөлийг нь гүйцээн зохиож бичээрэй.



Багшийг сонсоод бичээрэй.

Хялгасан цулбуур  
Бургасан шилбүүр



ГИЛЭХ - туух





1. Гэрийн тэжээмэл амьтан нэгийг дэвтэртээ зураарай.
2. Зурсан амьтныхаа тухай юу мэдэх вэ? Бусдадаа яриарай.
3. Загварыг ашиглаад зурсан амьтныхаа тухай бичээрэй.

Асуултын дагуу бичээрэй.	Би ингэж бичнэ.
<ul style="list-style-type: none"> <li>• Ямар амьтан сонгосон бэ?</li> <li>• Үр төлийг нь юу гэж нэрлэдэг вэ?</li> <li>• Ямар зүстэй вэ?</li> <li>• Ямар онцлог шинжтэй вэ?</li> <li>• Юугаар хооллодог, юунд дуртай вэ?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Туулайг сонгосон.</li> <li>• Би туулай тэжээдэг, үр төлийг нь бөжин гэнэ.</li> <li>• Бөжин саарал зүстэй</li> <li>• Уруул нь сэтэрхий, чих нь дэлдэн</li> <li>• Лууван болон хүнсний ногоогоор, хооллоно.</li> </ul>

4. Сүхийн зурсан зурагны тухай уншаарай.

### ХАВАР

Өрөөнд чив чимээгүй. Багш хүүхэд бүрийн дэргэд очиж, зурж буй зургийг нь үзнэ. Бүх хүүхэд таван хошуу малын аль нэгийг зурах даалгавартай байлаа.

Багш Сүхийн дэргэд очсоноо:

- Чи минь мал зурахгүй яагаад яргуй зурдаг билээ гэж гайхан асуухад:
- Өдийд яргуй идсэн ямаа сүү ордог гэж эмээ ярьсан юм. Би сүүнд дуртай болохоороо яргуй зурсан, дараа нь ямаа зурна гэж Сүх хариулжээ.

*Д.Базаррагчаа*

5. Дараах асуултын дагуу сонгон уншаад, ярилцаарай.
  - Сүхээс багш юу гэж асуусан бэ?
  - Сүх ямаа зурсан уу?
  - Ямар улиралд болсон үйл явдлын тухай уншсан бэ?

6. Асуултад тохирох үгсийг бүлэглэж бичээрэй (Хэн?....., юу? .....
7. Өгүүллэгийн үйл хөдлөлийг шат ашиглан эрэмбэлж будаарай.



Дараа нь ямаа зурна гэж хариулжээ.

Багш Сүхийн дэргэд очиж яагаад яргуй зурж байгааг нь асуув.

Хүүхэд бүр 5 хошуу малын нэгийг зурах даалгавартай байлаа.

Яргуй идсэн ямаа сүү ордог гэж эмээ ярьсан.

Би сүүнд дуртай болохоороо яргуй зурлаа.



1. Шүлгийг тод чанга уншаарай.

### ЗОРИГТОЙ ТУУЛАЙ

Ойн эзний тавагтай шөлийг  
Огтор туулай уучихжээ  
Баавгай ирэхийн бараанаар  
Баярын ширээнээс зугтжээ


Давхиж давхиж гэртээ ирээд  
Дан хийтэл хаалгаа түгжээд  
“Би уусан яадаг юм бэ” гэж  
Байдаг чадлаараа хашхирчээ.  
О.Сундуй



2. Онцолсон үгийг толь бичиг ашиглан тайлбарлаарай.

3. Таалагдсан хэсгээ бусдад уншин, яагаад таалагдсан тухайгаа яриарай.

4. Загварыг нөхөж бичээрэй.



5. Орхигдсон үйл хөдлөлийг шүлгээс сонгож бичээрэй.

Туулай эхлээд яасан?

.....  
.....  
.....



1 2  
3 4

Төгсгөлд ямар үйл хөдлөл болов? .....

.....  
.....  
.....

6. Туулай, баавгай хоёрыг харьцуулан ярилцаарай.

7. Бичлэгийг ажиглаад, дуурайлган бичээрэй.

Туулай

туулайн, туулайнд, туулайнаас,  
туулайг, Туулайн зулзагыг бөжин  
гэнэ, дуртай хоол нь лууван.

Баавгай

.....,  
баавгайнаас, .....  
Баавгайн төлийг.....  
..... гэнэ, дуртай хоол нь  
.....

## ӨГҮҮЛБЭРИЙН ЦЭГ ТЭМДГИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭЖ СУРЦГААЯ



1. Найз минь надаас асуулт асуувал яаж хариулахаа бодъё.

- Асуултыг сонсож сайн ойлгоё.
- Олон хариултаас зөвийг сонгоё.
- Асуултын хариултыг бичье.

### Асуулт:

- Хүү хаанаас ирэв?
- Хүрэмийн талаар юу байна?
- Ногоо яаж тарьдаг юм бэ?
- Ногоо яаж ургадаг юм бэ?
- Ногоо ургахад юу, юу хэрэгтэй байдаг юм бэ?
- Хүрэмийн тал усаар бага хөрсөөр муу шүү дээ

### Хариулт:

- Хүрэмийн талаас ирлээ.
- Хүмүүс ногоо тарьж байна.
- Үрийг хөрсөнд суулгаж тарьдаг.
- Соёолсон үрээс байцай, төмс, лууван, саримс, сонгино ургадаг юм.
- Нар, ус, агаар, хөрс, хөдөлмөр хэрэгтэй.
- Хүмүүс суваг татаж хөрсийг нь сайжруулсан шүү дээ  
Мэдээгүй юм уу? Та гэжээ.

2. Харилцан яриагаа уншъя.  
3. Харилцан яриандаа гарчиг өгье.



- Найзын асуултыг бичье.
- Би бас юу гэж хариулахаа бичье

- .....
- Хүү хаанаас ирэв?
  - Хүрэмийн талаас ирлээ.
  - Хүрэмийн талаар юу байна?
  - Хүмүүс ногоо тарьж байна.
  - Ногоо яаж тарьдаг юм бэ?
  - Үрийг хөрсөнд суулгаж тарьдаг.
  - Ногоо яаж ургадаг юм бэ?
  - Соёолсон үрээс байцай, төмс, лууван, саримс, сонгино ургадаг юм.
  - Ногоо ургахад юу, юу хэрэгтэй байдаг юм бэ?
  - Нар, ус, агаар, хөрс, хөдөлмөр хэрэгтэй.
  - Хүрэмийн тал усаар бага хөрсөөр муу шүү дээ.
  - Хүмүүс суваг татаж хөрсийг нь сайжруулсан шүү дээ
  - Мэдээгүй юм уу та гэжээ.

Гарчгаа оновчтой сонгоё.

- Өвгөн хүү хоёр
- Хүрэмийн тал
- Хүнсний ногоо

4. Зургийг ажиглаад, ярилцаарай.



5. Зугаа үгийг төлөөлөн уншаарай.

6. Асуулт хариултыг харьцуулж уншаад ямар ялгаатай болохыг тайлбарлаарай.

**Өвгөн хүү хоёр**

- Хүү хаанаас ирэв?
- Хүрэмийн талаас ирлээ.
- Хүрэмийн талаар юу байна?
- Хүмүүс ногоо тарьж байна.
- Ногоо яаж тарьдаг юм бэ?
- Үрийг хөрсөнд суулгаж тарьдаг.
- Ногоо яаж ургадаг юм бэ?
- Соёолсон үрээс байцай, төмс, лууван, саримс, сонгино ургадаг юм.
- Ногоо ургахад юу юу хэрэгтэй байдаг юм бэ?
- Нар, ус, агаар, хөрс, хөдөлмөр хэрэгтэй.
- Хүрэмийн тал усаар бага хөрсөөр муу шүү дээ.
- Хүмүүс суваг татаж хөрсийг нь сайжруулсан шүү дээ
- Мэдээгүй юм уу? Та гэжээ.

7.


Зөв тэмдэглэе



Асуусан өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг (?), хариулсан өгүүлбэрийн эцэст цэг (.) тавина.

8. Тохирох хариултыг бичээрэй.

Асуулт	Хариулт
<ul style="list-style-type: none"> <li>• Хүнсний ногоог тарихдаа эхлээд юу хийх вэ?</li> <li>• Дараа нь юу хийдэг вэ?</li> <li>• Хүнсний ногоо ургахад юу юу хэрэгтэй вэ?</li> </ul>	<p>Хүнсний ногоо тарихын өмнө хөрсөө сийрүүлж бордоно.</p> <p>.....</p> <p>.....</p>



## Дунд хуруу олох (Тоглоом)

### Тоглох заавар:

- Дунд хуруу олох тоглоомыг хосоороо эсвэл багаараа тоглоно.
- Дунд хурууг нуугч хүүхэд хуруугаа аль болохоор сольж байрлуулаад нөгөө гараараа базаж барина. Нөгөө гарынхаа хуруунаас оролцуулж болно.
- Хуруу ологч хүүхэд дунд хурууг олж чадвал хожно. Олж чадахгүй бол тоглоомоос хасагдана.
- Дунд хурууг олж чадвал хурууг тавилгүйгээр дараах зүйлийг нягталж асууна.

### 1. Тоглохдоо дараах хэллэгийг ашиглаарай.

- |                            |  |
|----------------------------|--|
| - Хур бороо оров уу?       | - Хөх бухын хөндийгөөр орлоо.                                |
| - Хур бороо орлоо.         | - Хөх бух чинь яав?  |
| - Хур бороо чинь яав?      | - Хааны хүүхдүүд хаа хуу гээд худаг руу түлхээд унагачихлаа. |
| - Нар гараад хатаачихлаа.  | - Хааны хүүхдүүд яав?  |
| - Нар чинь яав?            | - Аав ээждээ аргал түүж өгөхөөр араг үүрээд явлаа...         |
| - Үүлний цаагуур орчихлоо. |  |
| - Үүл яав?                 |  |

### 2. Үгэн тоглоомыг төлөөлөн уншаарай.

#### Асуулт

- Хур бороо оров уу?
- Хур бороо чинь яав?

.....

#### Хариулт

- Хур бороо орлоо.
- Нар гараад хатаачихлаа.

.....


### 3. Өмнө үзсэнээ сэргээн санаад, асуулт хариултыг гүйцээж ярилцаарай.

#### Асуулт

- Чи ямар, ямар тоглоом мэдэх вэ?
- Үгэн тоглоом мэдэх үү?
- Юу гэж эхэлдэг юм бэ?
- Хэтээр .....
- Гал түлж яах нь вэ?
- .....

#### Хариулт

- Шагай шүүрэх, шатар, даам гээд олон тоглоом мэднэ.
- Чоно тарвагацах .....
- Чоно гуай чоно гуай хэтээ өгөөч
- Гал түлье.
- Цавуу .....
- .....



### Харилцан ярилцахдаа:

1. Асуултаа урьдчилан бэлтгэсэн байна.
2. Хариултаа бүтэн өгүүлбэрээр хариулна.






4. Харилцан яриаг гүйцээж зохиогоорой.  
Ашиглах үг. (шатар, морь, хүү, тэрэг, бэрс .....)

Асуулт

- Чи шатар тоглодог уу?
- .....
- .....
- .....

Хариулт

- .....
- .....
- .....
- .....



5. Дараах харилцан яриаг уншаад асуусан утгатай өгүүлбэрийн төгсгөлд (уу? үү? бэ? вэ?) асуух утгатай үгээс тохирохыг сонгож бичнэ үү?

Өдөр

- Чамайг хэн гэдэг .....
- Чамайг маргааш бас л шөнө гэх .....
- Өчигдөр бас л шөнө гэж нэрлэж байсан.....
- Тэгвэл би олон нэртэй. Өнөөдрийн миний нэр даваа, маргааш намайг мягмар гээд өдөр бүр өөрөөр дуудна шүү дээ.

Шөнө

- Намайг шөнө гэдэг.
- Тийм ээ бас л шөнө гэнэ.
- Бас л шөнө гэсэн.

Асуух утгатай өгүүлбэрийн төгсгөлд асуух үг (уу? үү? юу? юү? бэ? вэ?) бичнэ.



6. Хуруун хүүхэлдэй ашиглан харилцан ярилцаарай.



- Торой - Чамайг юу гэж нэрлэдэг вэ?
- Гөлөг - Намайг Алагхан гэдэг.
- Торой - Чи юунд дуртай вэ?
- Гөлөг - Би сүү, бас маханд дуртай.
- Торой - Чи яаж тоглох дуртай вэ?
- Гөлөг - Харайж, нуугдаж тоглох дуртай.

7. Чоно ба туулайн хуруун хүүхэлдэй ашиглан харилцан яриа зохиогоорой.



- Чоно - .....
- Туулай - .....
- Чоно - .....
- Туулай - .....
- Чоно - .....
- Туулай - .....

Хуруун хүүхэлдэйг өөрийн дуртай амьтдын дүрсээр хийж болно. Хүүхэлдэйг хийхдээ багш болон гэр бүлийнхээ хүмүүстэй хамтран хийгээрэй.



1. Зургийг ажиглаад, төсөөлөн бодоорой.

2. Өгүүллэгийг уншаад ярилцаарай.

### Ногоон навчны мөрөөдөл

... Хумбан жаахан навчис нь голын мандалд өөрийгөө тольдон “Би том болж байна. Би том болж байна” гэж шуугилдан шулганалдан ургана.

Ийнхүү цэнгэлдэн цэцэглэн байтал тэдний нэг навчхан, эх модондоо хандан өгүүлэх нь:

- Би ургаж төлжөөд эрийн цээнд хүрлээ. Нэг л мөчир дээр бүх л насаараа ургана гэдэг даан ч залхуутай юм. Ингэж уйтгартай амьдармааргүй байна.

Улиас хариуд нь:

- Үр минь нас чинь бага, цус чинь шингэн байна. Би чиний ээж чинь бас эх орон чинь байна. Эх орноо орхин одсон хэнд ч гэмших зүйл олон тохиолддог юм гэж сургамжлав.

Гэвч эхийнхээ үгийг ухааралгүй зүтгэн зүтгэсээр мөчрөөсөө тасран голын мандалд бууж цааш хөвөн одлоо. Хөвөн явсаар нэг чулуунд тээглэн саатав.



3. Навчны хийсэн үйлдэл зөв үү? Яагаад?

Навч цаашдаа яах бол? Сонгоорой.

Чулуунд тээглэж байсаар хатна.

Цааш урсана.

Урсгалаар эрэг дээр шидэгдээд ургана.



Багшийг сонсоод бичээрэй.

Алга байсан, алаг бяруу  
Аавын аргийг шөргөөж, ахын  
тэргийг мөргөв

4. Төлөөлөн уншаад цэг тэмдгийг зөв бичээрэй.

навч	чулуу
- Чулуу чи юунд миний замд саад болов? Усан дотор дөмбийж хэвтэхдээ уйдахгүй байна уу - Байз, байз. Нээрээ ямар сайхан сонсогдоно вэ Сэтгэл нэг л цэлмэчихлээ.	- Балчирхан навч минь бүү бухимд энэ голын хоржигнон жирвэгнэх яруу эгшгийг сонсохгүй байна гэж үү

... Ийнхүү ярилцан байтал гэнэт усны түрлэг ирж чулууг нэгэнтээ илбэх мэт болоод хөөрхий навчийг урсган авч одлоо. Навч уруу дагасан урсгалын эрхээр хөвж явахдаа “Бусдын эрхшээл дор хаа хүрэхээ мэдэхгүй ингэж явснаас мөчир дээрээ сэрчигнэн сэрвэлзэж, эрхлэн наадаад дуртай цагтаа нар хөдрөн нойрсож байх минь яалаа даа” хэмээн гуниглав...

О.Сундуй



### 5. Асуултад хариулж ярилцъя.

- Навч эх улиасандаа хандаж юу гэж хэлсэн бэ?
- Эх улиас хариуд нь юу гэж хэлсэн бэ?
- Мөчрөөс тасарсан навч яасан бэ?
- Навч чулуунд юу гэж хэлэв?
- Навч яагаад гуниглав?

### 6. Гарчигт тохирох хэсгийг сонгож уншаарай.

- Би том болж байна.
- Бяцхан навчны мөрөөдөл.
- Эхийн сургаал.
- Бяцхан навч чулуу хоёрын яриа.
- Навч гуниглав.

#### Төлөөлж уншихдаа:

- Асуултыг ойлгомжтой уншъя.
- Хариултаа ойлгомжтой уншъя.
- Уншихдаа сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж уншъя.

### 7. Төлөөлөн уншъя.

- Навч, эх улиас хоёрыг төлөөлөн уншъя.
- Навч, чулуу хоёрын харилцан яриаг төлөөлөн уншъя.

### 8. Асуусан утгатай өгүүлбэрт хариулж бичээрэй.

Асуух утгатай өгүүлбэр	Хүүрнэсэн утгатай өгүүлбэр
• Навч яагаад гунигласан бэ?	.....
• Бяцхан навч цааш яах бол?	.....
• Бяцхан навчны хийсэн үйлдэл зөв үү?	.....
• Ээжийнхээ хэлсэн үгийг эргэцүүлэн бодсон бол...	.....



**хөдрөх** - нөмрөх  
**нар хөдрөн нойрсох**  
 - нарны илчинд  
 дулаахан нойрсох



1. Зугаа үгийг уран тод уншаарай.
2. Асуусан утгатай зугаа үг болгон хувиргаарай.

### Зугаа үг

Тугал тугал тоглоно  
 Туул голдоо очно  
 Унага унага тоглоно  
 Онон голдоо очно  
 Ботго ботго тоглоно  
 Борзонгийн говьдоо очно  
 Хурга хурга тоглоно  
 Хадан дээгүүр наадна  
 Ишиг ишиг тоглоно  
 Эргэн дээгүүр наадна.

### Зугаа үг

Тугал тугал тоглодог уу?  
 Туул голдоо очдог уу?

.....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....

3. Өгөгдсөн үгийг ашиглан зугаа үгийг өөрчлөн бичээрэй.

(мөөрнө, янцгаана, буйлна, майлна)

Тугал тугал мөөрнө  
 Туул голдоо очно  
 Унага унага .....  
 Онон голдоо очно  
 Ботго ботго .....  
 Борзонгийн говьдоо очно  
 Хурга хурга .....  
 Хадан дээгүүр наадна  
 Ишиг ишиг .....  
 Эргэн дээгүүр наадна.



4. Түргэн тод хэлж сураарай.




Хур дэлтэй хул морь  
 Хурд ихтэй бор морь


Шанх сайтай шарга  
 Саваг сайтай сарлаг



тайлбарлах үг	миний бодлоор	толь бичигт
хур дэл		
хул морь		



1. Эдгээр амьтад яаж унтдаг вэ? Төсөөлөн ярилцаарай.



2. Цэгийн оронд дараах амьтдын нэрээс тохирохыг бичээрэй.

- (туулай, болжмор, тогоруу, сарьсан багваахай)  
..... зогсож байгаад унтдаг.  
..... толгойгоо унжуулан зүүгдэж унтдаг.  
..... сууж байгаад унтдаг.  
..... хэвтэж байгаад унтдаг.

3. Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй. (бэ? вэ? уу? үү?)

- Болжмор, тогоруу хоёр шувуу мөн .....  
Сарьсан багваахай яаж унтдаг .....

4. Хуулж бичихдээ цэг тэмдгийг зөв бичээрэй.


#### Амьтад яаж унтдаг вэ?

- |  |   |
|--|---|
| <ul style="list-style-type: none"><li>- Туулай чи яаж унтдаг вэ</li><li>- Тэгвэл болжмор чи яаж унтдаг вэ</li><li>- Харин тогоруу чи яаж унтдаг вэ?</li><li>- Чи тэгэхээр яаж унтдаг вэ?</li></ul> | <ul style="list-style-type: none"><li>- Ердийн байдлаар хэвтэж унтдаг</li><li>- Сууж байгаад л унтдаг</li><li>- Би зогсож байгаад унтдаг.</li><li>- Тэгвэл, найзууд минь Би л бусдаас илүү тавтай унтдаг Бүхнээс сайхан амьдардаг юм байна. Юмнаас зүүгдэж унтдаг</li></ul> |
|--|---|

5. Шүлгийг төлөөлөн уншаарай.



## ҮЙЛ ЯВДЛЫГ ТААМАГЛАЖ СУРЦГААЯ



1. Гацуур мод хийж сурцгаая.
2. Гацуур хийх явцад юу бодогдсон бэ?
3. Сүлд модны баяраар хэрхэн баярласнаа дурсаж ярилцаарай.



Өвлийн өвгөний  
бэлэг  
гацуур мод

### 4. Сурагчдын бодлоос:

Өвлийн өвгөнтэй  
уулзана гэж төсөөлж  
байна.



Шинэ жилийн баяраар  
цав цагаан даашинз  
өмсөж цасан охидын  
хамт бүжиглэнэ.



### 5. Шинэ жилээр юу хийхээ бичигдээ.

#### Хамгийн сайхан баяр

Ганган гацуураа хүүхдүүд тойрон  
бүжиглэнэ. Өвлийн өвгөн ууттай  
бэлгээ хүүхэд багачуудад түгээв.  
Хөгжилтэй хүүхдүүд бүжин  
наадлаа.

#### Хамгийн сайхан баяр

Ганган гацуураа хүүхдүүд  
чимэглэнэ. Өвлийн өвгөн ууттай  
бэлгээ хүүхэд багачуудад түгээв.  
Хөгжилтэй хүүхдүүд баяр хөөртэй  
бүжлээ.

#### Бичихдээ:

- Бичих зүйлээ таамаглан зурна.
- Таамагласнаа бусадтай ярилцана.
- Бичиж тэмдэглэнэ.
- Засаж сайжруулна.



1. Тодруулсан үгийн ард зогсолт хийж тод чанга, хурдан унших дасгал хийгээрэй.
2. Бадаг бүрийн утгыг яриад, сонгон цээжлээрэй.



### Сүлд мод

Мөнх  
Ногоон  
Мөчиртэй  
Сүлд **МОДОО**  
Мөнгөн одоор  
Тэргүүлж **ЧИМЬЕ**  
Алтан гадас одыг  
Орой дээр нь **ЗАЛЪЯ**

Мөнх  
Ногоон  
Мөчиртэй  
Сүлд модоо  
Хаврын яргуй  
Өнгийн солонго  
Хөвөн цагаан үүл  
Намрын алтан түрүү  
Цалин мөнгөн цас мөс  
Нарны садан есөн гараг  
Найргийн бадгаараа **ЧИМЬЕ**

Мөнх  
Ногоон  
Мөчиртэй  
Сүлд **МОДОО**  
Баясгалантай  
Үр хүүхдийнхээ  
Царайд гэрэлтсэн  
Баяр хөөрөөр **ЧИМЬЕ**  
Айл бүхэнд дэлгэрсэн  
Аз жаргалаар бас **ЧИМЬЕ**  
Эх дэлхийд эгнэгт мандах  
Энх тайвнаар дээдлэн **ЧИМЬЕ**  
Ер бусын модоо чамд **БЭЛЭГЛЭЕ**  
Ерөөлт шинэ жилийн баяр **ХҮРГЭЕ**

Ж.Дашдондог



### Цээжилснээ уншихдаа:

- Үгийг тод хэлэх
- Тодруулсан үгийн ард зогсолт хийх
- Дууны өндөр намыг тохируулах

### 3. Нөхөж бичээрэй.



ямар?


...үүл

...мөчир

...од

...цас

4. Сүлд модыг юу юугаар чимэглэнэ гэснийг түүж бичээд, үеэр таслан бичнэ.





1. “Ухаантай аав” эхэд юуны тухай өгүүлэхийг таамаглаарай.

### Ухаант аав

Цэцэрлэгч өвгөн хөвгүүдээ цэцэрлэгийн ажилд сургах сан гэж хүсдэг байжээ. Насан өөд болохын цагтаа өвгөн хөвгүүдээ дуудан ирүүлж:

- За хүүхдүүд минь, усан үзмийн цэцэрлэгт нуусан юмыг ол гэж захижээ.



Аавыгаа өнгөрсний дараа нуусан эрдэнийг нь олох гэж цэцэрлэгийн бүхий л газрыг онгичин ухжээ. Ийнхүү усан үзмийн газрыг сайтар сэндийлж ухсаны ачаар жимс ихээр ургав. Хүүхдүүд ч баян чинээлэг, элбэг хангалуун амьдрах болжээ.

*Л.Н.Толстой*

2. Асуултад хариулагдах үгийг тэмдэглэж уншаарай.

- Аавын хүсэл юу байсан бэ?
- Өвгөн юу гэж захисан бэ?
- Хүүхдүүд элбэг хангалуун амьдардаг болсны учир юу вэ?
- Аавын газар булсан эрдэнэ юу байсан бэ?
- Чиний таамаглаж байсан санаа эхэд байна уу?

3. Эхийн утга санаанд тохирох зүйр үгийг сонгож учрыг тайлбарлаарай.



4. Өвгөний хүүхдүүд ямар хүүхдүүд байсан бэ? Чи яагаад тэгж бодсоноо тайлбарлаарай.


хариулт 1	хариулт 2	хариулт 3
Ажил хийж сураагүй залхуу хүүхдүүд байсан. Яагаад гэвэл: Аавынхаа ажилд тусалдаггүй байсан.	..... .....	..... .....

5. Асуултад тохирох үгийг олоорой. Олсон үгийнхээ ард тэмдэглээрэй. хэн?

- өвгөн  газар  хүүхдүүд  баян   
 цэцэрлэгч  цэцэрлэг  жимс  усан үзэм

6. Тохирох үгийг нөхөж бичээрэй.

(ажилд сургах сан гэж, хөвгүүдээ, нуусан юмыг ол гэж)



1. Шүлгийн бадаг тус бүрийг уншаад, дараах бадагт ямар үйл явдал өрнөхийг таамаглан ярилцаарай.

### Дайллага

Алаг гөлөг  
Арга ухаан сийлж  
Гавар найзаа дайлахаар  
Гадагш гарч гүйв.



Айлын бяцхан хүү  
Алаг гөлгийг хараад  
Өлсөө юу гэж асуун  
Өрөвдсөн байртай харснаа  
Үсийг нь илж энхрийлснээ  
Үмх мах өгөв.

Гавар ямар байдалтай  
байсан бол? Чи юу гэж  
бодож байна.

Алаг гөлөг гадагш гарч  
ямар арга сийлсэн бол. Чи  
юу гэж бодож байна вэ?

Идэш хийсэн айлын  
Илүү гэрийн гадаа  
Хуцаж гиншин зогсоод  
Хошуу амаа долоов.

Төсөөлсөн зүйл  
нь тохирсон уу?

Айлын хүү юу хийсэн бэ?  
Тэр гөлөгтэй ямархуу  
байдалтай ярьсан бол?

Олсон махаараа гөлөг  
Овт шарын хүүг  
Цадтал сайн дайлаад  
Цааш хоёул явжээ.

Ю. Санжаагончиг

2. Гавар, гөлөг хоёр цаашид юу болох бол? Таамаглан бодоод эхийг үргэлжлүүлэн бичээрэй.

#### Таамаглан бичихдээ:

- Таамаглалаа зургаар илэрхийлнэ.
- Таамагласан зүйлээ бусдад ярина.
- Бусдын ярьсныг сонсох, санаа авна.
- Бичиж сайжруулна.



#### Сонгох үг:

хоёр найз, зугаалав, үнэг, таарав,  
гавар, гөлөг ганцаардав

**гиншин** - сул дуугарах  
**үмх мах** - ганц үмхэх  
хэмжээтэй



1. Онъсогыг таагаад юуны тухай уншихаа таамаглаарай.



Хоёр хар морийг  
Нэг хүн  
Хол ойр ялгаагүй  
Зэрэг унадаг  
Тэр юу вэ?

2. "Зугтсан гутал" гэхээр ямар үйл явдлыг таамаглаж байна вэ? Ярилцаарай.

- Гутал зугтаж чадах уу?
- Хэргээ зугтсан бол юунаас болж яаж зугтах вэ?

3. Зугтсан гутал үг хэлдэг бол эзэндээ юу гэж хэлэх бол?

Хэлэх үгийг нь бичээрэй. Ашиглах үг: урагдсан, гомдсон, цоорсон, гялалзсан, цэвэрхэн, талархсан, шинэ гутал



Эзэндээ гомдсон юм болов уу?



Гутал нээрэн зугтдаг юм болов уу?




?

...



Халтар нүүрийг минь угаагаач.



?

...



#### 4. Өгүүллэгийг уншаад ойлгоорой.

##### Зугтсан гутал

Хүүхдүүд өдрийн хоолоо идээд, тавтайхан нойрсож харагдана. Тэд гутал хувцсаа байр байранд нь цэмцгэрхэн хураажээ.

Нэг савхин гутал олноосоо онцгойдуухан амаа дорвойлгон уйлж байв.

- Хүүе яаж байгаа чинь энэ вэ?

- Энэ.... го... го... Готов л намайг ханзалчихсан. Би хоршоонд байхдаа хэчнээн гоё байлаа. Гэтэл лааз, чулуу... Тааралдсан юмаа өшигчсөөр хамрыг минь халцлаад, амыг минь цуулчихсан. Одоо би яана аа ий... ий.... ий гэнэ.

- Нөгөө өрөөсөн чинь хаачсан бэ?

- Тэр, тэр зугтаж явна.

- Өө та нар чинь нэг хүүхдийн гутал байж яаж байгаа юм бэ? Нааш ир!

- Үгүй би очихгүй яасан ч очихгүй гээд өсгийгүй болчихсон өрөөсөн гутал хазганан явсаар далд орчхов.

Готовын янзаар явбал

Горьгүй болох нь байна шүү

Гутлаа муухай эдэлбэл

Гомдол гаргах нь байна шүү!

Л.Соронзонболд

хоршоо

хоршоо- дэлгүүр

Хоршооноос гутал худалдаж авлаа.

#### 5. Асуултын хариултыг тэмдэглэж, сонгон уншаарай.

Асуулт:

- Гутал яагаад уйлсан бэ?
- Хэний гутал вэ?
- Өрөөсөн гутал нь хаашаа явсан бэ?




Асуултын хариултыг тэмдэглэх

- Асуултын хариултыг эхээс давтан уншиж олно.
- Зөв олсон эсэхээ ярилцана.

#### 6. Нөхөж бичээрэй.

Готов ямар буруу зүйл хийсэн бэ?	Готовт хандаж юу гэж хэлмээр байна вэ?
Лааз чулуу өшиглөн....	Гутлаа гамтай ....





7. Өгүүллэгээс ямар сургамж авсан бэ?  
Тайлбарлаарай.

8. Готов хүү одоо яах бол чи юу гэж  
бодож байна вэ?

Миний бодлоор Готов хүү гуталгүй  
болсон. Гутлаа хайж олох байх. Тэгээд...

9. Сонгосон хэсгийг бүлэглээрэй.

Гутлаа муухай эдэлбэл  
Гомдол гаргах нь байна шүү!

эр үг	эм үг
гутлаа	эдэлбэл

**Сургамжтай хэсгийг  
сонгож унших**

- Сургамжтай хэсгийг дахин уншиж олно.
- Яагаад сургамжтай гэж сонгосноо тайлбарлана.



**Сэргээн санаарай**

а, о, у- эр эгшиг (**ы**)  
э, ө, ү, и- эм эгшиг (**ий**)



10. Өгүүллэгээс тодруулсан үгийг загварын дагуу тайлбарлаарай.

Үлгэрлэвэл: өдрийн - “ө” эм эгшиг учир эм үг - (**ий**) бичсэн.

11. Гутлаа хэрхэн арчилдаг вэ? Ярилцаарай.

12. Зургийг ажиглаарай. Аль нь зөв бэ? Яагаад?



**Үнэлгээ:** Чаддаг болсон зүйлээ асуултын дагуу бичээрэй.

- Асуултын хариултыг сонгон уншиж сурсан.





асуулт

хариулт

.....

.....

1. Өгөгдсөн зургаас үйл явдлыг таамаглан ярилцаарай.



**Хэрэмний аялсан тэмдэглэл**

Зуны амралт болж хорилдой аялал хийж зуны халуун өдрүүдийг ардаа хийхээр шийджээ. Тэрээр ойг гатлан нэг горхины хөвөөнд очиж ус авахаар яваа цагаан бөжинтэй таарав. Цагаан бөжин модон хувингаа усан дотор тавиад хөдөлгөж чадахгүй байгааг хараад хорилдой яаран түүнд тусаллаа.

- Чамд баярлалаа. Чи тун сайн юм гэж цагаан бөжин сэтгэл догдлон хэлээд хорилдойг гэртээ урьж хамт тоглов. Хорилдой цагаан бөжингийнд очиход цагаан бөжингийн ээж нь түүнийг дотносон хүлээн авчээ. Цагаан туулайн ээж хорилдойн юмны учрыг ойлгодог, сайхан сэтгэлтэйг мэдээд цагаан бөжин, хорилдой хоёрыг хамт аялуулж, тэр хоёр их юм сурч мэдэж авчээ.

*Ж.Мягмарсүрэн*

2. Асуултад хариулж ярилцаад үргэлжлүүлэн асуулт зохиогоорой.

- Хорилдой зуны амралтаа яаж өнгөрүүлэхээр шийдсэн бэ?
- .....
- .....

3. Хорилдой, бөжин хоёрын нэрийг хүүхдийн нэрээр сольж уншаад, ээжийн тухай өгүүлсэн хэсгийг хуулан бичээрэй.

4. Цэгийн оронд тохирсон үгийг нөхөж бичээрэй. (Нөхөх үгс: хорилдой, цагаан бөжин, аялж)

- Хэрэмний зулзагыг ..... гэдэг.
- Хорилдой ..... хоёр хамт ..... их юм мэдэж авчээ.



### 5. Ямар алдаа байгааг олоод, засаж бичээрэй.

Хорилдой бөжин хоёр аялах замдаа мод тарих цэцгийн мандал байгуулах ажилд маш идэвхтэй оролцжээ.

#### Сэргээн санаарай

- Мөр шилжүүлэхдээ үеэр зааглах дүрмийг сэргээн санаарай.

### 6. Хорилдой бөжин хоёрын аяллын тухай тэмдэглэлийг уншиж ярилцаарай.

Намайг Хорилдой гэдэг. Би зуний өдрүүдээр ойд аялахаар шийдсэн. Аялах замдаа бөжинтэй тааралдаж, сайн найзууд боллоо. Би бөжинг “дэлдэнхэн” гэж нэрлэсэн. Бид хоёр олон газруудаар аялж, сонин сайхан зүйл их сурсан. Мод тарьсан. Бас “дэлдэнхэн”-д самар яаж цөмөхыг зааж өгсөн.

Намайг Хорилдой гэдэг. Би **зуны** өдрүүдээр ойд аялахаар шийдсэн. Аялах замдаа бөжинтэй тааралдаж, сайн найзууд боллоо. Би бөжинг “**Дэлдэнхэн**” гэж нэрлэсэн. Бид хоёр олон **газруудаар** аялж, сонин сайхан зүйл их сурсан. Мод тарьсан. Бас “Дэлдэнхэн”-д самар яаж **цөмөхийг** зааж өгсөн.

### 7. Бөжингийн бичсэн тэмдэглэлийн алдааг засаарай.

би зуны амралтаар хэрэмны зулзага хорилдойтой танилцсан. Тэр их тусч сайхан сэтгэлтэй. Миний ээж цагаан туулай хорилдойг магтсан. ээж бид хоёрыг хамт аялахыг зөвшөөрсөн. Би хорилдойг “соотонхон” гэж нэрлэсэн. Бид хоёр мод тарьж, цэцгын мандал байгуулахад оролцсон.

### 8. Дуурайж аяллын тэмдэглэл бичээрэй.



**хорилдой** - хэрэмний зулзага  
**догдлох** - баярлах хөөрөх

1. Зургийг ажиглаад таамаглан ярилцаарай.



2. Уншаад ярилцаарай.

### Цэцэгхэн хотын тагжгарууд

Үлгэрийн нэгэн хотод жижигхэн хүмүүс амьдран суудаг байжээ. Тэд маш намхан байсан тул тагжгарууд гэж нэрлэдэг байв. Биеийн өндөр нь өргөст хэмхний л чинээ юм. Тэд үнэхээр сайхан хотод аж төрдөг. Байшин бүрийн эргэн тойронд хонин нүдэн цэцэг, балжингарав, багваахай цэцэг ургана. Тиймээс энэ хотыг “Цэцэгхэн хот” гэдэг юм. Энэ хотод мэдлэг ихтэй Ихмэдэх, Үрэлхэн эмч засварчин Эрэгжав өөрийн туслах Шурагжав, зураач Бийрхэн, Ятгахан гэдэг хөгжимчин, анчин, Сумхан, Хүдэр гэдэг нохойтойгоо олон тагжгарууд амьдран суудаг байжээ. Тэднээс хамгийн алдартай нь Үлмэдэх байв.

*Н.Носов*

3. Асуултад хариулж бичээрэй.

- Үлгэрийн хотыг яагаад “Цэцэгхэн хот” гэж нэрлэсэн бэ?
- Хотын оршин суугчдыг юу гэж нэрлэдэг вэ? Яагаад

4. Зургийг ажиглаад нэрийг бичээрэй.



Үлмэдэх .....



.....



.....

### Сэргээн санаарай

- Оноосон нэрийг бичихдээ том үсгээр эхлэн бичнэ.
- Өгүүлбэрийн эхний үсгийг томоор бичнэ.





.....

.....

.....

.....


5. Эхээс цэцэгний тухай өгүүлсэн хэсгийг сонгож бичээрэй.

.....

6. Мөр шилжүүлэн бичихдээ хэн нь ямар алдаа гаргасан бэ?

Их мэдэх	Үл мэдэх
Байшин бүрийн эргэн тойронд хонин нүдэн цэцэг, балжингарав, багваахай цэцэг ургана.	Байшин бүрийн эргэн тойронд хонин нүдэн цэцэг, балжингарав, багваахай цэцэг ургана.

7. Үгийг тохирох асуулттай нь харгалзуулаарай.



8. Ажиглаж ярилцаад бичээрэй.

цэцгийн сав	Цэцэгийн дүү	Цэцэгхэн хот
жигжиг үрэл	Үрэлийн ном	Үрэлхэн эмч
эрэг шураг	Эрэгжавын түлхүүр	Шурагжавын багаж

9. Уншаад ярилцаарай.

Багш **цэцгийн** сав авлаа.  
Өнөөдөр **Цэцэгийн** төрсөн өдөр.  
Бид **Цэцэгхэн** хотын тухай уншив.

Өөрийгөө үнэлээрэй. 😊 😐 😞

10. Асуултын дагуу өгүүлбэр зохиогоорой.

Ашиглах үг: (үрэл, Үрэлхэн, Үрэл)  
Хэн? ямар? юу? яав?  
Хэзээ? хэний? ямар? юу вэ?

1. Оноосон нэрийг зөв бичсэн	
2. Оноосон нэрийн заримыг зөв бичсэн	
3. Оноосон нэрийг буруу бичсэн	


## Ес, тэг хоёрын үлгэр

1. Аль нь зөв бэ? Яагаад?  $99 + 1 = 1$  ?  $399 + 1 = 4$   
 “0”-ийн тухай чи юу мэдэх вэ?  $9 + 1 = 10$   $99 + 1 = 100$

2. Эхлэл, гол, төгсгөл хэсгийг таньж ялган уншаарай.

Гэтэл нэг удаа нэг-ийн тоо гурвалжин, гонзгой хэдэн шугамтай танилцаж гэнэ. Шинэ танилуудынх нь хэмжээс томоо гэгч тэг-ээр эхэлсэн харагдав. Нэгийн тоо уурлаж:

- Энэ тэг яахаараа миний өмнө бичигддэг байна аа? 0 гэдэг чинь ямар ч утгагүй хоосон гэсэн үг биз дээ? гэхэд тэг инээмсэглэн тайвнаар:
- Би ямар ч утгагүй, юунд ч хэрэггүй гэж үү? гэхэд нэг-ийн тоо:
- Тийм ээ, тийм. Чи бол жинхэнэ хоосон зүйл. Арван тэг-ийг нэмээд үзье. 0 гарна. Бүр зууг ч нэмье. Бас л 0 гарна биз дээ? Харин арван нэг-ийг нэмье. 10 гарч байна шүү дээ хэмээлээ. Тэг юу ч хэлэлгүй толгой дохин жуумалзав.



Тэгээд нэг-ийн тоог хашраахаар шийдэж номын ертөнцөөс яваад өгчээ. Үүнийг тооны хаан сонсоод бараа бологчдоо дагуулан номын ертөнцөөр аяллаа. Зам зуураа тэднээр тоо бодуулжээ. Гэтэл  $9 + 1 = 1$ ,  $99 + 1 = 1$ , бүр  $399 + 1 = 4$  гарахад тоонууд “Буруу, буруу гэж ам амандаа хашхирав. Тооны хаан:

- Зөв бодлоо. Ард нь зогсох тэг-үүд хаачив хэмээн асуухад:
- Нэг мэднэ, нэг л мэднэ. Онгиороо нэг... гэж шуугихад нэг сая буруугаа мэдэн ичсэндээ нүүр нь улайн зогсов

Нэгэн сурах бичгийн тоонууд хүртэл маргалддаг ажээ. Энэ бүхэн нэг-ийн тооноос л болжээ. Тоо тооны дундаас нэг-ийн тоо ер нь их онгиороо гэнэ. Тэр “Ертөнцийн юм бүхэн нэг”-ээс эхэлнэ. Тэгш, сондгой бүх тооны тэргүүлэгч нь би. Хэрвээ би байхгүй бол хэн ч юу ч хэмжиж чадахгүй” гэж ярих дуртай гэнэ.

3. Асуултын дагуу ярилцаарай.

- Тоонууд юунаас болж маргах болов?
- Нэг, тэг хоёр магадгүй хэрэггүй байсан бол яах вэ?

4. Дахин уншихдаа таалагдсан хэсгээ тэмдэглэн уншаарай.

5. Үлгэрийн баатруудын дүрд тоглоорой.




баатрууд	дууны өнгө	нүүрний хувирал	биеийн хөдөлгөөн
“0” тоо	дээрэнгүй	.....	гараа гозгонуулах
“1” тоо	.....	тайван амгалан	.....
тооны хаан	.....	.....	захирч тушаасан
бараа бологч	тал зассан	.....	.....

Бараа бологч - дагалдагч



### 1. Асуултын дагуу яриарай.



Тэд юуны тухай  
ярилцсан бол?



Цаашид яах  
бол?



Үлгэр яаж төгсөхийг  
таамаглаарай.

### 2. Үлгэрийн баатруудын дүр төрх, үйл хөдлөлийг таамаглан уншаарай.

#### Гөлөг зулзага хоёр

Нэгэн айлын гөлөг, муурын зулзага хоёр эв найртай, сайхан амьдардаг байжээ. Тэд нэгэн удаа оюунаа сорьж тоглох болов. Муурын зулзага:

- Дахиад нэг оньсого хэлээрэй. Дэлхийн бүх оньсогыг би мэднэ гэж хөөрөхөд гөлөг:

- Гуруй гуруй биетэй гучин гурван нуруутай

Шарга шарга биетэй шар шувуу нүдтэй тэр юу вэ? Үүнийг таа даа гэв. Зулзага:

- Яасан амархан оньсого вэ? Яг л оготно байна мөн үү? Гөлөг:

- Хүүе, яана аа! Зулзага минь. Хэзээ оготно том нүдтэй байсан юм бэ? хэмээн шоолов. Зулзага:

- Аа мэдлээ, мэдлээ. Аймаар урт могой байна тийм үү? хэмээн мэдэмхийрэх үед гөлөг:

- Би ямар гоё оньсого хэлэв ээ. Бодоод бодоод чи таахгүй юм байна гэж хорыг нь малтахад зулзага:

- Тэгвэл наадах чинь тэмээ юм уу? Эсвэл эрвээхэй л байна. Тэр хоёрыг би сайн таньдаг юм гэж өөрийгөө магтав. Гөлөг:

- Гуруй гуруй биетэй гучин гурван нуруутай, шарга шарга биетэй, шар шувуу нүдтэй зулзага чи л байна шүү дээ гээд инээхэд зулзага:

- За, чамайг даа! Заавал гүйцэж маажна даа гээд ухасхийв. Энэ үед гөлөг:

- “Мэддэгт мэргэн цоохор мэддэггүйд эрээн цоохор гэдэг чинь энэ шүү дээ хэмээн сургамжилжээ.

### 3. Сонирхолтой санагдсан хэсгээ дахин уншаарай. Чиний таамаглалаас ямар байна?

### 4. Баатруудын яриаг гүйцээн бичээрэй.



Дахиад ..... би мэднэ.  
.....  
Яасан амархан.....  
..... могой .....  
..... маажна даа




..... тэр юу  
вэ?..... гоё  
..... шар.....  
эрээн цоохор  
гэдэг энэ шүү дээ.



### 5. Хүүхдүүд ээ! Зургийн дагуу эхийн эхлэл хэсгийг өөрчилж үзье.

- Цаашид юу болох бол?
- Энэ хоёрын тоглоом яаж төгсвөл чамд тааламжтай байна вэ?

1. Дараах үгийг уншаарай. Хэлэх болон сонсоход ялгаа байна уу?



2. Энэ үгсийг уншихад чамд юу төсөөлөгдөж байна.



3. Бусадтай ярилцахдаа дараах асуултыг ашиглаарай.

- Яагаад сонсох, хэлэх нь адил үгийг хэдэн янзаар бичсэн бэ? (бэлэг-билиг)
- Чи, өвлийн өвгөний бэлэг гэж бичдэг үү? Билиг гэж бичдэг үү? Яагаад?
- Үүнтэй адил хэлэх, сонсох нь адил, бичих нь өөр ямар үг мэдэх вэ?
- “төрх, торх, шарх” гэвэл чи юу төсөөлж байна?

4. Өгүүллэгийг уншихдаа “бэлэг, билиг” гэсэн үгийг тэмдэглээд, уншингаа төсөөлөөрэй.

### Төрсөн өдрийн бэлэг

Миний найз Хонгорзулын төрсөн өдөр 6 сарын 5-нд болно. Би мартагчгүйн тулд хуанли дээр тэмдэглэлээ. Найзтайгаа хичээлд явахаар бид хоёрыг эгч дүү хоёр уу? гэж хүмүүс асуудаг байлаа. Төрсөн өдөр дөхөж би бэлэг авахаар дэлгүүрт ортол, Хонгорзул, “Маргааш миний төрсөн өдөр, би бэлэг авч байна” гээд төрсөн өдрийн баяртаа урив. Би найзууддаа бэлэг авч байгаа юм байна гэж бодоод Туяад бас Өнөрзулд хэллээ. Маргааш нь Хонгорзулын төрсөн өдрийн баярт очтол бидэнд бэлэг өгсөнгүй, харин: Энхрий хөөрхөн биеийг минь төрүүлсэн. Эрдэм ном, билиг оюуныг минь тэжээсэн ээждээ бэлэг барья гэлээ. Жижигхэн хөөрхөн найзыг минь “Миний охин их том болж” гэхийг сонсоод би ээждээ төрсөн өдрөөрөө бэлэг барина, тэгэхдээ өөр бэлэг барина гэж бодсон... (Сурах бичгийн зохиогчид)

5. Энэ хоёр үгийг яагаад өөр, өөр бичсэнийг өгүүллэгээс уншиж тайлбарлаарай.

Уншингаа төсөөлсөн үгийн сонголт	Тайлбар
бэлэг	
билиг	

6. Дээрх хоёр үгэнд эгшиг үсэг хэд байна? Эгшгээ ашиглаад үелж бичээрэй.

## Үгийг үелж сурах уу?



Та нар үелж сурснаа яаж мэдэх вэ?

Үгийг үелдэг аргыг мэднэ, түүнийгээ ашиглаад үеийн заагийг олно.



Үгийг эгшгийн тоогоор үелж бичнэ. Үелэхдээ юуг ашигладгийг тодорхойлж сурна.



**1-р алхам:** Ертөнцийн гурвыг уншихдаа үелж уншаарай.



Тостойгоос тогоо хар  
Билигтэйгээс бэх хар  
Амттайгаас архи хар

**2-р алхам:** Дараах ертөнцийн гурвыг хуулж бичээд, хэрхэн үеэр заагласныг ажиглаарай.



Сал|хи|тай тэн|гэ|рийн үүл хур|дан  
Са|руул у|хаант|ны са|нах хур|дан  
Сайн мо|ри|ны яв|дал хур|дан

**3-р алхам:** Асуултын дагуу ярилцаарай.

- Би|лиг|тэй|гээс гэхэд гийгүүлэгчээр зааглагдсан хэдэн эгшиг байна.
- Тэгвэл бусад үгийн эгшгийг нь тоолоод үелээрэй.
- Эгшиггүй үе байна уу?
- Гийгүүлэгчгүй үе байна уу?
- Үеийг зааглаж байгаа ямар үсэг байна.
- Үеийн заагт 3 гийгүүлэгч байвал яаж заагласан байна?



Үг хэдэн эгшигтэй байна, түүний тоогоор үе болно.

**4-р алхам:** Үеийн бүтцийг ажиглаад, үеэр тасалсан үгээ бүлэглээрэй.

1 үетэй үг	2 үетэй үг	3 үетэй үг	4 ба түүнээс дээш
бэх, .....	цэн хэр, хур дан, .....	ер төн цийн, .....	би лиг тэй гээс, .....

**5-р алхам:** Хэрхэн багцалсныг ажиглаад тайлбарлаарай.

(э-эгшиг, г-гийгүүлэгч) Дутууг нь олоорой.



**6-р алхам:** “Төрсөн өдрийн бэлэг” эхийг дахин уншихдаа харандаагаар үелж тэмдэглээрэй.



1. Уншаад ойлгоорой.
2. Өнгөөр ялгаж бичсэн үгийг ажиглаарай.
  - Мөрд багтаагүй үгийг яаж бичсэн байна вэ?
  - Нэг эхийг гурав дахин бичсэний учир юу вэ?



### Чих

Гадаа хүйтэн байлаа. Энхээг гарах гэхэд нь эмээ нь: - Миний хүү малгайгаа өмсөөрэй! гэв. Энхээг эмээгийнхээ үгийг огт дуулсан шинжгүй гарахад шинэхэн цас орсон байв. Тэр цасан дээр элдэв юмны дүрс зурж эхлэв. Тэгтэл гэнэт чих нь бахиар хавчих адил часхийн янгинан өвдөв. Энхээ:

- Би одоо эмээгийнхээ үгэнд орно гэж чихээ барин дэвхцэн уйлав. Гэвч хожимдсон байлаа.

М.Доржсүрэн

3. Өгүүллэгийг дахин уншихдаа гол утга санаа бүхий өгүүлбэрийн доогуур харандаагаар зурж тэмдэглэн уншаарай.

### Чих

Гадаа хүйтэн байлаа. Энхээг гарах гэхэд нь эмээ нь: - Миний хүү малгайгаа өмсөөрэй! гэв. Энхээг эмээгийнхээ үгийг огт дуулсан шинжгүй гарахад шинэхэн цас орсон байв. Тэр цасан дээр элдэв юмны дүрс зурж эхлэв. Тэгтэл гэнэт чих нь бахиар хавчих адил часхийн янгинан өвдөв. Энхээ:

Би одоо эмээгийнхээ үгэнд орно гэж чихээ барин дэвхцэн уйлав. Гэвч хожимдсон байлаа.

М.Доржсүрэн

4. Эмээгийнхээ үгэнд ороогүйгээс юу болсон бэ? Асуултад хариулж сонгосон хэсгээ хуулж бичээрэй.

Чих

Гадаа хүйтэн байлаа. Энхээг гарах гэхэд нь эмээ нь: - Миний хүү малгайгаа өмсөөрэй гэв. Энхээг эмээгийнхээ үгийг огт дуулсан шинжгүй гарахад шинэхэн цас орсон байв. Тэр цасан дээр элдэв юмны дүрс зурж эхлэв. Тэгтэл гэнэт чих нь бахиар хавчих адил часхийн янгинан өвдөв. Энхээ: Би одоо эмээгийнхээ үгэнд орно гээд дэвхцэн уйлав. Гэвч хожимдсон байлаа.



Багшийг сонсоод бичээрэй.

**Билиг** оюунаа хөгжүүлье  
**Бэлгэ** дэмбэрлийн үг хэлэлцье



5. Мөрд багтахгүй бол шинэ мөрд шилжүүлэхдээ хэрхэн шилжүүлсэн байна вэ?

өм-сөөрэй, өмсөө-рэй, тэг-тэл, малгай-гаа, мал-гайгаа, га-рахад, гара-хад, хожимдсон, хожимд-сон, шинж-гүй, дэвх-цэн гэж шинэ мөрд шилжүүлэхдээ хэдэн янзаар, ямар онцлогтойгоор шилжүүлсэн байна вэ? Хосоороо ярилцаарай.

Үеэр таслан шилжүүлнэ. Мөрийн адагт үеэр тасалж болж байгаа ч ганц эгшиг мөрийн адагт үлдээж мөрд шилжүүлэхгүй. Жишээ нь: а|рав = арав, энэ үгийг мөрд шилжүүлэхгүй.


6. Мөрд шилжүүлэх загвар гаргая. Яаж гаргаж болох вэ?

Өгүүллэгээ ашиглаарай.

А. Загвар - (үеийн заагт нэг гийгүүлэгч байвал яах вэ?)

Б. Загвар - (үеийн заагт хоёр гийгүүлэгч байвал яах вэ?)

В. Загвар - (үеийн заагт гурван гийгүүлэгч байвал яах вэ?)



7. Нүх шахах тоглоомын карт ашиглан эхийг өрж тоглоорой.



жаа-

-дөг

-жээ

дөр-

**Тоглоомын заавар:** 10 сантиметрийн зайд үгээ багтаана, багтахгүй бол үеэр тасалж шилжүүлнэ. Үе тус бүрийг багцын өнгөөр ялгаж бичээд хэрчмэл байдлаар бэлтгэсэн байна.

**Тоглох карт**

1 дэх багц карт. Нэг жаа- -хан хүү- -хэд сагс- -тай өн- -дөг барьж яв- -тал морь- -той хүн саг- -сыг дай- -ран у- -на- -га- -лаа.

2 дахь багц карт. Өн- -дөг ха- -гарч хүү уй- -лав.

3 дахь багц карт. Бит- -гий уйл. Өн- -дөг авч өгье гэ- -жээ.

4 дэх багц карт. Хэч- - нээн өн- -дөг бай- -сан юм.

5 дахь багц карт. Тоог нь март- -чих- -жээ. Хос хо- -соор тоо- -ло- -ход нэг өн- -дөг, гу- -рав гур- -ваар тоо- -ло- -ход бас нэг өн - - дөг, дөр- -вөөр тоо- -ло- -ход мөн л нэг үл- -дэж, ха- -рин тав таваар тоо- -ло- -ход үл- -дэг- -дэл- -гүй таарч бай- --- сан. Хэч- -нээн өн- -дөг бай- -сан бол?

8. Мөрийн адагт дараах үгс байвал чи яаж, хэдэн янзаар мөрд шилжүүлэх вэ?

Бичээд найздаа тайлбарлаарай. Үгс: тоолоход, үлдэж, үлдэгдэлгүй, унагалаа, мартчихжээ, сагстай, таваар. Үлгэрлэвэл: эмээгийн, итгэлээрээ эмээ-гийн 3 үетэй үг ч мөрд шилжүүлэхэд нэг л янзаар мөрд шилжүүлнэ. Харин ит-гэлээрээ, итгэ-лээрээ, итгэлээ-рээ гэж 3 янзаар шинэ мөрд шилжүүлнэ. 4 үетэй үг.

1. Аль нь том бэ? шүлгийг цээжлээрэй.



**Цээжлэхдээ:** Өнгөөр ялгасан үгээ нүдэлж тогтоогоорой. Тогтоохдоо орчин дахь үгийг нь утгачлан холбож ойлгоорой.

**Нүдэлж бичихдээ:** Өнгөөр ялгасан үгийг нүдлээд, мөр мөрөөр нь хуулан бичээрэй. Хуулж бичихдээ давтагдсан үгийг нүдлээд бичээрэй.







2. Нүдэлж бичээрэй.

Хонины ..... уушгинаас жижиг.  
Хонины ..... гуянаас жижиг.  
Хонины ....., ..... гэдэснээс бага.  
Хонины ..... таван цул эрхтэн, ходоод, зайдас, гүзээ зэрэг орно.  
Хонины ..... эрхтэнд зүрх, уушги, бөөр, элэг, дэлүү орно.

3. Аль нь том бэ? Яагаад?

4. Хуулж бичихдээ гурав ба түүнээс дээш давтагдсан үгийг үелж бичээрэй, мөрд шилжүүлэх хэдэн боломж байна вэ?

5. Үеэр үг бүтээж уншаад, зураглалыг ашиглан өөрсдөө зохиож тоглоорой.





1. Толь бичиг ашиглаад, дараах үгсийн утгын тайлбарыг хуулж бичээрэй. Хуулан бичихээсээ өмнө өөрийнхөө төсөөллийг бичээрэй. (зурж болно)

үг	миний төсөөлөл	толь бичгийн тайлбар
Улаанбаатар хот	Монголын хамгийн том нийслэл хот, их олон хүнтэй олон машин сүлжилдсэн, өндөр байшингуудтай, би тэнд паркад тоглож байгаагаар өөрийгөө төсөөлж байна.	Монгол улсын нийслэл
хот айл		
хоттой хонь		

4. Бичихэд хүнд үгийг тэмдэглэн дахин нүдлээд хуулахдаа харж бичих, аажмаар нүдэлснээ шалган харалгүй бичихийг хичээгээрэй.

3. Үг, өгүүлбэрээ бичихдээ үгийг хоёр хоёроор нь харж хуулан бичнэ. Хуулж бичихдээ үгээ эхлээд хоёр хоёроор нь харж бичээрэй. Хэсэг хугацааны дараа гурваар нь, дараа нь бүтэн өгүүлбэрээр нь нүдлээд, хуулж бичээрэй.

**Хуулж  
бичих  
алхам**

1. Эхлээд бүтнээр нь уншиж бичих зүйлийнхээ утгыг ухаарч ойлгоно.

2. Хамт суудаг найздаа ойлгосноо яриарай.

2. Хуулан бичсэн үгийнхээ тайлбарыг ярилцаарай. Хуулж бичихдээ мөрд шилжүүлэх дүрмээ санаарай.
3. Өгүүллэгийг уншихдаа толь бичиг ашиглаж шинээр мэдсэн үгээ тэмдэглэж уншаарай.




### Ховдог жаал

Хөдөөний айлууд сайхан заншилтай. Хонь төхөөрөөд хотолж буусан хэнийд боловч гэдэс, шөлнөөс нь өгдөг. Бяцхан ховдог жаал Балганы хөгтэй явдал санаанаас гардаггүй юм. Нэгэн намар тэднийх хонь төхөөрчээ. Тэгээд айлынхаа хүмүүст амсуулж, шөл уулгах гэж тавганд гэдэс хийж хүүгээрээ өгч явууллаа. Жаахан Балган хажуу айлдаа очих гэж хоттой хонин дундуур явахдаа маш их хорхой нь хүрсэн тул эргэж ирэхдээ идье гэж бодоод зүрх, уушгийг нь хэвтэж байсан том сүүлтэй хонины нуруун дээр тавьчихаад айлд оржээ. Буцаж ирээд өнөөх том сүүлтэй хонио олсонгүй. Өглөө нь хонио бэлчээсэн ээж нь нэгэн том хонины нуруун дээр зүрх, уушги наалдсан байхыг харж хүүгийнхээ ховдгийг гайхан түүнийг дууджээ. Жаахан Балган гэрээс гүйн гарч ирээд өнөөх хонины нуруун дээрхийг харж царай нь ув улаан болжээ.


Д.Гармаа

4. Асуултад тохирох хариултыг эхээс хуулж бичээрэй.
  - Эхэд ямар заншлын тухай өгүүлсэн байна вэ?
  - Балдангийн царай улаан болсон шалтгаан юу вэ?
  - Хүүгийнхээ ховдгийг яаж мэдсэн бэ?
5. Хоёр янзаар мөрд шилжүүлж болох үгийг өгүүллэгээс олж, үеэр тасалж бичээрэй.  
Жишээ нь: хө-дөөний, хөдөө-ний



### СОНСГОХ ЗОХИОЛ: ХӨГЖӨӨНТЭЙ ТУУЖ

1. “Хөгжөөнтэй тууж” эхийг сонсоод ярилцъя.  
(Багш нь эхний хэсгийг уншина.)
  - Ямар үйл хөдлөл болж байна вэ? Хаана, ямар газар, ямар улиралд энэ үйл хөдлөл болж байна төсөөлөн ярилцаарай.
  - Банзай тэр ямааг яах бол? Яагаад, ямар учраас чи тэгж бодсон бэ?
2. Өгүүллэгийн гол хэсгийг үргэлжлүүлэн сонсоорой. Асуултад хариулж бичээрэй.
  - Сахлаа хайчлуулсан ямаа яах бол?
3. Хэрхэн төсөөлж бичсэнээ багаараа ярилцаарай.
4. Өгүүллэгийн төгсгөлийн хэсгийг уншиж өгнө. Сайн сонсоод “САХЛАА ХАЙЧЛУУЛСАН ЯМАА” төсөөлөн бичсэн зохиолоо баяжуулж бичээрэй.



5. Дараах өгүүлбэрийг уншаад үйл хөдлөлийн дарааллын дагуу хуулж бичээрэй.
  - Банзайд ихэд таалагдсан бололтой хэдэнтээ илж, гараараа манах мэт оролдож байснаа хайчаа авч ганц тасхийлгэн хайчилж орхив.
  - Банзай нэг ямаа эвэрдэж аваад шууд л хүзүүн дээр гараа тавьснаа сахлыг нь илж харагдав.
  - Чи мал мэддэггүй хүн үү, хэзээ монгол хүн ямааны сүр чимэг болсон сахлыг авч байлаа гэж нэг ах зэмлэв.
  - 4 Бусад ямаа хажиглана даа гэж ах ууртай өгүүлэхэд өнөөх ямаа “Нээрээ сахалгүй, би яана аа” гэх шиг гомдолтой майлж байлаа.





1. Зургийг ажиглаад ярилцаарай.



2. Харав, харва үгсийг үеэр зааглаж, утгыг нь бичээрэй.

бичих үгс	харав	харва
миний бодлоор		
толь бичигт		



3. Тодруулсан үгийг нүдэлж уншаад, үеэр тасалж хуулж бичээрэй.

### Сур харвах ёс

Сур харвах эртний ёсонд харвасан сумыг хулгана жилд төрсөн хүнээр цуглуулдаг нь “Хулгана юм сайн хураадаг амьтан” гэсэн утгатай холбоотой. Харвааны анхны сумыг бар жилд төрсөн хүн тавьдаг нь “Бар шиг мэргэн харайх” утгыг агуулжээ. Мөн луу жилд төрсөн хүнээр харваачдад зориулсан “Уухай”-г эхлүүлдэг. Бичин жилд төрсөн хүнээр оноо тэмдэглүүлдэг нарийн ёс горимыг баримталдаг байжээ.

4. Эхээс сонгон хуулж бичээрэй.

Ямар үйл хийдэг	Бэлгэдэл нь юу вэ?

5. Ширээнийхээ найзаар хэлүүлж, дээрх эхийг цээжээр бичээрэй.  
(Харилцан бие биедээ хэлж өгч цээжээр бичүүлнэ.)

6. Сурах бичгийнхээ эхтэй тулгаж алдсан эсэхээ шалгаарай.

7. Чи ямар жилтэй вэ? Чиний дүү, ах, эгч ямар жилтэй вэ? Ярилцаад, 12 жилийг гүйцээн бичээрэй.



## Би чадна.

1. Үлгэрийг уншиж ойлгоод, асуулт зохиогоорой.

### Хонх (домог үлгэр)

Эрт цагт нэг хүн хаан болж хамаг дэлхийг эзэгнэж, хар толгойтой болгоныг захиран суухыг мөрөөддөг байжээ.

Тэгтэл тэр нутгийн хаан өөд болж нөгөө хүн хаан болов. Тэрээр хаан ширээнд суунгуутаа л бүх түшмэдүүдээ цуглуулаад,

- За би хамаг дэлхийг эзэгнэн, хар толгойтон болгоныг захирах цаг болсон биз? гэж асуужээ. Тэгтэл нэг түшмэл,

- Хаантан минь, таны захирахыг огт тоохгүй зуун хүн, зөвхөн энэ хотод байна шүү гэж гэнэ. Хаан ихэд уурлаж,

- Миний тушаалыг дуулахгүй тэр танхай хүмүүсээ өнөө шөнийн дотор миний ордонд ирүүл. Би яадгийг нь үзүүлээд өгье гэжээ. Тэгэхээр нь нөгөө түшмэл хоёроос гурван настай дөнгөж явж сурч байгаа зуун хүүхэд цуглуулаад, хааны ордонд авчирчээ.

Нэг хэсэг нь уйлсан, зарим нь инээж, зарим нь хааны ордны үнэт зүйл, гоёл чимэглэлийг авах гэж чарлан хүн юу ч гэсэн огт тоохгүй дур дураараа аашилж гарчээ. Хаан өөрийнхөө хэлсэн үгнээсээ ихэд ичиж,

- Эд үнэхээр захиргаагүй улс юмаа. Хаа дуртай газраа явцгааж л байг.

Цөмд нь хонх зүүж өг. Хонхны чимээгээр хаа явааг нь олж мэдэж байг гэж хэлжээ. Тэгээд хүүхдэд зүүдэг хонх гарсан юм гэдэг.

2. Тодруулсан хэсгийг хуулж бичээд, үеэр таслаарай.

3. Үеэр тасалсан үгээ бүлэглээрэй (Э, ГЭ, ГЭГ, ГЭГГ, нэг үетэй, хоёр үетэй ...).

4. Мөрд шилжүүлэхдээ буруу шилжүүлсэн хэсгийг олж тайлбарлаарай.

*Газар шороо, уул усал  
монголчууд хүний мэд-  
рэл, цуцны судастай  
ажилтан үздэг байжээ.  
Түний судсыг тасал-  
бал үхдэгийн нэгэн а-  
диг газрын судсыг та-  
салбал байгаль үхдэг.  
Тиймээс хамаагүй га-  
зар ухах, хавар мод  
тайрах хамгийн цээртэй.*

5. Банзай бид хоёрын бодсон зөв бол (+), буруу бол (-) тэмдэг тавиарай.

- Банзай **ноосолно** үгийг эгшгийн тоогоор нь гурван үе болгосон.
- ЭГ гэсэн бүтэцтэй үе байна, харин ГЭ гэсэн бүтэцтэй үе байхгүй.
- Би үеийн заагт хэдэн гийгүүлэгч байна, хамгийн сүүлчийн гийгүүлэгчийн өмнүүр үелнэ гэлээ.
- **харваа** гэхэд гурван үе байна гэж Банзай надад хэлсэн.
- Мөрийн адагт дан эгшгээс бүтсэн үе үлдээж мөрд шилжүүлэхгүй.
- Би адуугэдэг үгийг үеэр таслаад мөрд шилжүүлнэ гэж бодож байна.



# ЭСРЭГ УТГАТАЙ ҮГИЙГ ХЭРЭГЛЭЖ СУРЦГААЯ



1. Аль нь зүйр үг, аль нь оньсого вэ? Ярилцаарай.

Хол явъя гэвэл ойроос эхэл  
 Ихийг хийх гэвэл багаас эхэл  
 Унтаж, мартаx уруудахын шинж  
 Санаж сэрэх өөдлөхийн шинж  
 Харахад бага  
 Ханилахад их

2. Өнгөөр ялгаж бичсэн үгийг хоёр хоёроор нь хуулж бичээрэй.  
 Үлгэрлэвэл: мартаx-санах, өндөр-нам, .....


3. Зургийг ажиглан эсрэг утгатай үгийг гүйцээж бичээрэй.



өдөр




.....



.....



хаах



.....

.....




.....

.....




.....



.....

4. Үгийн сүлжээн дэх эсрэг утгатай үгийг олоорой. Зөв олбол догшин гэдэг үгийн эсрэг утгатай үг үүснэ.



өндрийн  
 холын  
 сайны  
 цагааны  
 цөөний  
 дайсны



эсрэг утга

.....

5. Цэгийн оронд үг нөхөж бичээрэй. Ямар эсрэг утгатай үг үүссэн бэ? Ялгаж бичье.

**Сайныг** дагавал сарны гэрэл  
..... дагавал могойн хор

**Үнэн** үг үнэд хүрнэ  
..... үг хор хүргэнэ

**Эрхийг** сурахаар  
..... сур

**Авахдаа** бөхийх  
..... гэдийх

**Инээсэн** бүхэн **нөхөр** биш  
..... бүхэн ..... биш

**Өлсөхөд** өлөн бугын эвэр **зөөлөн**  
..... цагаан хурганы сүүл .....

үнэн		нөхөр		зөөлөн		авах	
	инээх		өлсөх		эрх		сайн

6. Загварын дагуу эсрэг утгатай үгээр зүйр үг зохиож бичээрэй.

**Алхам 1:** Хүн, юм, үйл хөдлөл, шинж байдлын эсрэг утгыг гаргах уу гэдгээ бодоорой. Тухайлбал: хүний сайн, муу чанарын тухай бичье.

**Ажилч хүн арван гартай,**  
..... хүн ганц гаргүй  
тэгвэл ямар хүн ганц гаргүй мэт байж болох вэ?

**Зохиохдоо:**

- Ямар үгний эсрэг утгыг гаргахаа сонгоно.
- Аль үг нь оновчтой байгааг олон үгээс сонголт хийнэ.
- Эсрэг утга гаргаж чадсан эсэхээ шалгана.

**Алхам 2:** Сонгож буй үгийн утга тохирох эсэхийг ярилцаарай. Тухайлбал: амтай, тэнэмэл, өөдгүй, худалч, **залхуу** гэх мэт үгсийг сонгон ярилцаж үзээрэй.

**Алхам 3:** Аль үг нь оновчтой эсрэг утга үүсгэж байна? Яагаад?

**Алхам 4:** Зохиож сурсан бол өөрөө зохиогоод үзээрэй.






1. Шүлгийг бадаг бадгаар нь ойлгож уншаарай
2. Өгөгдсөн зааврын дагуу ажиллаарай.

#### Алхам 1:

- 1-р бадагт юуны тухай өгүүлсэн болохыг нэг, нэг өгүүлбэрээр илэрхийлнэ.
- Бусдын хэлсэн санааг давхцуулж хэлэхгүй. (Найзынхаа хэлснийг сайн сонсоорой.)

#### Хархан духтай муур

**Эрэлхэг** барын шинжтэй  
 Эрээхэн **жаахан** биетэй  
 Мяндсан **зөөлөн** үстэй  
 Мярааж гэтэх дуртай  
     Соргог **босоо** чихтэй  
     **Шонтгор** борхон хамартай  
     Алаг булган дээлтэй  
     Ааш **хөөрхөн** муур  
**Хорт** хулгана харагдвал  
 Хумсаа гарган баздаг  
 Харайх дүүлэхдээ **гоц**  
**Хархан** духтай муур



#### Алхам 2:

- 1 ба 2-р бадгийг нэг нь уншаарай. Бусад нь сайн сонсоно.
- Асуултад хариулаарай  
     Хархан муур ямар чихтэй вэ?  
     Хархан муур ямар хамартай вэ?  
     Муурын ааш занг хэрхэн дүрсэлсэн бэ?

#### Алхам 3:

- 1,2,3-р бадгийг нэг нь уншаарай. Бусад нь сайн сонсоно
- Тодруулсан үгийг утгыг ярилцаад, тохирох асуултыг хэлээрэй.

#### Алхам 4:

- Тохирох үгийг нөхөөрэй.



.....хулгана харагдвал  
 Хумсаа гарган...  
 Харайх дүүлэхдээ...  
 ... духтай муур



Соргог ..... чихтэй  
 ... борхон хамартай  
 Алаг булган дээлтэй  
 Ааш ... муур



Алхам 5:

- Муурын онцлог шинжийг илэрхийлсэн үгийг ялган, эсрэг утгатай үгийг бичээрэй.

хөөрхөн	муухай

- Эсрэг утгай үгийг ашиглан өгүүлбэр зохион тайлбарлаарай.

Ааш **хөөрхөн** муур

Ааш **муухай** муур

...


- Үгийн сүлжээг бөглөн эсрэг утгыг олоорой.

Босоогоор:

- хөөрхний эсрэг утга
- босоо гэдэг үгийн эсрэг утга

Хөндлөнгөөр:

- жижиг гэдэг үгийн эсрэг утга
- зөөлний эсрэг утга
- аймхайн эсрэг утга



- Эсрэг утгатай үгийг ашиглаад шүлгийг хувиргаж бичээд үзээрэй.
- Хувиргаж бичсэн шүлгээ дараах шүлэг болон, анхны шүлэгтэй харьцуулаарай.
- Хэрхэн хувиргаснаа тайлбарлаарай.

**Халтархан муур**



Аймхай туулайн шинжтэй  
Аймаар том биетэй  
Махир хатуу хумстай  
Мярааж гэтэх дуртай




Хугархай хэвтээ чихтэй  
Монтгор борхон хамартай  
Хар булган дээлтэй  
Ааш муутай муур





1. Зургийг ажиглаарай. Бид юуны тухай үлгэр унших нь вэ? Яагаад?



## Заан оготно хоёр

(Монгол ардын үлгэр)

### Дүрслэн ярихдаа:

- Заан, оготно хоёрын гадаад төрхийг нь дүрслэн ярилцаарай.
- Эдгээр амьтад юугаараа ялгаатай вэ?
- Энэ амьтдын тухай ямар утгатай үлгэр байж болох вэ?
- Чи юу гэж бодож байна вэ? Бусадтай саналаа хуваалцаарай.

Эрт урьд цагт нэгэн хотын захад заан амьдардаг байжээ. Заан өдөр бүр голд очиж ус ууна. Тэнд нэгэн оготно амьдардаг байв. Заан ус ууж ханаад оготнын нүхийг усаар шүршиж сүйтгэдэг байлаа. "Миний өчүүхэн орон байрыг битгий сүйтгээч" гэж олон удаа гуйжээ. Гэвч тоохгүй сүйтгэсээр байлаа.

2. Ярилцъя: - Заан оготны нүхийг яагаад сүйтгэдэг байсан бэ?

- Оготно заанаас хариугаа авч чадах болов уу?

Нэгэн өдөр зааныг ирэхэд оготно: "Миний орон байрыг сүйтгэхээ болихгүй бол танд дайн зарлана" гэжээ. Заан энэ үгийг үл тоомсорлон инээд нь хүрч гэнэ. Оготно тэр хавийн ардуудад "Би заантай байлдана. Та нар эндээс нүү" гэж зарлажээ.

Гэтэл томчууд оготнын үгийг тоохгүй: "Энэ өчүүхэн оготно заантай яаж байлдах юм бэ?" гээд нүүсэнгүй. Харин жижиг ардууд нүүжээ.

Маргааш нь зааныг усанд ирэхэд оготно хамрын нүхээр нь орж улаан хоолой, уушги зүрхийг урж гарчээ. Заан орилон, цовхчин туйлсан ч оготныг дийлсэнгүй. Ийнхүү заан бяцхан оготнод ялагдаж, оготно санаа зовох зүйлгүй амар сайхан жаргаж гэнэ.

- Энэ үлгэр чамд ямар сургамж өгсөн бэ?

**Сургамж: Жижиг гэж басаж болохгүй, ухаанаар бүхнийг шийдэж болно.**

3. Уншихын өмнө дүрслэн ярьсан зүйл, үлгэртэй хэрхэн нийцэж буйг ярилцаарай.

4. Үйл явдлын дарааллыг бичээрэй.


- Эхлээд яасан бэ?
- Дараа нь ямар үйл явдал болсон бэ?
- Эцэст нь юу болсон бэ?

5. Үлгэрт оготно, заан хоёроор төлөөлүүлж хүний ямар зан аашийг өгүүлсэн байна вэ?

1. Үлгэрийг уншаад, зааврын дагуу сургамжит үлгэр бичээрэй. Үлгэр бичих дарааллаа сайн төлөвлөөрэй.



### Сургамжит үлгэр бичихдээ:



Эрт урьд цагт үнэг, чоно хоёр хөрш амьдарч байжээ. Нэгэн өдөр ойд зугаалж яваад хэсэг мах олжээ. Чонын олсон мах арай илүү том байлаа. Үнэг чонын олсон маханд шунаж, өөрийн олсон махаа нуугаад, чонын олсон махыг хулгайлахаар чонынд очжээ. Чоно аль хэдийн махаа идчихсэн сууж байлаа. Үнэг сэтгэлээр унаж, мах нуусан газраа иртэл байхгүй байлаа. Шууд л идэхгүй даанч яав даа гэж үнэг уйлав.

**Сургамж: Шунал ихэдвэл хоосон хоцорно.**

*сурагч С.Төгөлдөр*

2. С.Төгөлдөрийн зохиосон, засаж сайжруулсан үлгэр хоёрыг харьцуулаарай.

Эрт урьд цагт үнэг, чоно хоёр хөрш амьдарч байжээ. **Тэд хоол олж идэхээр ойгоор явж байгаад хэсэг мах олжээ.** Чонын олсон мах арай илүү том байлаа. Үнэг чонын олсон маханд шунаж, өөрийн олсон махаа нуугаад, **чонын олсон махыг хулгайлахаар сэмхэн чоныг дагав.** **Нэг харсан чинь:** Чоно аль хэдийн махаа **идчихээд, шогшиж явлаа.** Үнэг сэтгэлээр унаж, мах нуусан газраа иртэл байхгүй байлаа. Шууд л идэхгүй даанч яав даа гэж үнэг уйлав.

**Сургамж:**

- **Шунал ихэдвэл хоосон хоцорно.**
- **Муу арга, заль сайн үр дагавар дагуулахгүй.**


*сурагч С.Төгөлдөр*

1. “Би хэн бэ” оньсого таалцаж тоглоорой.



**Тоглоомын заавар**

1. Нэг сурагч үг, зурагтай малгай өмссөн байна.
2. Малгайтай сурагч: “Би хэн бэ?” гэж асууна.
3. Хүүхдүүд зураг ба үгийг ажиглаад оньсого хэлж таалгана.
4. Таавал дараагийн хүүхэд өөр зураг, үгтэй малгай өмсөж үргэлжлүүлнэ.



2. Оньсогыг тааж, хуулан бичээрэй. Хүүхдүүд хэрхэн ном уншиж байна вэ?

Ар талыг арлаад  
Өвөр талыг өвөрлөөд  
Өөд уруугүй шогших  
Тэр юу вэ?



3. Харилцан яриаг уншаарай.

- Хоёулаа номын сан орж ном уншъя.
- Би үнэмлэхгүй яах вэ?
- Үнэмлэхээ очоод нээлгэж болно. Төрсний гэрчилгээ, цээж зураг хэрэгтэй.

**Уншигчийн үнэмлэх нээлгэхдээ:**

- Төрсний гэрчилгээ
- Эцэг эхийн иргэний үнэмлэх
- Хоёр хувь цээж зураг, 1000 төгрөг авч очно.



**ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН**  
Уншигчийн үнэмлэх №032

Овог/нэр: **Б. БАТЖАРГАЛ**

Регистрийн дугаар: **УЦ 01261511**


Олгосон: **2010-01-01**

Хүчингэй хугацаа: 1 жил


1. Шүлгээ чанга, тод уншаарай.



## Номоо хайрлана



2. Бид хоёрын яриаг үргэлжлүүлээрэй.



3. Хоёулаа шүлгээ цээжилье. Цээжилснээ бадаг бадгаар нь уншъя.

4. Тэд шүлгээ цээжлээд үлгэр зохиохоор болтол үлгэр яаж зохиохоо мэдэх хэрэгтэй болов. Үлгэрийг уншаад хоёр найздаа туслаарай.

### Хаакий ном уншиж сурсан нь (үлгэр)

1. Хоёулаа нохойндоо зориулж үлгэр зохиож бичье. Үлгэр эрт урьд гэж эхлээд их сайхнаар төгсөж байна. Дагаад хийгээрэй.


Үлгэрээ хэрхэн бичихээ төлөвлөх:

- Хоёулаа юу бичихээ бодоод зуръя.
- Юу зурснаа дараа нь ярилцъя.
- Зурсан зургуудаасаа сонголт хийе.
- Сонгосон зургуудынхаа дор өгүүлбэр бичье.





2. Зурсан зургуудаа сонгон, тохиолдсон явдлаас санаа авч үлгэрээ зохиогоорой.




3. Бид гуравтай хамтарч уншаад, асуулт зохиогоорой.  
Үлгэр яаж эхэлж, яаж төгсөж байна вэ?

**Эрдэм сурсан нь**  
(Монгол ардын үлгэр)

Эрт цагт элээ, чогчиго хоёр эрдэм ном, дуу сурахаар алсын алсад явах болжээ. Нисэн ниссээр зорьсон газраа хүрч гэнэ.

Тэгээд ээрэм их талд нэгэн чулуун дээр сууж эрдэм сурч эхэлжээ. Гэтэл элээний нойр нь хүрээд унтаад өгчээ. Энэ хугацаанд чогчиго уйгагүй оролдсоор маш их зүйл сурч авчээ. Харин элээ гэнэт сэртэл эхээсээ төөрсөн нялх унаганы янцгаах дуу сонсогдож гэнэ. Элээ зөвхөн түүнийг л сурчээ. Ийнхүү чогчиго их зүйл сурч, олон янзаар дуугарч байхад элээ зөвхөн унага шиг дуугардаг болсон юм гэнэ.





4. Харин би бичсэн үлгэрээ Баясгаланд уншиж өглөө. Та нар бас найздаа уншиж өгөөд өөр юу бичиж болох тухай зөвлөгөө авч болно.

### Хаакий ном уншиж сурсан нь

Хаакий бол “Зуун нэгэн гөлөг” гэдэг үлгэрийн кинонд гардаг **үүлдэрийн** нохой. Манай байрны Баясгалан бид хоёрыг дагаж сургуульд ирээд, гадаа үлдэнэ. Түүний мөрөөдөл эрдэм сурах байлаа. Тиймээс өдөржин **сургуулийн** гадаа мөрөөдсөөр хэвтэнэ. Заримдаа биднийг цонхоор тэр харах гэж оролдоно. Баясгалан нэг өдөр **номноос** нохойн сургууль байдгийг мэдэв. Хаакий сургуульд орж ном уншиж сурсан. Бидэнд уншсан номоо **үзүүлж** бас найзуудынхаа тухай үлгэр уншиж өглөө.

5. Баясгалан миний үлгэрийг ингэж засаж өглөө.

### Хаакий ном уншиж сурсан нь


Хаакий бол “Зуун нэгэн гөлөг” **гэдэг** үлгэрийн кинонд гардаг **үүлдрийн** нохой. +шилмэл

Манай байрны Баясгалан бид хоёрыг дагаж сургуульд ирээд, гадаа үлдэнэ. Түүний мөрөөдөл эрдэм сурах байлаа. Тиймээс өдөржин **сургуулийн** гадаа мөрөөдсөөр хэвтэнэ. Заримдаа **тэр** цонхоор биднийг харах гэж оролдоно. Баясгалан нэг өдөр **номноос** нохойн сургууль байдгийг мэдэв. Хаакий сургуульд орж ном уншиж сурсан. Бидэнд уншсан номоо **үзүүлж** бас найзуудынхаа тухай үлгэр уншиж өглөө.

6. Дагаад хийгээрэй.

- Үлгэрт юуны тухай гарч байна вэ? Ярилцаарай.
- Хэн нэгэнтэй хамтарч үлгэр зохиогоорой.
- Зохиосон үлгэрээ найздаа уншаад, зөвлөгөө аваарай.
- Үлгэрээ засаад, хуулж бичээрэй.

*Хаакий ном уншидаг болов  
Хаакий бол “Зуун нэгэн гөлөг” үлгэрийн  
кинонд гардаг шилмэл үүлдрийн нохой.  
Манай байрны Баясгалан бид хоёрыг  
нохой дагаж сургуульд ирээд, гадаа үл-  
дэнэ. Түүний мөрөөдөл эрдэм сурах.*





7. Би Хаакид мэндчилгээ, Баясгаланд талархал бичмээр байна.

Бичихдээ:

- ✓ Хэнд, ямар учраас бичих болсноо бодно.
- ✓ Мэндчилгээ хэрхэн бичихээ төлөвлөнө.
- ✓ Төлөвлөсний дагуу бичнэ.

Талархлаа хэрхэн илэрхийлэх вэ?

- Утсаар ярина, мессеж бичнэ.
- Зурвас бичнэ
- Ил захидал илгээнэ
- Талархлын үг хэлнэ
- Хөгжим, утсандаа бичээд сонсоно



Талархал	Мэндчилгээ
Талархал бичихэд ямар үг сонгох вэ? Ярилцаарай.	Мэндчилгээ яаж төгсөх вэ? Ярилцаарай.

8. Сонгох үг, төгсгөлийн үгийг ашиглан талархал, мэндчилгээ бичээрэй.



9. Гэртээ ном уншаад номын тэмдэглэл бичье.

Зохиолчийн нэр	.....
Зохиолын нэр	.....
Хэвлэгдсэн он, газар	.....
Номын гол утга	.....
Номоос миний олж авсан зүйл	.....

## 1. Үлгэрийг уншаад, асуултын дагуу ярилцаарай.

### Алимны мод



Нэгэн хаан өөрийн шадар түшмэлийн хамт зугаалж явжээ. Тэгээд замдаа алимны мод тарьж буй өвгөнтэй таарав. Хаан өвгөнийг ёжилмоор санагдаж:

- Өвгөн гуай та, ийм настай хүн байж хэзээ энэ модныхоо жимсийг авна гэж суулгаж байгаа юм бэ дээ? Алимны мод ургаж гүйцээд жимсээ өгөх хүртэл та байж чадах юм уу? гэж ихэд шоолонгуй асуув. Өвгөн хариуд нь:

- Би өвөг эцгийнхээ тарьсан алимны модны жимсийг насаараа идсэн юмаа.

Тэр ч гэсэн тарьж байхдаа хүлээж байгаад иднэ гэж тариагүй л байлгүй дээ. Одоо миний тарьж байгаа модны ургацыг би биш гэхэд үр ач нар хураах юм. гэлээ.

Энэ үг хаанд маш их таалагдсан тул хаан өвгөнд хэтэвч дүүрэн алт өглөө. Өвгөн хариуд нь: “Хаантан та харж байна уу? Бусдын алимны мод олон жилийн дараа ургацаа өгч байхад миний алимны мод дөнгөж тарьж байхад жимсээ өгч эхэллээ шүү дээ” гэлээ. Хаантанд өвгөний энэ үг бүр их таалагдаж, дахин нэг хэтэвч алт өгөв. Өвгөн хариуд нь, “Хаантан минь ээ, бусдын мод жилд нэг удаа ургац өгдөг байтал миний мод ургаагүй байж хоёр ургац өглөө шүү дээ. Тэгэхээр хамгийн чухал нь хэзээ ургац авахдаа гол нь биш хийж бүтээн тарьж ургуулж байсан цагт заавал үр ашгийг нь харах л болно” гэв.

Хаан: - Хэрэв би энд дахиад жаахан азнавал таны мэргэн үгийг магтсаар алтгүй үлдэх бололтой. Өвгөн ах танд баярлалаа. Сайн сайхныг хүсье. Бид замаа хөөе дөө гэсээр хурдан гэгч нь шогшин алга болов.

#### Асуулт:

- Өвгөний цэцэрлэгт алимны шинэ мод л байсан уу?
- Хаан өвгөнийг яагаад шоолоход хүрсэн бэ?
- Өвгөний юу нь хаанд таалагдсан бэ?
- Өвгөн яагаад “Бусдын мод жилд нэг удаа ургац өгч байхад миний мод ургаагүй байхдаа жилд хоёр удаа ургац өглөө” гэж хэлсэн бэ?
- Өвгөн хаан хоёрын хэн нь ухаантай вэ? Яагаад?

## 2. Үлгэрээс талархлын үгтэй хэсгийг хуулж бичээрэй.

## 3. Хаанд өвгөний илэрхийлсэн талархлын үгийг уншаад, дуурайн бичээрэй.

Баярлалаа, хаантан минь. ....

Унасан морь чинь жороо болог .....  
Унага даага бүхэн чинь хурдан болог .....  
Ухаан санаа чинь сэргэлэн болог. ....

1. Шүлгийг уншаад, цээжлээрэй.
2. Дуурайн зохиогоорой.



Аавдаа би сайн хүү  
 Ээждээ би ажилсаг хүү  
 Анддаа би тусч хүү  
 Эх орондоо би үнэнч хүү

**БИ**

Аавдаа би .....  
 Ээждээ би .....  
 ..... би .....  
 ..... би .....

3. Доорх өгүүллэгийн баатар ямар хүү вэ? Ярилцаарай.

### Гарын үүг арилгасан нь

Багваахай алтан шаргал өнгөт цэцгээрээ нар өөд тэмүүлнэ. Болд багваахай таслан авч ишийг нь хумсаараа зүсэж амандаа зуугаад бээ-вэн, баа-ван, бээ-вэн, баа-ван гэж амандаа аялахад нь иш нь дугуйран махийж байв.

Осор өвгөн Болдын өөдөөс ирж яваа харагдлаа. Тэр өвгөн Болдтой уулзаж гар луу нь харснаа, ингэж хэллээ.

- Хөөрхөн хуруунууд нь ингэж ч “үүнд баригдах” гэж дээ. Үүнээсээ салж чадахгүй яваа юм уу? Чи барьж яваа багваахайныхаа ишийг шах! Шингэн цагаан шүүс гарна. Түүнийг үүн дээрээ түрхчихээр л үү чинь арилна! гэж өвгөн Осор хэлэв. Болд багваахайн ишийг шахаж үүндээ түрхсээр алга болгожээ. Болд өөрийн биеийн өвчинд тус болсон эмийн ургамал багваахайгаар тоглохоо больжээ. Харин түүнийг зурж зургийн уралдаанд оролцжээ.



*Д.Базаррагчаа*

4. Гарынхаа үүг хэрхэн эмчилсэн бэ? Тэр хэсгийг сонгон, хуулж бичээрэй.
5. Зурсан зургандаа танилцуулга бичиж суръя.
6. Өгүүллэгээ ашиглаад хүснэгтийг бөглөөрэй.



Сэдэв: ...  
 Нэр: ...  
 Нас: ...  
 Аймаг / хот/,  
 сум / дүүрэг: ...  
 Сургууль: ...  
 Анги: ...

1 үетэй 5 үг	2 үетэй 5 үг	3 үетэй 5 үг



7. Талархал уу, мэндчилгээ юу? Яагаад? Ярилцаарай.

Р.Оргилд

Чи өөртөө итгэлтэй байж чадлаа, зургийн уралдаанд оролцсонд баяр хүргэе. Амжилтаа ахиулаарай.

Зохион байгуулах комисс

2014-05-31



8. Уншиж ойлгоод, хуулан бичээрэй.


9. Онцолсон үгийг мөрд шилжүүлэхдээ хэрхэн шилжүүлэх вэ? Тайлбарлан бичээрэй.

Монгол хүний эрхэмлэх зүйл  
Чин бат журмыг үргэлж хитгээж явах  
Өвөг дээдсийн сургаалыг санаж шүтэх  
Үийн дээд ахийг буцааж хариулах  
Өгөх гээхийн хорвоог уурлан таниулах  
Үргэлж мэргэн намыг тогтоон тунгаах  
Чээгийг дээрд аргыг өргөн тэнхрүүлж явах


Ингэж шилжүүлнэ.

Учир нь


10. Зургийг ажиглаад үйл хөдлөлийн дарааллыг бичээрэй.







Өмдөө үргэлж эвхдэг Баясгалан хүү, цамцаа цэвэрхэн өмсдөг Хулан нарт мэндчилгээ бичих үү, талархал илгээх үү? Бичээрэй.



1. Зургийг ажиглаад, төсөөлөн бодоод, ярилцаарай.



2. Зөгийн тухай юу мэддэг вэ? Эргэцүүлээрэй.



3. Төсөөлөн бодож өгүүлбэр зохиогоорой.

Үлгэрлэвэл:

- Зөгий үүрээ өнгөөр нь ялгаж таньдаг.
- Зөгийн бал ..... тустай.
- .....

4. Өгүүллэгийг уншиж ойлгоорой.

### Модон торхтой бал

Баавгай модон торх хийж зөгийн үүрний дэргэд тавив. Алаг зөгийнүүд эрэн цэцгийн дэлбээн дээр өдөржин бэлчээрлэж оройхон үүрэндээ ирнэ. Үүрэн сархиагтаа амтат бал боловсруулж үүрнээсээ зөөж торхонд хийнэ.



Баавгай ойгоор тэнэж торхны мод аваад ирэхэд л амтат бал торхонд байдаг байжээ.

Баавгай амтат балаа идсээр зун намрыг өнгөрөөж, аглаг хөвч цасанд дарагдав. Баавгай ичээндээ оров.



Баавгай хэнз яргуйтай уралдан ичээнээсээ гарч аглаг ой, аглаг цэцэгт ургамал, амтат балын эзэн эрээн зөгийнүүдээ эрээд эрээд олсонгүй. Дээрэнгүй эздийн огтолсон ойн хожуул ёрдойно. Баавгай дэргэд нь нулимс дуслуулан зогсоно.  
“Амьтдын тухай өгүүллэг” номоос

### 5. Асуултын дагуу ярилцаарай.

- Баавгай ямар учраас зөгийн үүрний дэргэд модон торхоо тавьсан бэ?
- Зөгий амтат балаа юунаас цуглуулж, хаана боловсруулдаг вэ?
- Баавгай яагаад уйлсан бэ? Учир нь юу вэ?
- “Дээрэнгүй эзэд” гэж хэнийг хэлж байна вэ? Тэд юу хийсэн бэ?


### 6. Сэргээн санаад бичээрэй.

Өгүүллэгийн эхний өгүүлбэрт хоёр үетэй үг хэд байгааг тооцоолон үеэр зааглан бичээрэй.

Үлгэрлэвэл: баав|гай

### 7. Өгүүллэгээс зөгийтэй холбоотой өгүүлбэрүүдийг сонгож, хуулан бичээрэй.

### 8. Өнгөөр ялгасан хэсгүүдэд гарчиг өгөөрэй.



### 9. Баавгайн асуултад хариулаарай.

- Дээрэнгүй эзэд гэж хэн бэ?
- Тэднээс болж байгальд ямар муу үр дагавар гарсан бэ?



### 10. Цэгийн оронд тохирох үгсийг нөхөж бичээрэй. (Нөхөх үгс: хүмүүсийг, зөгийн үүр, амтат балаа, Баавгай)

Модыг тайрсан ..... дээрэнгүй эзэд гэж нэрлэсэн. Ой модыг сүйтгэснээс болж ..... алга болсон. .... алаг эрээн зөгий ..... санаад, нулимс дуслуулсан.

хэнз яргуй -  
ичээнээс гарах -

Миний бодлоор	Толь бичигт
.....	.....




### 1. Онъсогыг эргэцүүлэн бодож, таагаарай.



Тоншиход нь  
тон тон гэсэн  
дуу гардаг юм  
байна.

Тон тон тоншиход  
Толгой минь өвдөнө  
Тун ч хоосон байхад  
Гэдэс минь өлсөнө.  
*Тэр юу вэ?*



Тоншдог  
гэхээр шувуу  
юм болов  
уу?

### 2. Эхийг хурдан, ойлгож уншаарай.

#### Цолдоохой тоншуул болсон нь

Эрт урьд цагт цулгуй газрын хөрсөнд анх ногоо ургажээ. Дараа нь уулын араар цөөхөн мод ургажээ.

Жигүүртэн шувууд тэрхүү модыг сонирхон энд тэндээс хуран цугларч ирдэг болжээ. Мод ч олшрон ургасаар ой болж олон төрлийн шувууд нутагшжээ. Гэтэл нэгэн зун олон нарс гэнэт шарлан хатчихаж гэнэ. Модондоо хайртай шувууд гайхан ажиглаваас түүнийг нь үй түмэн өт хорхой идэн сүйтгэж байлаа. Хамаг шувууд мод юугаа хамгаалахаар хүч үзэлцэн тэмцэлдэв. Далавчаараа алгадах нь алгадаж, зарим нь савраараа базаж олонхыг нь устгажээ. Гэвч үлдсэн өт хорхой нь мод руу нүхлэн орж дотроос нь идэн сүйтгэсээр байв. Шувууд хоорондоо зөвлөлдөөд хурц, урт хошуутай зоригтой шувуудаар өт хорхой устгахад хамгийн сайн ажилласан нь цолдоохой байв. Сайхан моддыг өтнөөс аварсан цолдоохойд бусад шувууд “Тоншигч баатар” цол өгчээ. Үүнээс хойш “тоншуул” нэртэй болсон юм гэнэ.



*С.Надмид*

### 3. Асуултад хариулж ярилцаарай.

- Эрт цагт газрын хөрсөнд ямар өөрчлөлт гарсан бэ?
- Шувууд хаана ирж амьдарсан бэ?
- Ямар мод шарлан хатсан бэ? Яагаад?
- Шувууд хайртай модоо яаж хамгаалсан бэ?

### 4. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээд, үеэр зааглаарай (Нөхөх үгс: цолдоохойд, Тоншигч баатар, тоншуул).

Сайхан моддыг өтнөөс аварсан ..... бусад шувууд ..... цол өгчээ. Үүнээс хойш ..... нэртэй болсон юм гэнэ.

5. Эхийг гүйцээж бичээд, эхэд гарчиг өгөөрэй.

Хавар болоход би өвөөтэйгөө ойд аялахаар явлаа. Бид ойн гүн рүү явсаар ойн цоорхойд очив. Ойд шувууд жиргэх нь яг л хөгжим шиг сонсогдож байв. Гэтэл биднээс холгүй тон тон гэсэн чимээ .....

Ойг өт хорхойноос хамгаалдаг энэ шувууг “Ойн эмч” гэж нэрлэдэг юм гэж өвөө минь хэллээ. Тэгээд .....

6.


Асуултад хариулж бичье.

1. Асуултаа сайн ойлгоё.
2. Асуултын оронд ямар үг сонгохоо бодъё.
3. Цэвэр сайхан бичье.

- Хэзээ? анх ногоо ургасан бэ?  
.....
- Юу, хаана, цугларч ирсэн бэ?  
.....
- Ямар, мод хатсан бэ?  
.....
- Юуг, ямар, нэртэй шувуу өт хорхойноос цэвэрлэсэн бэ?  
.....

7. Хэсэг бүрт гарчиг өгөөрэй.

- Гарчгийг оновчтой сонгоё.



8. Өөрийгөө үнэлъе.

Хэсэг тус бүрт гарчиг өгч чадсан







1. Дараах үгсийг уншаад юуны нэр болохыг эргэцүүлэн бодоорой. ✓  
 Байгалийн үзэгдэл үү? ○ Улирлын нэр үү? ○

бороо

цас

солонго

зөөлөн  
салхи

2. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

- Үүл гарч тэнгэр дуугараад ..... орлоо.
- Борооны дараа нар гарч ..... татав.
- Зун хааяа ..... хацар илбэнэ.
- Энэ өвөл ..... бага орсон шүү.



### Солонго



Намираа борооны дараа  
 Нар таатай ээлээ  
 Өнгөрсөн борооны наагуур  
 Өнгийн солонго татлаа  
 Тэр солонгыг барих гэж  
 Тэнхээгээрээ бид хурдлав  
 Цагариг солонго харин  
 Цаашаа зугтан одов  
 Байгалийн сайхан солонгыг  
 Барьж болдоггүйг мэдэв  
*Р. Ядмаа*

#### Сэргээн санаарай:

- Эхлээд үйл явдлын дарааллыг сайн уншиж ойлгох
- Хоёр хоёр мөрөөр нь уншиж цээжлэх
- Дараа нь дөрөв дөрвөн мөрөөр цээжлэх
- Шүлгийг бүхэлд нь чанга тод уншиж сурах


3. Асуултын дагуу ярилцаарай.

- Ямар үед солонго татдаг вэ?
- Хүүхдүүд юу мэдэж авсан бэ?
- Солонгыг барьж болдоггүйн учир юу вэ? Яагаад?

4. Шүлгийг хуулахдаа үеэр зааглан бичээрэй. Үлгэрлэвэл:

На|ми|раа бо|роо|ны да|раа  
 Нар .....

5. Солонго шүлгийг дуурайлган хүүхдүүдийн зохиосон шүлгийг уншаад 4 мөрт шүлэг зохиогоорой.



**Солонго**

Зөөлөн борооны дараа  
Өнгийн солонго татав.  
Зургийн дэвтэр аваад  
Өнгийн солонго зурав.

Сурагч: Б.Номинжин

**Солонго**

Нартай бороо ороход  
Нуман солонго татав.  
Нумалсан тэр солонгыг  
Найзтайгаа хамт сонирхов.

Сурагч: Б.Тэнүүн


**Солонго**

.....

.....

.....

.....



6. Ажиглаад ярилцаарай.

Солонго татав.  
Өнгийн солонго татав.  
Тэр солонгыг Солонго бид хоёр сонирхов.

7. Өгүүлбэр зохиогоорой.

**Гэрэл**

		.		
			.	
				.

8. Асуултаар өгүүлбэр зохиож бичээрэй.

- Хэн? юу? яав?
- Хэн? хэн? юу? яалаа?
- Хэн? хэн? ямар? юу? яасан?

9. Өөрийгөө үнэлээрэй. 😊 😐 😞

1. Дөрвөн мөрт дуурайж зохиож чадсан	
2. Дөрвөн мөрт дутуу зохиосон	
3. Дөрвөн мөрт зохиож чадаагүй	



**Багшийг сонсоод бичээрэй.**

Алаг азарга ч алаг адуундаа алга  
Алга болсон алаг үрээ ч алга



## Дуурайдаг Дугариг цэнхэр Тэр юу вэ?



- “Дуурайдаг дугариг цэнхэр” гэдгийг чи юу гэж тайлах вэ?
- Үгүй ээ, сайн бод л доо. Тэр хоёр чинь дугуй юм уу?
- Дөхөж байна. Яг тэгж харагддаг юу байж болох вэ?
- Зүйтэй, чи таачихлаа.
- Дөрвөн хөлтэй гэхээр...

- Дуурайдаг гэхээр, сармагчин юм уу? Эсвэл тоть юм уу?
- Аа, нээрээ тийм шүү дээ. Тэгэхээр энэ чинь хүн юм уу?
- Өө, тэгвэл нүүрээ хардаг гэхээр толь мөн үү?
- Нэг малгайтай дөрвөн хүн гэхээр юу байх вэ? Одоо чи таа.



1. Өөрсдөө оньсого сонгоод харилцан яриаг үргэлжлүүлээрэй.
2. Харилцан яриаг дэвтэртээ бичээрэй.

### Ярилцахдаа:

- Үйл хөдлөл, харц, дууны өнгөө тохируулах.
- Биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх.
- Бүтэн өгүүлбэрээр ярих.

### Бичихдээ:

- Дэвтрээ зөв тавьж, үзгээ зөв бариад, зөв суугаарай.
- Өгүүлбэр том үсгээр эхэлнэ гэдгийг санаарай.
- Хүний хэлсэн үгийн өмнө (-) бичээд, шинэ мөрнөөс бичнэ.
- Асуусан утгатай өгүүлбэрийн эцэст (?) бичнэ.
- Хүүрнэсэн утгатай өгүүлбэрийн эцэст (.) бичнэ.

3. Оньсогыг тайлж уншаад харилцан яриа болгон бичээрэй.

## Ажилсаг охин

- Цэцэгээ охин “Дуурайдаг дугариг цэнхэр”-т нүүрээ харчхаад “Нэг малгайтай дөрвөн хүн”-ий ард суув. Тэгээд “Мэддэгт мэргэн цоохор, мэддэггүйд эрээн цоохор”-оо дэлгэв. Дараа нь “Ангаг цангаг зантай, цагаан газар явдалтай”-г авлаа. Ингээд “Цагаан талд хар үр тарьж, хар үрээс хамаг ухаан”-ыг гаргаж эхэллээ.

Д.Мягмар

4. Тайлсан оньсого чиний төсөөллөөс ямар байв.

## СОНСГОХ ЗОХИОЛ: ШУВУУД



1. “Шувууд” эхийг анхааралтай сонсоорой (Багш эхний хэсгийг уншиж өгнө).

2. Сонсож, ойлгосноо ярилцаарай.

- Хаана, хэзээ, ямар үйл явдал болсон бэ?
- Хүү ямар зантай хүүхэд байв?
- Өвөө нь дэгдний тухай юу гэж хэлэв?
- Хүү юуг ойлгож авсан бэ?

3. Асуулт зохион харилцан ярилцаарай.

- Намрын улирлын тухай өгүүлсэн хэсэгт:

асуулт	хариулт
Намрын улирлыг юу гэж дүрсэлсэн бэ? .....	Намар болж, шувууд сүрэглэн ниснэ. .....

- Байгаль дэлхийн тухай өгүүлсэн хэсэгт:

асуулт	хариулт

- Өвөө нь хүүгээ өхөөрдөн ухааныг нь сорьсон хэсэгт:

асуулт	хариулт

- Хүүгийн хариултын тухай

- Хөх дэгдийн тухай

4. Үйл явдлыг дарааллаар нь жагсаан бичээрэй.

5. Зохиолын үйл явдалд тулгуурлан “Ертөнцийн гурван хөх”-ийг дуурайн бичээрэй.

Уудам дэлхийн тэнгэр нэг хөх  
Унтрах галын дөл нэг хөх  
Урсах голын ус нэг хөх



үхэр дэгд



мөнгөн дэгд

Талд ..... дэгд .....  
..... ургадаг .....  
.....

6. “Хөх дэгд, хөхүүл ханиад” гэсэн үгсийн утгыг толь бичиг ашиглан тайлбарлаарай.

## Сонгох зохиол: ШУВУУД



Намар цаг болж шувууд сүрэглэн ниснэ. Өргөн голын сав газраас дэгд түүх өвгөн хүү хоёр шувуудыг харан хэсэг зуур амсхийв. Хүү:

- Өвөө энэ хөх дэгдээр яадаг юм бэ? гэж сониучхан зангаар учрыг нь мэдэх юмсан гэсэн харцаар ширтэн асуув. (Зогсолт 1)

Өвгөн толгойгоо дээш өргөн:

- Тэр олон шулганах шувуудыг харав уу? Хөөрхий энэ амьтад, хөх дэгд бүгдээрээ л байгаль дэлхий минь юм шүү дээ гэхэд хүүгийн нүд улам шимтэнгүй ширтэж:

- Нэг нь шувуу нөгөө нь ургамал биз дээ? Та надад хөх дэгдийн тухай яриач гэв. Өвгөн юм бүхний учрыг мэдэх гэж шулганан байдаг хүүгээ өхөөрдөн:

- Чи миний асуултад хариулбал би хэлье гэв. Хүү:

- Тэгье, би чадна гээд чихээ тавин чагнав. (Зогсолт 2)

Өвгөн:


- Хэсэг шувууд нисэж яваад амрахаар болж хэсэг модон дээр очжээ. Тэр шувууд мод бүр дээр нэг нэгээрээ суувал нэг шувуу илүү гараад байв. Харин мод бүр дээр хоёр хоёроороо суусан чинь нэг мод илүү гарчээ. Хэдэн шувуу, хэдэн мод байсныг миний хүү хэл дээ гэв (Зогсолт 3)

- Хүү бодож, бодож нэгээр илүү тэгш тоо, нэгээр дутуу сондгой тоо хэлжээ (4 шувуу, 3 мод) өвөө хүүгийн толгойг илж: (Зогсолт 4)

- Ханиад хүрэхэд буцалгаж ууна, халуурч бүлээрэхэд хандалж ууна гэдгийг мэдлээ.

- Дэлгэр зуны тавиун цагт дэгд хаана ургадгийг ч мэдлээ хэмээн өвөөдөө талархав.

## ХӨГЖӨӨНТЭЙ ТУУЖААС



Хүүхдүүд хонь ноосолж байлаа. Тэд дэлгэцэн дээр хонио унагаад хөндийрсөн ноосыг нь хайчаар авч байв. Хэдэн хүүхэд хашааны гадаа ямаа самнана.

Банзай нэг ямаа эвэрдэж аваад шууд л хүзүүн дээр нь гараа тавьснаа сахлыг нь илж үзэв. (Зогсолт)

Тэр ямааны урт шодон сахал Банзайд ихэд таалагдсан бололтой хэдэнтээ илж, гараараа самнах мэт оролдож байснаа хайчаа авч, ганц тасхийлгэн хайчилж орхив. Сүр сүлдгүй мухар толгойтой болсон ямаа гомдсон мэт чангаар майлжээ.

- Хүүе чи яаж байгаа юм бэ? гэж ямааг хараад Баатар дуу алдлаа.

- Хайчилж байна, энэ муу ямаанаас нэг ч ширхэг үс үлдээхгүй хяргана даа гэж Банзай ихэмсгээр хамраа шантайлгав.

- Чи мал мэддэггүй хүн үү? Хэзээ монгол хүн ямааны сүр чимэг болсон сахлыг авч байлаа гэж нэг ах зэмлэв.



Банзай толгойгоо маажаад:

- Их үс байхаар нь авсан юм... гэж өчлөө.
- Хялгас гээч гэж Цэдэн засан хэлэв.
- Чи ер нь аль нутгийн хүүхэд вэ? гэж өнөөх ах

асуужээ.

- Шохойн үйлдвэрийн төвд амьдардаг... гээд Банзайгийн царай нь улайв.

- Мал мэдэхгүй ээ, мөн тусгүй. Энэ ямаа сахалгүй, мухар толгойгоо одоо яана? Бусад ямаа хажиглана даа гэж ах ууртай өгүүлэхэд өнөөх ямаа “Нээрээ сахалгүй, би яана аа”.. гэх шиг гомдолтой майлж байлаа.

Д.Гармаа





## ЗУРАГТ ТАЙЛБАР ТОЛЬ



а. Зурагт тайлбар толь



б. Тайлбар эх бүхий толь



Тайлбар эх бүхий толь



Зурагт тайлбар толь

## ҮГИЙН ТАЙЛБАР ТОЛЬ

### А

авга – аавын талын төрөл  
ан – юмны хагарч үүссэн цав  
ана мана – хүч тэнцүү  
ахрын эсгий – хонь хяргасны дараа  
ахин ургасан ноосоор хийсэн эсгий

### Б

бараа бологч – дагалдагч хүн  
бариа – уралдаж ирсэн морийг барих газар  
бахархал – сайн давуу талыг хүндэтгэх  
буурь – гэр барьсан ором  
борог өвс – шарлаж унасан өвс  
борог мах – өөхгүй мах  
борго – нохой ээрч хоргоон хуцах  
бөжин – туулайн үр төл  
бэлтрэг – чонын үр төл

### Г

гараа – уралдаан эхлэх эхний шат  
гавар – үнэгний үр төл  
гилэх – туух  
гөлөг гинших – сул дуугарах  
гөлчгий – хулганы үр төл  
голох – үл тоомсорлон орхих

### Д

догдлох – баярлах хөөрөх  
дэвжээ – шагай тоглоход дэвссэн зүйл

### З

зогдор – хүзүү хоолойд ургасан урт үс  
хялгас  
зоргодос – мушгирсан нимгэн мод

### М

матмал – махийлгаж матаж хийсэн зүйл  
мэргэжил – эзэмшсэн мэдлэг

### Н

нагац – ээжийн талын төрөл садан

### О

онх – үзүүр талаараа буусан шагай

### С

суваг шуудуу – ус урсгахаар ухсан жалга  
сүүдэр – газар туссан бараан дүрс  
сүүн хүчлийн өсгөвөр - тараг исгэдэг хөрөнгө

### Т

талын шувуу – талд амьдардаг шувуу  
тэмээ туйлна – ачаа хөсгөө хөглүүлнэ  
тэнгэр задрах – тэнгэрийн байдал ая тавгүй болох

### Ү

үмх мах – ганц үмхэх хэмжээтэй

### Х

хорилдой – хэрэмний зулзага  
хөлөг – шатар тоглох хүснэгт  
хэнз хурга – хожуу гарсан төл мал  
хэнз яргуй – оройтож ургасан яргуй

### Ц

цөөрөм – хур тунадаснаас тогтсон урсгалгүй усан сан